

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 24-НИЙ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-53

1.Байгаль орчны салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөтийн сайдын мэдээлэл сонсох	4-53
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж
ахуйн байнгын хороодын 12 дугаар сарын 24-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хамтарсан хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 42 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 52.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 20 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаттар” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бат-Эрдэнэ, С.Лүндэг, З.Мэндсайхан, У.Отгонбаяр, Д.Энхтуяа;

Чөлөөтэй: Д.Бум-Очир, Ж.Золжаргал, Б.Пунсалмаа, Б.Тулга;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганбаатар, Д.Пүрэвдаваа.

Нэг.Байгаль орчны салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, сайдын зөвлөх П.Батхишиг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ү.Энхтайван, мөн газрын мэргэжилтэн С.Амартүвшин, Нэгдсэн бодлогын газрын дарга Х.Мөнхзул, Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга П.Цогтсайхан, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн захирал Ж.Чойханд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Х.Хэрлэн нар байлцав

Байгаль орчны салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа танилцуулав.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Б.Уянга, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, Н.Наранбаатар, Ж.Батжаргал, Ц.Идэрбат, Б.Бейсен, Д.Батлут, Д.Үүрийнтуяа, Д.Батбаяр, Г.Очирбат, Б.Найдалаа, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, сайдын зөвлөх П.Батхишиг, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Ойн газрын дарга Б.Оюунсанаа, Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Ү.Энхтайван, Нэгдсэн

бодлогын газрын дарга Х.Мөнхзул, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн захирал Ж.Чойханд нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Лувсанжамц, Д.Жаргалсайхан, П.Мөнхтулга, С.Замира, М.Мандхай, Ц.Идэрбат, Б.Бейсен, М.Ганхүлэг, Д.Үүрийнтуяа, Ж.Золжаргал нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Байгаль орчны салбарт олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх мэдээлэл сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 00 минут үргэлжилж, 42 гишүүнээс 29 гишүүн хүрэлцэн ирж, 69.0 хувийн ирцтэйгээр 18 цаг 20 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 12 дугаар сарын 24-ний өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан ” танхим 15 цаг 20 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Энэ өдрийн хуралдааны ирцийг би танилцуулъя аа. Ингээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо 2 хамтарсан хуралдаан хийж байгаа.

Хэлэлцэх асуудал бол Монгол оронд хэрэгжиж байгаа олон улсын яг Байгаль орчинтой холбоотой ХХАА, ЖДҮ-лэлтэй холбоотой төсөл хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл сонсоно.

Олон 100 сая долларын тухай ярина аа. Үр дүнгийн талаар ярина.

Ингээд ирцийн мэдээллийн явцыг танилцуулъя. Сайнхүүгийн Ганбаатар ирсэн байна. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо Очирбатын Амгаланбаатар ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо Жигжидийн Батжаргал ирсэн байна Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Дамдинсүрэнгийн Жаргалсайхан ирсэн байна, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, бас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд хамт байгаа. Ингээд Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Мэндбаярын Мандухай гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, 7 дугаар тойрог Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо мөн Аж үйлдвэрлэлийн бодлогын байнгын хорооны гишүүн, Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн ирсэн байна Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Болдын Уянга гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо мөн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд хамт байдаг аа. Ингээд нийт гишүүдийн ирц 15 гишүүн ирсэн байна. Одоо 6 гишүүн дутуу юу 7 гишүүн байвал болчих гээд байдаг. Гишүүд ирцдээ ороод Монголын ард түмэнд нэн хэрэгцээтэй байгаа энэ мэдээллүүдийг сонсож дүгнэлт хамт гаргана гэж бодож байна аа. Гишүүд ирж байна. Буланы Бейсен гишүүн ирсэн байна. 3 дугаар тойрог. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга. Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Идэрбат гишүүн ирсэн байна, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүн ирсэн. Ганхуяг гишүүн ороод ирлээ.

Ингээд Аж үйлдвэржилтийн бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хуралдаан эхэлснийг мэдэгдье.

Та бүхэнд жанжин Д.Сүхбаатар танхимд хуралдаанаа эхлүүлж байна аа. Бейсен дарга бид 2 хамтарч хуралдааныг удирдаж даргална. Ирцийг та бүхэндээ танилцуулъя.

Буланы Бейсен гишүүн ирсэн байна 3 дугаар тойрог, Сайнхүүгийн Ганбаатар ирсэн байна. Жагсаалтаар гэхихсэн байна шүү дээ энэ чинь, болж байна уу. Очирбатын Амгаланбаатар 2 дугаар тойрог ирсэн байна, Жигжидийн Батжаргал гишүүн ирсэн байна 5 дугаар тойрог, Дамбын Батлут гишүүн ирсэн байна 4 дүгээр тойрог, Пүрэвийн Батчимэг гишүүн ирсэн байна. Ирцэд орсон. Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн 1 дүгээр тойрог ирсэн байна. Сонгобайн Замира гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн 6 дугаар тойрог ирсэн байна. Ганзоригийн Лувсанжамц гишүүн ирсэн байна. Мэндбаярын Мандухай гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Мөнхбат гишүүн ирсэн байна. Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн 1 дүгээр тойрог ирсэн байна. Бадрахын Найдалаа гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна 7 дугаар тойрог. Ганбатын Очирбат гишүүн ирсэн байна. Болдын Уянга гишүүн ирсэн байна. Чинбүрэн гишүүн энд ирцдээ орсон байгаа шүү. Ингээд юу ирцэд ороогүй хүмүүс бүгд байгаа биз.

Ингээд 52.4 хувиар ирц бүрдсэн хуралдаан эхэлснийг мэдэгдье ээ. Ингээд эрхэм гишүүд та бүхэнд Байнгын хороодын гишүүдийн олонх нь хүрэлцэн ирж ирц 52.4 хувьтай бүрдсэн тул Аж үйлдвэржилтийн бодлогын болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдааныг эхэлснийг мэдэгдлээ.

Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулсан. Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэх асуудлаа би та бүхэнд танилцуулъя аа. Байгаль орчны салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа аж төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсоно.

Ингээд хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Хэлэлцэх асуудал дээр Хөдөө аж ахуйн байнгын хорооны санал байсан боловч Хөдөө аж5 ахуйн яамнаас даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар яриад хойшлуулсан байгаа шүү. Ж.Энхбаяр сайд. Дархан хотод удирдах ажилтны зөвлөгөөн болоод хойшлогдож байгаа юм байна аа. Ингээд хэлэлцэх асуудалд нэмэх санал байхгүй бол хэлэлцэх асуудлаа баталъя.

Ингээд та бүхэнд ажлын хэсгээ танилцуулъя аа. Байгаль орчны салбарт олон улсын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилт явц, үр дүнгийн талаарх Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын мэдээллийг сонсох.

С.Одонтуяа Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Батхишиг сайдын зөвлөх ирсэн байна. Оюунсанаа Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дарга, Оюунсанаа ирсэн байна уу? Энхтайван, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Энхтайван ирсэн байна. Мөнхзул Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Нэгдсэн бодлогын газрын дарга, Цогтсайхан Байгаль орчин,

уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежментийн хэлтсийн дарга, Амартүвшин Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны гадаад хамтын ажиллагааны газрын мэргэжилтэн, Чойханд Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвийн захирал. Энэ нөхдүүд маань ирсэн байна. Ингээд хэлэлцэх асуудлыг мэдээллийг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа танилцуулна. Одонтуяа сайдад микрофон өгье.

С.Одонтуяа: Сайн байцгаана уу эрхэм хүндэт Байнгын хорооны гишүүд ээ. Өнөөдөр бид Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн талаар ярилцах болно доо. Байгаль орчин уур амьсгалын салбарт 28 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Мөнгөн дүнгээр 182.4 сая ам.долларын санхүүжилттэй.

Байгаль орчны мэдээллийн санд байгаа мэдээллээр 1998 оноос хойш 2023 оныг хүртэл үзэглэж батлан хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд 107 байна. Нийт дүнгээрээ 360 орчим сая ам.доллар байгаль орчин уур амьсгалын салбарт зарцуулагдаад байна 1998 оноос хойш. Үүнээс онцолбол ТХГН-т нийт санхүүжилтийн 3-ны 1 нь ноогдож байна. Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлээр 24 хувь нь зарцуулагдсан байна. Олон улсын Байгаль хамгааллын чиглэлийн донор байгууллагуудын санхүүжилтийн гол сонирхол нь урт хугацаанд тогтвортой үр өгөөж өгөх хамгаалагдсан газар Байгаль хамгааллын арга хэмжээг санхүүжүүлэхийг илүүд үздэг нь ТХГН-т хамгийн их санхүүжилт хийгдэж байгаагийн нэг шалтгаан болно оо.

Дараагийн слайдыг та бүхэн хараарай. 2024 оны байдлаар Даян дэлхийн Байгаль орчны сан, БНСУ, ХБНГУ, Уур амьсгалын ногоон сан, Европын холбоо, Япон Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудын санхүүжилтээр 28 төсөл хэрэгжиж байна аа. Эдгээр төслүүд нь цөлжилт Тусгай хамгаалалттай газар нутаг, уур амьсгалын өөрчлөлт, химийн хортой бодис, ногоон санхүүжилт, байгалийн гамшиг, усны нөөц, ой, хог хаягдал зэрэг олон чиглэлийг хамарч байна. Санхүүжилтийн үндсэн эх үүсвэрээр нь авч үзвэл 27 төсөл хөтөлбөр нь буцалтгүй тусламж, техник туслалцааны хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байна. Зөвхөн нэн хөнгөлөлттэй зээлээр нэг хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй төсөл байна аа. Тэр нь АХБ-ны 38 сая ам.долларын санхүүжилттэй хөнгөлөлттэй зээл бөгөөд тусгай хамгаалалттай газрын тогтвортой хөгжилд зарцуулагдаж байна. 2025 оноос Соёл, спорт, аялал жуулчлалын яамруу шилжүүлэхээр шийдвэр гарсан. Нөгөө бүтцийн өөрчлөлтөөр.

Дараагийн слайдыг та бүхэн харж байна. Монгол Улсын хувьд Байгаль орчин уур амьсгалын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн үндсэн санхүүжилтээр Даян дэлхийн Байгаль орчны сан бид жеф гэж ярьдаг. Уур амьсгалын Ногоон Сан Жи Си Эф, Европын Холбоо, ХБНГУ-ын Засгийн газар Нечер Консерванси олон улсын байгууллага голлох үүрэгтэй оролцож байна. 2024 оны байдлаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн 64 буюу 3-ны 2-ыг нь Жеф Герман улсын Засгийн газар Нечри Консервенси олон улсын байгууллага санхүүжүүлж байна аа. Хувийн хэвшлээс Рио Тинто компани нь томоохон төсөл хэрэгжүүлж байгааг дурдах нь зүйтэй.

Дараагийн слайд тавья. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны шууд хэрэгжүүлж буй 2 л төсөл байна. Төслийг хэрэгжүүлэгч байгууллагуудаар авч үзвэл НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр нийт 5 төсөл хэрэгжүүлж байна. Харин НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага 4 төсөл хэрэгжүүлж байна. Түүнчлэн Нечри Консервенси олон улсын байгууллага, Ти Эн Си нь 4 хөтөлбөр хэрэгжүүлж байна

аа. Санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч байгууллагууд гэдэг нь ялгаатай бөгөөд олон улсын санхүүжүүлэгчид нь тодорхой нарийн шалгуур хангасан аккредитед агентлаг байгууллагуудаар дамжуулан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг ээ. Жишээлбэл Монгол Улсад хэрэгжиж буй Байгаль орчны хамгийн олон төслийг санхүүжүүлж буй Даян дэлхийн Байгаль орчны сан буюу Жефф гэхэд НҮБ-ын түүний төрөлжсөн байгууллагууд тэргүүтэй 18 олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудаар дамжуулан санхүүжилт хийдэг бөгөөд тухайн улсын Засгийн газартай зөвшилцөж бодлогын дэмжлэг авах байдлаар хамтран ажилладаг. Өнөөдрийн байдлаар 2028 он хүртэл 10 жилийн хугацаанд буюу 2018-аас 2028 оны хооронд эдгээр төслүүдээр дамжин 170 орчим сая ам.долларын дотогшлох урсгал бий болж байна. Үүнийг эрчимжүүлэх хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай.

Энэ төслүүдийн зарим нь тухайн улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх нөхцөл тавьдаг тул Монгол Улсын Засгийн газраас ойролцоогоор 100 сая ам.долларын шууд бус санхүүжилтийг оруулах үүрэг хүлээсэн. Иймээс улсын болон орон нутгийн төсвөөс Байгаль хамгаалалд зарцуулж буй хөрөнгийн хэмжээг дахин авч үзэх, сайтар судлах шаардлагатай юм аа. Эдгээр төслүүдээс 2028 он хүртэл ямар хэмжээний санхүүжилт хийх боломжтойг нарийвчлан тодорхойлохоор ажиллаж байна. Түүнчлэн өнгөрсөн 4 жилийн хугацаанд жил бүрээр төслүүдийн санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулан харвал хангалттай биш байна аа. Яамны зүгээс шалтгаалж байгаа асуудлууд, яамны дэмжлэгтэйгээр сайжруулж болох асуудлуудыг тодорхойлж байгаа төслүүд удаашралтай хэрэгжиж байгааг эрчимжүүлэх шаардлагатай байна. 2024 оны байдлаар хэрэгжиж буй 28 төслийн хувьд авч үзэхэд Хөвсгөл, Завхан, Ховд, Баянхонгор, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад 2-оос 5 төсөл хэрэгжиж байна. Төслийн санаачилга гараад эцэслэн батлагдаж хэрэгжих хүртэл ойролцоогоор 2 жилээс багагүй хугацаа зарцуулагдаж байгаа тул 2024 оны байдлаар хэрэгжиж эхэлж байгаа төслийн үндсэн концепц хэрэгжих байршил нь 2022 онд түүнээс өмнөх батлагдсан болохыг дурдах нь зүйтэй. Төслийг хэрэгжүүлэхдээ засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хил хязгаарт тулгуурладаггүй бөгөөд байгалийн бүс, бүслүүр, эко системийн хил хязгаар, хамгаалалтын дэглэмийн нөхцөлүүдэд тулгуурлан тогтоодог нийтлэг шинж чанартай. Төслүүдийн санхүүжилтийн дийлэнх нь Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментэд чиглэж байгаа нь 53 хувь нь үүнээс 97.5 сая ам.доллар. Байгаль хамгаалал биологийн төрөл зүйлийг хамгаалах нь нэн тэргүүний зорилт болохыг харуулж байна. Гэсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлт 16 хувь буюу 29.1 сая ам.доллар, химийн хортой бодисын аюулд 6 хувь, 11.9 сая ам.доллар, цөлжилт 8 хувь, 14.6 сая ам.доллар зэрэг бусад чухал асуудлуудыг орхигдуулахгүй байхад анхаарч байна. Ойжуулалт, ойн салбарын шинэчлэл, цөлжилтийн чиглэлд одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 8 хувь буюу 14.6 сая ам.долларын 3 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн чиглэлд одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 16 хувь буюу 29.1 сая ам.долларын 6 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна.

Химийн хорт аюултай бодисын чиглэлд одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 6 хувь буюу 11.9 сая ам.долларын 3 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Байгалийн нөөц, биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлд одоо хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 7 хувь буюу 12.1 сая ам.долларын 5 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Салбарын чадавх бэхжүүлэх чиглэлд одоо хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 10 хувь буюу 18.1 сая ам.долларын 6 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна. Төслүүдийн

санхүүжилтийн дийлэнх нь ТХГН-ийн менежментэд чиглэж байгаа нь 53. Төслүүдийн санхүүжилтийн дийлэнх нь ТХГН-ийн менежментэд чиглэж байгаа нь 53 хувь буюу 97.5 сая ам.доллар. Байгаль хамгаалал, биологийн төрөл зүйлийг хамгаалах нь нэн тэргүүний зорилт болохыг харуулж байна. Нөгөөтээгүүр санхүүжүүлэгч байгууллагууд хууль, эрх зүйн орчин нь тодорхой, тогтвортой хэрэгжих, суурь төсөлд хөрөнгөө зарцуулах сонирхолтой байгаа нь ч үүнтэй хамааралтай. Монреалын дэлхийн биологийн олон янз байдлын хүрээг хэрэгжүүлэхээр нэгдсэн бөгөөд 30, 30 гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Өөрөөр хэлбэл 2030 он гэхэд газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалтад авах, манай улс 30 жилийн өмнө газар нутгийнхаа 30 хувийг хамгаалах энэхүү зорилгыг анх дэвшүүлж хэрэгжүүлж байсан бол өдгөө дэлхий даяар тус бодлого хэрэгжиж байна аа. Цаашид Байгаль хамгаалах уур амьсгалын чиглэлийн санхүүжилтийн хамгийн том орон зай нь хамгаалагдсан газар, тусгай хамгаалалттай газар байх төлөвтэй байна аа.

Ингээд төгсгөлд нь Монгол Улс нь Байгаль орчны төслүүдээ хэрэгжүүлэхэд гадаадын санхүүжилтийг цаашид ч татах шаардлагатай. Ингэхийн тулд олон улсын байгууллагуудтай хамтран санхүүжилт хийх, кофайненсинг шаардлага үүсэж байна аа. Ингэснээр санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлж төслийн хэрэгжилтийг сайжруулах боломжтой. Төсөл хөтөлбөрүүдийн үр ашгийг сайжруулахын тулд үр дүнд суурилсан тогтолцоог нэвтрүүлэх, хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг бодитоор хэмжиж, зорилгодоо төслүүдийн хяналт, шинжилгээ үнэлгээний нэгдсэн тогтолцоог шинэчлэх, Сангийн яамны мэдээллийн сантай бүрэн нийцүүлэх, Байгаль орчны салбарт санхүүжилтийг хуваарилахдаа зөвхөн нэг чиглэлд төвлөрөхгүй, харин цөлжилт, уур амьсгалын өөрчлөлт, химийн хортой бодис зэрэг бусад чухал асуудлууд ч гэсэн анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Ганбаатар: Одонтуяа сайдад баярлалаа. Мэдээллээ танилцуулсанд баярлалаа. Ингээд мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү? Жаргалсайхан гишүүн, Батлут гишүүн байна. Ингээд Үүрийнтуяа гишүүн ороод ирсэн байна. Үүрийнтуяа гишүүнээр нэрсийг тасаллаа. Ингээд Лувсанжамц гишүүн асуулт асууна уу?

Г.Лувсанжамц: Энэ өдрийн мэндийг хүргэе. Их хэрэгтэй чухал төсөл хөтөлбөрүүд 28 төсөл дээр, 182 сая долларын төсөл хэрэгжүүлж байгаа гээд одоо хэрэгжүүлж байсан ажлууд сургалт ямар байдлаар зохион байгуулсан, хэдэн хүн хамрагдсан, цаашдаа ямар ажил хэрэгжүүлэх гэж байгаа гээд чухал агуулгуудаа тавьсан байна. Тараасан материал дээр нэг маш том алдаатай нэг зүйл байгаад байна л даа. Энэ дээр 4 багана дээр дугаарыг нь тавиад төслийн нэр тавиад, ерөнхий мэдээлэл тавиад, тэгээд явц үр дүнг тавиад энэ бид нар үр дүн үр нөлөөгөө хэмжих ёстой. Яг энэ төслүүдийг хэрэгжүүлээд бид нар яг ямар үр дүнд хүрээд байна? Ахиц гарсан юм уу, үгүй юм уу? Энэнээсээ энэ үр дүнгээсээ улбаалаад ямар үр нөлөө үзүүлэх юм? Шалгуур үзүүлэлт нь тодорхой суурь түвшин нь тодорхой, зорилтот түвшин нь тодорхой байх ёстой. Жишээ нь 2028 онд дуусна гэж байгаа төслийн зорилтот түвшин ямар юм байх юм? Ийм мэдээллүүд нь байхгүй байгаад байгаа болохоор энийг ямар нэгэн байдлаар үнэлэх ч юм уу тийм боломж байхгүй байгаад байна. Аль төсөл нь илүү чухал юм бэ гэж эрэмбэлэх ч боломжгүй юм байна.

Энэ дээр манай Байгаль орчны яам ямар ажил зохион байгуулж байгаа вэ? Яамдууд хэзээнээс үр нөлөө, үр дүнгээ зөв хэмжээд шалгуур үзүүлэлтээ зөв тодорхойлоод ялангуяа энэ хөдөө орон нутгийн иргэдийн амьжиргааны түвшин хэдэн хувиар дээшлэх юм. Хариуцлагатай уул уурхайн хувь хэд байх юм. Тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд хэдэн хувиар ахих юм? Байгалийн гамшиг сөрөн тэсвэрлэх чадвар сайжрах юм уу, үгүй юм уу? Биологийн олон талт байдал гээд энэ маш олон гоё зорилгууд тавьчихсан байна. Хийж байгаа ажлаараа л дүгнэх гээд л байна л даа. Сургалт зохион байгуулаад байвал тэгээд л сургалт зохион байгуулаад л яваад байна. Яг тогтвортой хөгжил үүсэх юм уу, үүсэхгүй юм уу, цөлжилт буурах юм уу? Нөхөн сэргээсэн гол, нуур, цөөрөм хэдэн хувиар дээшлэх юм. Нэг ийм чанарын үзүүлэлтүүд хэрэгтэй байгаад байгаа юм. Төсөв дээр ч гэсэн хэлж байсан. 1 дүгээр хавсралт дээр хамгийн чухал зүйл нь байгаа. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин гээд. Санал оруулж байж ингээд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бүх бохирдуулагч бодисоор нь хэмждэг болсон. 21 аймгийн төвөө хэмжье гэсэн. Тэгээд санал нь унасан. Ийм тайланг оруулахдаа ийм алдаатай орж ирээд байгаа юм.

Ялангуяа ийм төлөвлөгөө төсөл хөтөлбөрийн ийм бичиг баримтууд энэ чухал суурь түвшин, зорилтот түвшин гэсэн эд нарыгаа л гоё тодорхойлоод өгчихвөл болохоор байна. Бусдаар бол энэ төслүүдийн агуулга болон юунд ямар ч асуулт алга. Хэзээнээс яг ийм үр дүнд суурилсан нэгдсэн байдлаар төлөвлөх юм бэ?

Одоо энэ 28 төслийн аль нь сая таны үзүүлж байсан чиглэлүүдээс аль чиглэл дээр нь бид нар ахиц гаргах юм бэ гэсэн жоохон анализ хийж байгаад бодитой нэг бодлогын чанартай байдлаар бичиг баримт төсөл хөтөлбөрүүдийн танилцуулга явмаар байна. Ийм болох боломжтой юу гэсэн асуулт байна.

С.Ганбаатар: Гишүүний асуултад хариулъя. 4 номерын микрофон дээр хариулъя.

Нэрээ албан тушаалаа хэлээд яваарай. Протоколд бүгд тэмдэглэгдэж байгаа.

П.Батхишиг: Баярлалаа. Би сайдын зөвлөх Батхишиг байна аа. Гишүүний хэлж байгаа KPI-ууд бол төслүүд дээр бий. Харьцангуй гаднын донор болон олон улсын байгууллагуудтай хамтарч энэ төслийг санаачилж санаан дээр нь 2-оос доошгүй жил ажиллаж байгаа учраас яг тийм дэлгэрэнгүй KPI-ууд бол бий. Би зүгээр жишээ болгоод энэ 21 хүлэмжийн хийн тооллого гээд 19, 20 дээр байгаа төслийг зүгээр хэлэхэд Монгол Улс 2019 онд Засгийн газрын тогтоолоор хүлэмжийн хий бууруулахад Парисын хэлэлцээрийн үүргийг яаж хүлээсэн бэ гэдгийг тавьчихсан байгаа. Тэрнийхээ хэрэгжилтийг жишээлбэл энэ хүлэмжийн хийн тооллого, тооллогын ил тод байдлын 1, 2 дугаар илтгэл үндэсний 5 дугаар тайлан гээд гардаг. Тийм байгаа. Тэгэхээр бусад төслүүд дээр ч гэсэн харьцангуй энэ KPI-ууд байгаа учраас энэ нэмэлт мэдээллийг бол бид нар нэмээд хүргүүлэх нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд мэдээж хэрэг сайжруулах юм бол байгаа. Баярлалаа.

С.Ганбаатар: Асуулт Лувсанжамц гишүүн тодруулъя.

Г.Лувсанжамц: Тийм. Миний асуулт болохоор ингээд Байнгын хороон дээр орж ирэхдээ таны сая хэлж байгаа байгаа бэлэн KPI-уудыгаа л оруулаад ир гэж байгаа юм. Тэгээд дараа нь явуулъя гэдэг юм болохоор энэ чинь ингээд явуулдаг байгууллага нь ч цөөхөн, тэр нь ирсэн ирээгүй нь ч мэдэгддэггүй тийм зүйл болчихоод

байгаа болохлоор би хэлээд байгаа юм л даа. Хэзээнээс танай яамнаас ингээд өргөн барьж байгаа хэлэлцүүлэх гэж байгаа асуудлууд нь KPI-тайгаа бүр зөв шалгуур үзүүлэлттэйгээ орж ирээд хэдүүлээ арай нэг илүү нэг ийм гүнзгий хэлэлцүүлэг өрнүүлмээр байгаа юм шүү дээ. Тэрийг л хэлж байгаа юм. Дараа нь ингээд бичгээр явуулна гээд тэгэхээр чинь зөвхөн над руу явуулах юм уу бусад энд ирсэн гишүүдэд очих юм уу, үгүй юм уу? Тэр нь тодорхойгүй учраас дараа дараагийн Байнгын хорооны хурлууд дээр ийм мэдээлэл өгч байгаа бол тэрийгээ өгөөч ээ гэсэн, хэзээ тийм болох вэ гэсэн асуултаа дахиад давъя.

С.Ганбаатар: Асуултад тодорхой хариулъя. 4 номерын микрофоныг нээж өгье.

П.Батхишиг: Ойлголоо. Тэгэхээр 28 төслийнхөө юмнуудыг эмхлүүлээд ирэх 7 хоногт хэдүүлээ удирдах хороонуудаас нь зөвшөөрөл аваад тэд нарыг ирэх 7 хоногт хүргүүлье ээ.

С.Ганбаатар: Лувсанжамц гишүүн 2 дахиа тодруулъя.

Г.Лувсанжамц: Нөгөө цаашдын бусад төсөл хөтөлбөрүүдээрээ ч гэсэн ийм байдлаар мэдээлэл авмаар байгаа юм гэж байгаа юм. Миний хэлж байгаа нөгөө тавьж байгаа хүсэлт нь болохлоор дараа нь яах вэ ингээд мэдээллээ хүргэж болно л доо. Дараа нь дахиад танай яамнаас ийм мэдээлэл өгөх бол тэр KPI-тай шалгуур үзүүлэлттэй бичиг баримтаа боловсруулаад өгөөч ээ гэсэн тийм зүйл байгаа. Тэгээд нөгөө төслийн агуулгууд бол бүгдийг нь дэмжиж байна танай маш сайн ажиллаж байгаа байх гэж бодож байна. Энэ чухал салбарыгаа бас цааш нь ажлын өндөр амжилт хүсээд хичээж ажиллаарай гэж хүсэж байна аа.

Тэгээд саяын хэлсэн ганц шаардлагыг ингээд л яг хэлчихмээр л хариулт л авмаар байна. Тэгээд өөр хүсэлт алга.

С.Ганбаатар: Уянга гишүүн асуулт асууя.

Б.Уянга: Энэ өдрийн мэнд хүргэе ээ. Их олон төсөл хөтөлбөрүүдийг Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлдгээрээ ер нь төрийн байгууллагууд дундаа их алдартай байдаг аа. Тэгээд өнөөдөр яг нарийвчлаад нэгдсэн байдлаар бүх төслүүдийн мэдээллийг авч сонсож байгаад баяртай байна. Тэгээд дараах хэдэн асуулт байна аа. Яг товчхон товчхон хариулаад өгөөрэй. Тэгэхээр нөгөө Монгол орны эхний асуулт нь болохоороо Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх эрсдэлийн менежментийг сайжруулах гээд 2021-2028 он хүртэл хэрэгжиж байгаа төслийн талаар тараагдсан материалд дурдсан. Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар гээд 4 аймгийг онцолсон юм байна. 2028 он хүртэл хэрэгжих юм чинь бүгдээрээ өөр аймаг нэмэх боломж байна уу? Яг зүгээр нөгөө ландшафтаар нь бодоод үзэхээр уулархаг тэгээд талархаг байх шиг байгаад байх юм. Цөлжилтөд нэрвэгдэж байгаа гээд байвал урд өргөргийн аймгуудад орох ёстой юм биш үү? Говийн бүсийн аймгуудаас оруулах ёстой байх.

Тэгэхээр оруулахад дэмжлэг болж өгөөч ээ яах ёстой вэ? Энэ дээр хариулт авъя. Тусгай хамгаалалттай газруудын менежментийг сайжруулах ёстой гээд Засгийн газрын мөрийн хөтөлбөрт оруулж өгсөн байгаа. Тэгэхээр энэ нь учир шалтгаан нь ТХГН-ийн тухай хуулиараа газрыг тусгай хамгаалалтад авчихаараа ерөөсөө хөндөж болохоо больчихдог. Хүн амьдрах тэр газрыг хөндөхгүй ингээд

бүхэлд нь хамаарч хамгаалчхаж байгаа учраас энэ олон төслүүдэд менежментийн загварыг боловсронгуй болгоод хүлээлгэн өгнө өө гэж дурдсан байна. Тэгэхээр одоо яг явц нь ямар байгаа юм бол? Ихэнх төсөл нь 2025, 2026 онд дуусаж байгаа юм байна. Биологийн олон янз байдлыг хамгаалах нь болохоороо 27 онд дуусах юм байна. Тэгэхээр энэ дээрээ менежментийг сайжруулна гэсэн байгаа юм чинь яг юу орох юм бол. Эсвэл байгалийн цогцолбор газрууддаа аялал жуулчлалыг хөгжүүлэхээр ярьж байгаа юм болов уу? Энэ дээр хариулт авъя. Уул уурхайн салбартай холбогдохоор бас хэд хэдэн төслүүд байна. Жишээ нь алтны уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсооход хувь нэмрээ оруулна гээд 2025 онд дуусах төсөл юм байна. Маш чухал эрүүл мэндийн асуудал. Хариуцлагатай уул уурхайг бэхжүүлнэ ээ гээд 2026 онд дуусах төсөл байна.

Нутгийн иргэд манлайлсан Байгаль хамгаалал гээд 2026 онд дуусах төсөл байна аа. Яг 2024 оны 6 сарын байдлаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаман дээр байж байхад эдгээр төслүүд Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай уялдсан байдлаар явагддаггүй байсан. Яригддаг ч үгүй байсан. Тэгэхээр яг энэ салбарын гол яамтайгаа хэрхэн хамтарч ажиллаж байгаа вэ? Хамтарч ажиллаагүй байгаа бол хамтарч ажиллах ёстой гэж хэлмээр байна. Тэгээд ер нь бол олон улсын ийм олон төсөл хөтөлбөр бол хэрэгжиж байсан түүхтэй байдаг. Яаманд олон жил ажиллаж байгаа манайхан бүгдээрээ сайн мэдэж байгаа байх. Тэгээд зөвлөгөөнүүд гардаг, зөвлөмжүүд гардаг. Хөндлөнгийн экспертүүд их ирж ажилладаг. Тэгээд тайлан нь бичигдээд бодлогын түвшиндээ хэрэгждэггүй дарагдчихдаг гэдэг нэг тийм шүүмжлэл байдаг аа.

Тэгэхээр яг энэ тайлангуудаа өмнө нь хэрэгжсэн бүх төслийнхөө тайлангуудыг нэг дор нээлттэй байлгах, одоо хэрэгжиж дуусах тайлангуудаа бас нэг дор байлгах дээр анхаарч өгөөрэй.

С.Ганбаатар: Гишүүн санал хэлсэн үү? Асуулт асуусан уу? Санал гэж ойлголоо шүү. Үгүй асуулт байсан уу? Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Уянга гишүүний асуултад хариулъя. Манайхан бас нэмээд хариулаарай. Энэ ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бид Улсын Их Хуралд өргөн барихаар бэлтгэж байгаа. Үзэл баримтлал нь бол ингээд батлагдчихсан. Тун удахгүй өргөн барина аа. Тэгэхээр энэ ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар саяын таны асуусан асуулт бол яг 36 дугаар зүйлд ингээд орж байгаа. Өөрөөр хэлбэл ТХГН-ийн орчны бүсийн менежментийн ямар байх юм бэ гэдгийг бол орон нутаг нь ямар байх юм. Бид нар менежментийг нь хэрхэн хэрэгжүүлэх юм? Хэн ямар үүрэгтэй байх юм бэ гэдгийг нь бол оруулж өгсөн байгаа. Тэгээд ер нь зүгээр бид нар энэ манай яам бол энэ 2025 онд төрийн зарим чиг үүргийг ТББ, хувийн хэвшилд зоригтойгоор шилжүүлнэ ээ гээд ийм зорилт тавиад ажиллаж байгаа. Сая энэ сард гэхэд бид нар нийт нэг 25 байгууллагууд ТББ хувийн хэвшилдээ санамж бичиг зурсан байгаа.

Өөрөөр хэлбэл бид энэ төсвийн хөрөнгөөр юм уу эсвэл манай ТХГН-ийн энэ ажилтан албан хаагчид хэдэн аймаг дамначихсан ийм газар бол одоо энэ хамгаалалтыг бүрэн хийхэд маш хүндрэлтэй байдаг. Яах вэ энэ олон улсын нөгөө тусламж, хөтөлбөрүүд хэрэгждэг тулдаа бас ингээд бид энэ газруудынхаа менежментийг хийгээд явж байгаа. Тийм учраас бид энэ чиг үүргүүдийг зоригтойгоор шилжүүлж, хамтарч ажиллах, тэд нараас тусламж дэмжлэг авах энэ ажлыг бол эхлүүлсэн байгаа. Орон нутагтай ярьсан. Энэ бол нэлээд амжилттай нэлээн ачааны хүндийг үүрэлцэх байх гэж бодож байна. Манай ТХГН-т бол энэ

менежмент хийх нэгж байдаггүй. Одоо байгаа зардал нь бол зөвхөн цалин урсгал зардалтай явдаг.

Тийм учраас бусад орны жишгээр бол одоо менежментийн нэг нэгж байдаг юм байна. Өөрөөр хэлбэл энэ менежментийн нэгж дээр энэ тусгай хамгаалалттай газар нутгаа тоног төхөөрөмжөөр хангаж байдаг, мэдээлэл мэдлэгээр хангаж байдаг ийм зүйл байдаг. Бид нар энийг бас нэвтрүүлэхээр зорьж байгаа. Тусгай шалгуур үзүүлэлтүүд байгаа. Та бас өмнө нь ярьж байсан. Орон нутаг нь баахан тусгай хамгаалалтад авчихдаг, яам бас ингээд л авчихдаг. Улсын Их Хурлаар тогтоол гаргаад авчихдаг. Тэгэхээр энийг ямар зүйлийг шалгуур үзүүлэлтээр авах юм бэ гэдгийг энэ хуулийн төсөлд нэлээд дэлгэрэнгүй оруулж өгсөн байгаа. Хадлан тэжээлээ яах юм, бэлчээрээ яах юм бэ гэдэг. Тэгэхээр энэ менежментийг сайжруулах дээр маш олон ажлыг хийхээр төлөвлөсөн байгаа.

Нэмээд манай хүмүүс хариулчих уу?

С.Ганбаатар: Уянга гишүүний асуултад нэмж хариулъя. 7 номерын микрофоныг нээе.

Х.Мөнхзул: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Мөнхзул гишүүний асуултад хариулъя.

Энэ хөдөөгийн Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох чадварыг нэм юу, чадавхыг нэмэгдүүлэх, эрсдэлийн менежментийг сайжруулах Адапт гээд төсөл хэрэгжиж байгаа. Анх төсөл бичихдээ төслийн эхний бичиг нь болохоор чинь яг энэ 4 аймаг сонгогдоод үйл ажиллагааны чиглэл нь батлагдаж орж ирсэн. Хэрэгжих юм нь 2021-2028 он байж байгаа. Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймаг. Энийг судалж үзээд бас цаг үеийнхээ өөрчлөлттэй холбогдуулаад дахиад өөр аймаг энийг солих юм уу эсвэл нэмэх боломж байгаа талаар нь судалж үзээд санал тавьсан. Дор хаяж 6-аас 1 жилийн хугацаа шаардлагатай учраас энийг хэрэгжих хугацаандаа энийг өөрчлөхөд төвөгтэй юм байна лээ. Энэний харин төслийн үр дүнд хэрэгжсэн зарим арга хэмжээнүүдийг амжилттай болж байна гэж үзэх юм бол бусад аймгууд өөр төсөл хөтөлбөрөөр юм улсын төсөл дээр тавиад энэ арга хэмжээг нь үргэлжлүүлээд явчихвал боломж харагдаж байгаа юм. Баярлалаа.

С.Ганбаатар: Уянга гишүүн тодруулах уу? Уянга гишүүн асуултаа тодруулна.

Б.Уянга: Нөгөө нэг уур уул уурхайн салбартай уялдах 3 төсөл байгаад байгаа шүү дээ тиймээ? Алтны уурхайд мөнгөн усны хэрэглээг зогсоох, хариуцлагатай уул уурхайг бэхжүүлэх. Тэгээд нутгийн иргэдийн оролцоогоор байгалийг хамгаална гээд.

С.Ганбаатар: Филиппинтэй холбоотой юу?

Б.Уянга: Энэн дээр Уул уурхай, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хэрхэн хамтарч байгаа вэ? Хамтраагүй бол хамтрах шаардлагатай.

4 номерын микрофонд хариулт өгье.

Х.Мөнхзул: Бусад яамтай хамтрах энэ юу бол ер нь төслийн удирдах хороогоороо дамжиж хэрэгжвэл их зүйтэй харагдаад байна. Тэгээд бид нар бол яг

одоо нөгөө төслүүдийн удирдах хороог шинэчлэх энэ ажил дээрээ явж байгаа. Хүмүүсийнхээ саналыг аваад бүгдээрээ өмнө нь байгуулагдсан нөгөө дэд сайдаар ахлуулсан ажлын хэсэг удирдах хороотой байдаг юм байна лээ. Ихэнх төслүүд нь. Тэгээд энийг төслийн багийн гишүүдийг шинэчилсний дараа удирдах хорооныхоо. Мэдээж хэрэг тэрийг хүлээлгүйгээр бид нар Эдийн засгийн хөгжлийн яам Уул уурхай, Аж үйлдвэрийн яамнуудтайгаа харьцаад санал солилцоод тулгамдсан бас нэг жоохон хугацаа алдчихсан юмнуудад бол хариу өгөөд явж байгаа. Тэгэхээр удирдах хороогоо бид нар яаралтай шинэчлээд энэ ажлыг эрчимтэй үргэлжлүүлнэ ээ гэж хэлэх байна.

С.Ганбаатар: Жаргалсайхан гишүүн асуулт асууя.

Д.Жаргалсайхан: Энэ олон төсөл ингээд хэрэгждэг юм байна. Тэгээд энэ төслүүдээ хэрэгжих газар орон тэр аймгаа яаж сонгодог юм бэ? Мөн одоо энэ төслүүдтэй холбоотой тэр тусмаа Байгаль цаг уурын хүнд цаг үед энэ ард иргэдийн эрүүл мэндийн асуудал их чухал байгаа юм. Тэгээд энэ асуудлыг та бүхэн маань урьд жилүүдэд бол харж байсан. Тэгэхээр энэ иргэдийн мэдээлэл тэгээд мэдлэгтэй болгох энэ өвөлжилт энэ хүнд байдалд бэлтгэх дээр энэ малчдын нөхөрлөлд түшиглэн бэлчээрийн менежментийг сайжруулах замаар гээд. Тэгээд энэ асуудал дээр манай энэ хангайн бүс нутаг маш их бэлчээрийн доройтолтой болсон даацлуулдаг. 4-өөс 5 дахин ингээд хэтэрчихсэн байгаа юм. Тэгэхэд ингээд өөр аймаг руу явчихсан байгаа байхгүй юу жишээ нь.

Бэлчээрийн нүүрстөрөгчийн ТЭЗҮ төсөл гэдэг дээр бол бас одоо яг энэ малчдын МАА-д эзэлж байгаа гаднын нэмэлт орлоготой болох боломжийг бүрдүүлэх ч гэдэг юм уу ийм ингээд нэртэй төслүүд байж байгаа байхгүй юу. Тэгээд энэн дээр бас энэ аймгуудыг нэмэх боломж байдаг юм уу? Яаж үнэлдэг юм бэ? Мөн дээрээс нь энэ түрүүн энэ Уянга гишүүний асуудал гарч байна. Энэ газар нутгийг ингээд л нэг баахан олон ингээд дархан цаазат гээд л говийн одоо юу гэдэг юм Говь 3 сайхан гээд л ингээд баахан л ингээд л тусгай хамгаалалттай газрууд гээд бий болгочхож байгаа юм. Энэ нь ингээд л нэг хүмүүст янзын сайхан юм шиг ингээд байна.

Дараа нь эргээд нөгөө газар нутагтаа хүмүүс нь дураараа юм уу эс үгүй бол нүүгээд очих ч эрхгүй болж байна шүү дээ. Энэ дээр ямар бодлого байдаг юм? Бид нар энийгээ эргэж харахгүй, бид нар өөрсдөө бас жишээ нь Баянхонгор аймаг, Өвөрхангай аймгийн тэр нутгууд бол Богд уулын Дархан цаазат газар гээд л байж байна. Их говийн дархан цаазат гээд л байж байна. Их говийн Гурван сайхан ч гээд л ингээд л байж байх жишээний. Тэгээд энэ дээр бид нар одоо бас ямар байдлаар хандах ёстой юм. Тэгээд энэ дээр хэрэгжиж байгаа энэ төслүүдийг жишээ нь манай Эхийн гол гээд тэр орчимд хүмүүс юу гэдэг юм мал бэлчээрлээд явах ч боломжгүй болчихоод байгаа шүү дээ. Бүүр хойшоо явж Говь-Алтай нөгөө юу руу очиж зөвшөөрөл авдаг ч гэдэг юм уу тэгээд энэ энэн дээр бас одоо ямар байдаг юм? Энэний төсөл нь л бидний хувьд бол их л том. Гаднын санхүүжилттэй төслүүд явдаг л гэсэн мэдээлэл байхаасаа мэдэхгүй байгаад байгаа байхгүй юу. Дараа нь энэ эрүүл мэндтэй холбоотой асуудал байж байгаа юм. Ингээд бэлчээр энэ МАА-гаас гадна хүний эрүүл мэндийн асуудал байгаа. Одоо яг тэр зуднаар одоо ч гэсэн ингээд өвөлжилтийн бэлтгэл ажил хангах гээд энэ айлуудад очиход гэр бүл нь сум руу орчихсон хүүхдээ аваад, ганцхан нөхөр л гэртээ байж байгаа байхгүй юу. Тэгээд гэр нь гэхэд ямар ч тийм давхарга байхгүй түлээ нүүрс ч байхгүй ингээд байж байх жишээний. Тэгээд энэн дээр ингээд эрүүл мэндтэй холбоотой Байгаль орчин.

С.Ганбаатар: Хариулт өгье. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр эхлээд би энэ ТХГН-ийнх нь асуултад хариулъя Жаргалсайхан гишүүн ээ. Энэ ТХГН-ийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг одоо яамнаас ингээд боловсруулаад үзэл баримтлал нь батлагдаад өргөн барих гэж байгаа. Тэгэхээр энэ Улсын Их Хуралд өргөн барихаар нөгөө ажлын хэсэг гардаг Байнгын хороон дээр ярина, чуулган дээр ярина. Энэ дээр бол гишүүд маань саналаа өгөөд энэ ТХГН-ийн тухай хуулийг одоо энэ Улсын Их Хурал маш чамбай амьдралд нийцсэн ийм хууль болгох боломж байгаа. Удахгүй бид өргөн барина. Энд бол таны хэлээд байгаа бас л ингээд тусгай хамгаалалттай газар гэж байна. Дархан цаазат газар гэж байна, байгалийн цогцолбор газар гэж байна, байгалийн нөөц газар гэж байна. Нөхөн сэргээгдэх байгалийн баялаг бүхий газар гээд л ингээд хуулиараа их олон янзын ийм ангиллынх байгаа. Тэгэхээр энэ дээр бол яг энийг хуульд ингээд нэг бүрчлэн нарийн тусгачихсан байгаа. Ямар газар нь ямар зүйлийг хориглох юм, ямар зүйлийг ашиглаж болох юм гэдгийг бол хориглочихсон байж байгаа. Ямар зүйлийг зөвшөөрөгдсөн юм бэ гэдгийг бол энд байгаа. Ер нь бол энд нэг 5 ангиллаар бид бол энэ хуулийн төсөлд оруулсан байгаа.

Тэгэхээр энэ хууль өргөн баригдахаар та бас энэ дээр сайн саналаа хэлээд ажиллаарай гэж хүсэж байна.

Хоёрдугаарт энэ гаднын энэ тусламжуудыг би ер нь ажлаа аваад ингээд үзэхэд манай яам бол бас энэ яг гаднын зээл тусламж дээрээ ингээд бүртгэдэг, үнэлэлт дүгнэлт өгдөг, ийм гадаад харилцаагаа хариуцдаг ийм яг бүтэн нэгж байгаагүй. Тэгэхээр бид нар ганц нэмж шинэ байгуулсан нэгж нь бол Гадаад хамтын ажиллагааны газар гэдгийг байгуулаад энэ олон төслийнхөө үр өгөөж нь ямар байгаа юм, хаана ямар төсөл хэрэгжиж байна. Энэ төслүүдтэйгээ хэрхэн хамтарч ажиллах вэ, ямар эргэх холбоо байх вэ. Энэ төслийнхөө үнэлэлт дүгнэлтийг өгдөг ийм газартай болсон.

Тийм учраас энэ дээр бол бид нэлээд төсөл хөтөлбөрүүдээ идэвхжүүлэх чиглэлээр бол ажиллаж байгаа. Тэр аль аймгийг сонгох вэ гэдэг дээр бол ер нь яамнаас бараг санал авдаггүй. Голцуу энэ төслийг хэрэгжүүлэхийн өмнө өөрсдөө манай төслийн нэгжүүд судалгааны баг ажиллуулдаг. Хөндлөнгийн судлаач дээр голцуу энэ судалгаагаа хийлгээд тэгээд бид нар энийг ингээд хэрэгжүүлнэ ээ гэдэг ийм зүйлүүд яригддаг юм. Тэгэхээр ер нь энэ аймаг сонголт дээр ч гэдэг юм уу энд бол ер нь Монголын тал бол бас төдийлөн нэг их айхтар санал өгөөд шийдэх боломж бага юм шиг харагдсан. Тэгэхдээ яах вэ одоо өмнө нь хэрэгжиж байсан төслүүд учраас би тэгж хэлж байгаа. Цаашдаа хэрэгжүүлэхэд бол бид нар өөрсдөө энэ аймагт чинь ийм зүйл хамгийн чухал байгаа юм шүү гэдгийг бол ингээд хэлж яриад ажиллах боломжтой. Эрүүл мэндийн асуудал их чухал асуудал яалаа.

Ер нь энэ ТХГН-т энэ уугуул иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал бол маш чухал байдаг. Тийм учраас энэ дээр энэ ХБНГУ-ын KFW гэж төслөөс энэ ТХГН-ийн сумдуудад эмнэлгийн машиныг бол өнгөрсөн 6 дугаар сард өгсөн байгаа. Ингээд ээлж дараалалтай өгч байгаа. Өөрөөр хэлбэл энэ нутгийн иргэдийн эрүүл мэндийн асуудал бол чухал юм аа. Энэ хэдийгээр ЭМЯ-ны асуудал юм шиг боловч энэ бол энэ төслийн уугуул иргэдэд чухал гэдэг үүднээс энэ нэлээн том төсөл бол хэрэгжсэн байгаа. Манайхан тэгвэл саналаа хэлэх үү?

С.Ганбаатар: 3 номерын микрофонд саналаа хэлье. Дэлгэрүүлж хэлье.

Б.Оюунсанаа: Сайн байцгаана уу? Жаргалсайхан гишүүний асуултуудаас нэмж хариулъя. Тэгэхээр төслийг хэрэгжүүлэх байршлийг хэрхэн сонгодог вэ гэдэг дээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газрын дарга Оюунсанаа байна аа. Тэгэхээр бид төслийг хэрэгжүүлэхийн тулд урьдчилсан судалгаа хийдэг. Судалгаан дээрээ тухайн жишээ нь би ойжуулалт дээр жишээ аваад яриадахъя. Ойжуулалт хийх газрыг сонгохын тулд бид нар бидэнд мэдээллийн сан бий. Мэдээллийн сан дээр 1.6 сая га талбай ойн хөнөөлт шавжын улмаас доройтсон байж байгаа ойн сангийн. Эндээсээ эрэмбэлээд тогтоочихсон байдаг орон нутгийн болоод улсын төсвөөс хийж болох ажил. Гаднын төсөл, хөрөнгө оруулалтаар хийх ажил байна. Эрэмбэлчхээд эндээсээ бид нар саналыг тавьдаг. Бидэнд ийм бололцоотой, ийм ийм аймгууд, ийм газрууд байна гээд. Энэ дээрээ хамтарсан ажлын хэсэг гараад ажилладаг. Ажиллаад тодорхой байршлуудаа тогтоод ялангуяа орон нутагтаа нэлээдгүй ажиллаж байж орон нутгийн удирдлагын түвшний хүмүүсийг оролцуулж байж хэлэлцүүлгүүдийг өрнүүлж байж сонголтоо хийгээд явдаг. Ерөнхийд нь ярих юм ийм жишиг бий. Тэгээд мэдээж эрэмбэлж байж бид нар гаргаж ирдэг юм гэдгийг хэлэх гэсэн юм. Тусгай хамгаалалттай газрын хувьд бас онцгой онцлог зүйлс бий. Тэрэн дээр сайд хариулсан учраас ингээд. Баярлалаа.

С.Ганбаатар: Асуултад хариуллаа. Мөнхтулга гишүүн асуулт асууна.

П.Мөнхтулга: Сая аймгуудыг яаж сонгодог вэ гэсэн бид нар судалгаа хийдэг гээд. Тэгээд тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл гэсэн чинь Хөвсгөл, Хэнтий 2 л байгаа байхгүй юу. Тэгээд манай Монголын хамгийн их аялал жуулчлал авдаг, тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх ёстой аймгийн нэг чинь Архангай шүү дээ. Тэгээд та нар судалж судалж байгаад ерөөсөө энэ 2 л аймаг дээр 38 сая доллар зарцуулна гэж ийм мундаг судалгаа хийдэг юм байна зөв үү тэ?

Тэгээд энэ сонголт судалгаа чинь яг тийм бодит судалгаа байгаад байна уу эсвэл улс төржилт явдаг юм уу? Надад бол энэ дээр үнэхээр яг бодит судалгаа хийсэн бол энэ дээр шал өөр аймгууд. Жишээлбэл дахиад нэг жишээ дурдъя. 9 дүгээр төсөл дээр. 19.8 сая еврог зарцуулах гэж байна. 2024 оны 11 сар гэдэг чинь өнгөрсөн сараас эхэлж хэрэгжих гэж байна энэ төсөл. Тэгээд энэ дээр болохоор ХАА болон экосистемийн тогтвортой менежментийг хангах нь гэж байгаа юм. Тэгээд газар нутгуудад дэмжлэг үзүүлэх замаар гээд энэ дээр говийн аймгууд ерөөсөө байхгүй. Бид нар говио сүйтгэж, тэндээс олсон уул уурхайн орлогоор гадаадын зээл тусламжаа эргүүлж төлнө. Тэгсэн мөртөө энэ эко систем нь хамгийн эвдэж байгаа энэ аймгуудынхаа яагаад Байгаль орчны асуудал руу нь орохгүй одоо энэ дээр орж байгаа нь баруун 5 аймаг, Хэнтий, Сэлэнгэ, Хөвсгөл гэхчигсэн байгаа. Говь байхгүй, хангай байхгүй. Тэгэхээр энэ судалгаанууд чинь үнэхээр та нар ийм мундаг судлаад хамгийн чухал газруудаа хаяад байдаг юм уу? 1 дүгээр асуулт.

Хоёрт нь одоо манай Монгол Улс карбон кредитээ тооцуулбал бид нар бараг дэлхийд хамгийн баян болохоор хорт утаатай байгаа. Тэгээд энэ дээр яагаад манайх хоцроод байдаг юм бэ? Хувийн хэвشلүүд чинь хэдэн залуучууд хөөрхий минь өөрсдийнхөө хэмжээгээр НҮБ-тай нэг аппликэйшн хийгээд, гэр хорооллынхныг тэрэндээ сургаад ингээд яваад байна лээ шүү дээ. Тэгээд яам нь яагаад энэ рүү орохгүй байгаад байгаа юм бэ? Энд маш их мөнгө байгаа шүү дээ.

Гуравт нь энэ төслүүдээ орон нутгийн удирдлагуудтай яаж холбодог юм бэ? Жишээ нь сумын Засаг дарга, аймгийн Засаг дарга, аймгийн иргэдийн төлөөлөгч нар энэ төсөл хөтөлбөрүүдэд саналаа өгч оролцох боломжтой байдаг уу? ийм 3 асуулт.

С.Ганбаатар: Хариулт өгье. 3 асуулт асуулаа. 3 номерын микрофонд хариулт өгье. Нэр усаа хэлээрэй.

Б.Оюунсанаа: Ойн газрын дарга Оюунсанаа байна. Мөнхтулга гишүүний асуултад хариульъя.

Энэ төслийн 1 дүгээр үе шат нэг хуучин ажиллаж байсны хувьд мэдээлэлтэй байгаа. Таны асуусан 9 дүгээр заалтад байгаа төслийн хувьд ярих гэсэн юм. Ер нь сонголтын хувьд болохоор судалгааг өргөн хүрээнд хийдэг ээ. Мэдээж тухайн аймаг орон нутагт санхүүжилт орон нутгийн болон төсвийн санхүүжилт нь хэр байгаа юм. Энэ асуудал маань өөрөө хэр эрэмбэлэгдэж явж байгаа юм гэдэг асуудлуудыг авч үздэг. Энэ хөдөө Жайзета хамтарч хэрэгжиж байгаа төслийн хувьд болохоор бид өмнө нь эхний шатанд хэрэгжсэн байсан төсөл өргөжүүлж тэлээд энэ дээр Хөвсгөл аймаг нэмэгдэж байгаа. Энэ Германы Засгийн газраас бас ажлын хэсэг ирж ажилласан. Тэднээс тодорхой саналуудыг тавьсан. Бид нэг байрлалаас нөгөө байрлал руу тийм огцом өөрчлөлтийг хиймээргүй байна. Эхний гаргасан үр дүнгээ үргэлжлүүлээд хиймээр байна гэдэг 2 талын саналууд тусгагдаж байгаад энэ маань энэ төслийн хувьд үргэлжлээд явагдаж байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Дээрээс нь Хөвсгөл аймаг маань ойн сангийн гол массанд байж байдаг. Тэнд асуудлууд хэвээрээ байгаа учраас энэ дээр үргэлжлүүлээд хийе ээ гэдэг тэр асуудлыг 2 талаас ярилцаж байгаад орсон байж байгаа. Орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын оролцоо ямар байдаг юм бэ гэдэг жишээ нь би Иншур төсөл дээр жишээ авч хэлэх гэсэн юм. Ирэх жилээр дуусах гэж байгаа төсөл. Байгаль орчин уур амьсгалын яаман дээр хэрэгжсэн 7 жил хэрэгжээд дуусаж байгаа төсөл. Энэ төслийн хувьд юу гэхээр баруун 4 аймгийн 11 суман дээр хэрэгжиж байгаа. 11 сумынх нь Засаг дарга нь 4 аймгийн засаг дарга нь дээрээс нь орон нутгаас нь бас төлөөлөгч байдаг. Тэгээд яг газар дээр идэвхжүүлэгч байдлаар ингээд ажилладаг. Яг орон нутгийн иргэдээр сонгогдсон тэр хүн маань газар дээр яг хүмүүстэйгээ ингээд ажиллаад явдаг. Ийм бүтэц зохион байгуулалттай буюу бүх санал юмнууд маань нэг орон нутгаасаа орж ирээд ингээд хэрэгждэг. Ийм төслийн жишээ байгаа.

С.Ганбаатар: 4 номерын микрофонд хариулт өгье.

Б.Батхишиг: Аялал жуулчлал дээр их том төсөл төсөв байна гээд тэгсэн. Энэ 2019 оноос хэрэгжсэн гэдэг маань ойролцоогоор 16, 17 оны үед хаана хэрэгжихээр ямар дүнтэй гэдэг зүйлийг нь сонгочихсон ийм төсөл байгаад байгаа. Одоо төсөл сүүлийнхээ шат руу орсон учраас аялал жуулчлал манай яамнаас салаад энэ ажил салаад явчихсан байгаа. Тэгэхээр урьд өмнө 5, 6, 7, 8 жилийн өмнө шийдэгдсэн төслүүдийн хувьд бол шинэ орж ирсэн багийн хувьд өөрчлөөд байх нь их бага харагддаг юм байна лээ. Яагаад гэхээр хамаг ажлууд нь урагшаа явчихсан.

2 дахь асуудал карбон кредиттэй холбоотой асуудал бол сая Бакугийн уур амьсгалын конвенцын хурлаар л 10 гаран жил хэлэлцэж байж тэр нь Карбон кредитийг улс хоорондоо арилжих ерөнхий үйл явцын стандартыг л тохиролцлоо.

Тэгээд энэ тохиролцсон маань одоо дараагийнхаа шат руу нарийвчилсан дүрэм журам бол гаргах ёстой байх. Яамны тухайд бол Жи Ай Зи-тай хамтраад 2, 3 жилийн өмнөөс Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийг төслийн хүрээнд бичүүлсэн байгаа.

С.Ганбаатар: Наранбаатар гишүүн асуулт асууя.

Мөнхтулга гишүүн тодруулах байсан уу? Болчихсон уу? Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Энэ Байгаль орчин, уур амьсгалын чиглэлээр 359 сая доллар, 107 төсөл арга хэмжээ гэдэг чинь 1 их наяд гаруй төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байгаад байгаа байхгүй юу. Тэгээд энэ тарааж өгсөн материалыг чинь харахаар эндээс ерөөсөө нэг олигтой ойлгогдох юм байхгүй. Түрүүн нэг гишүүн хэлж байсан. Энэ нөгөө хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт эхлээд ямар байсан юм тэгээд төсөл хэрэгжсэнээрээ явц нь ямар байгаа юм? Аль эсвэл дууссан бол үр дүн нь ямар байгаа юм гэх мэтчилэн энэ хүснэгт чинь зүгээр нэг тийм мэдээллийн чанартай л хүснэгт байна.

Байнгын хорооноос дараа дараагийн яамдуудын мэдээллийг сонсохдоо яг ийм хэмжээнд мэдээллээ хийе гэж хэлж өгөхгүй бол зүгээр нэг ийм усан мэдээлэл эндээс чинь ерөөсөө ойлгогдох юм байхгүй л юм байгаад байгаа байхгүй юу. Дараагийн дугаарт олон гишүүд хэлж байгаа энэ төсөл хэрэгжих байршлаа яаж сонгоод байгаа юм гээд. Тэгээд өнөөдөр говийн бүсээс уул уурхайгаас хамаг орлогоо олж байгаа. Тэгээд тэнд үлдэж байгаа орон нутаг, иргэдийн амьдрал ойлгомжтой байгаа шүү дээ. Ан амьтан нь үхээд дүрвээд алга болчихсон. Мал аж ахуй эрхлэх ямар ч боломжгүй цөлжилттэй болчихсон. Хүн амьтан нь тоос шороондоо дарагдчихсан, ийм л хүнд нөхцөлтэй байгаа юм. Тэгээд энэ төслийнхөө хэрэгжиж байгаа энэ байршлийг яаж сонгоод байдаг юм. Аль болох боломжтой газруудад нь бэлчээрийн доройтлийг сайжруулах гээд л тэгэхэд говийн бүсэд хамгийн доройтчихоод байхад л хангайн бүс бэлчээр сайтай аймгуудад төсөл нь хэрэгжээд явж байх жишээтэй. Тэгэхээр түрүүний судалгаа үндэслэж хийдэг гэдэгт би итгэхгүй байгаа юм. Аль нэгэн сайдын тэр тухайн сайдын, сонгогдсон тойрог юм уу? Энэ төслийг хийж байгаа энэ яамны мэргэжилтнүүдийн нутаг юм уу? Ямар учиртай юм. Тийм байдлаар сонголтгоо хийдэг юм шиг харагдаад байгаа байхгүй юу.

Тэгээд энэ гишүүд ч гэсэн гайхаад байна шүү дээ. Яаж сонгоод яаж хийгээд байгаа юм гэдэг дээр цаашдаа анхаарах хэрэгтэй.

Дараагийн дугаарт бидний хамгийн тулгамдсан асуудал чинь агаарын бохирдол, цөлжилт, энэ хогийн асуудал байгаа шүү дээ. Тэгээд энэ чиглэл рүү эндээс чинь харвал хэрэгжсэн төсөл байхгүй л юм шиг харагдах юм. Агаарын бохирдлыг бууруулахад хэчнээн хэмжээний төсөв хөрөнгө зарцуулж, ямар үр дүнд хүрсэн юм. Энэ Улаанбаатарын аймгуудын энэ хог, энэ хогийн менежментийг сайжруулахад юу хийсэн юм. Энэ чиглэл рүү ямар ажил хийсэн юм гээд ингээд яг хэрэгтэй хэрэгжүүлэх тулгамдсан ийм ажлууд руугаа биш өөр өөр энэ нэн шаардлагатай биш зүйлүүд рүү их төсөл арга хэмжээ нь чиглэгдэж явсан байна гэж ингэж харагдахаар байгаа юм. Тэгээд ТХГН-ийн тухайд бол хураамж төлбөр авдаг мөн энэ зээл тусламжийн хажуугаар. Тэгээд энэ.

С.Ганбаатар: Дараа нь тодруулах юм байна. Ингээд хариултаа авъя. Хэн хариулах вэ? 4 номерын микрофонд хариулна аа.

Т.Батхишиг: Энэ манай яаман дээр нэгтгэгдсэн энэ 28 төслийн мэдээлэл бол яг олон улсын донор ОУБ, Засгийн газар хооронд ногоон сан, уур амьсгалын сангуудаар дамжин манай яамтай бодлогын хувьд явж байгаа төслүүдийг оруулсан

байгаа. Одоо жишээлбэл агаарын бохирдолтой холбоотой том төсөл бол Эдийн засаг, хөгжлийн яаман дээр явж байна. Энэ маань хотыг ногоон орон сууцаар хангах гэдэг төсөл явж байдаг. Ногоон хөгжлийн сангаас бас аймаг, сумдын одоо ногоон хөгжлийг дэмжих гээд 178 сая долларын тийм төслүүд ч гэдэг юм уу. Ингээд бусад яамд дээр яг чиглэсэн төслүүд харьцангуй том агуулгаараа явж байдаг учраас энэ дээр яг тийм агаарын бохирдлын, ялангуяа одоо гэр хорооллыг ногоон барилгажуулах дэд төв барих энэ тэр төслүүдийг бид нар энд оруулаагүй ээ. Яагаад гэхээр төслийн үндсэн хариуцагч нь тэр яаман дээр явж байгаа учраас. Хүнс ХААЯ-ан дээр ч мөн ялгаа байхгүй. Бэлчээртэй холбоотой малын тоо толгойтой холбоотой бэлчээрийн доройтлыг сайжруулах, газрын доройтолтой холбоотой тийм төслүүд олон явдаг. Яг бид нарт өгсөн энэ асуулгаар бол Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын яг хариуцаж байгаа төслүүдийн.

Түрүүний асуултаа хариулчихъя. 98 оноос хойш өчнөөн их мөнгө зарчихсан байна гэж байгаа боловчиг бид нар бол яг одоо хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явц үр дүнг танилцуулна уу гэсэн энэ агуулгын хүрээнд материалыг бэлдэж ирсэн байгаа. Мэдээжийн хэрэг тэр 1 их наяд гаруй төгрөгөөр хэрэгжсэн бусад төсөл хөтөлбөрүүдийн үр дүн бол шаардлагатай тохиолдолд мэдээж өмнө аудит янз бүрийн байгууллагууд дээр гарсан тайлангууд байгаа байх. Энийг бол бид нар яахад цаг жоохон орох байх л гэж харж байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Тодруулах уу та? Тодруулъя Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Тэгээд хариулт ер нь тийм юу байна хангалтгүй. Тэгээд л ерөнхий нэг гишүүдийн амыг таглах маягтай л хариулт өгөх юм аа. Энэ тусгай хамгаалалттай газар, нутгуудад дэмжлэг үзүүлэх гээд түрүүн гишүүн асууж байсан. Одоо жишээ нь говийн бүсэд гэхэд Ёлын ам, Говь Гурвансайханы тусгай хамгаалалттай газар гээд байдаг юм. Жуулчид их очдог тэгээд. Ёлын аманд яваад очихоор нэг ч жорлон, хогийн сав, тийм дэд бүтэц байхгүй. Тэгээд үнэхээр хэцүү. Гаднын жуулчид дагуулаад очиход бол дотоодынх ч ялгаа байхгүй. Тэгээд аймаг нь юм хийчихье гэхээр мөнгөө гаргаад. Тусгай хамгаалалттай газар юу ч хийж болохгүй ээ гэдэг. Тэгсэн мөртөө энэ гадаадын зээл тусламжууд нь тусгай хамгаалалттай газруудад зориулагдсан зээл тусламжууд нь өөр тийшээ хуваарилагдаад байдаг. Дахиад тэндээс тусгай хамгаалалттай газраас хураамжууд аваад байдаг. Тэр нь яам руу явчихдаг гэдэг. Эргээд нэг ганц жорлон, ганц хогийн сав барьчихгүй. Иймэрхүү л байдалтай байгаад байгаа юм.

Тэгэхээр зэрэг би энэ ТХГН-аас.../минут дуусав/.

С.Ганбаатар: Наранбаатар гишүүний санал байлаа. Асуулт байсан уу? Тэр хаашаа ороод байна вэ гэж асуусан шүү. Хариулт хариулт хэн хариулах вэ? 5 номерын микрофонд хариулъя.

Ү.Энхтайван: Гадаад хамтын ажиллагааны газрын дарга Энхтайван байна аа. Би эхлээд тэр гишүүд нарын маань асуугаад байгаа энэ төслүүдийнхээ үр өгөөж тэр хүрч байгаа үр дүн юмны талаар ер нь дэлгэрэнгүй мэдээлэл оруулж ирэх асуудлыг байн байн хөндөөд байна. Тэгэхээр энийг бол зүйтэй гэж бодож байгаа. Манай яаман дээр бол яг энэний нэгдсэн мэдээлэл дата сан бол бүрэн байхгүй. Гэхдээ бид бүхэн нэг мэдээллийн дата санг хөгжүүлж байгаа. Энэ EIS гээд сан одоогоор 53 мэдээллийн сантай ийм сан байгаа. Мэдээж дотоодын нөөцөөр хөгжүүлж байгаа учраас илүү дэлгэрэнгүй хийх шаардлагатай. 2025 онд бид нар

энийг бүрэн хийгээд бүх төслүүдийн үр өгөөж, үр дүнг тооцож харах ассессмент хийх боломжтой болно гэж тооцож байгаа. Өнөөдрийг хүртэл яг бүх төслийг нэгтгэсэн байдлаар үр дүнг үнэлж нэгтгэсэн судалгаа тооцоо улсын хэмжээнд бол бүрэн байхгүй байгаа гэдгийг тодотгоно.

С.Ганбаатар: Одонтуяа сайд хариульъя тодруулж.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ сая бид нар хэллээ. Энэ төслийн удирдах хороод гэж байгаа. Тэгэхээр нөгөө удирдах хороод бол голцуу нөгөө өөр өөр яамдуудын ийм төлөөлөл байдаг. Тэгэхээр Удирдах хороо хуралдаад энэ ийм асуудлуудыг нэгтгэх ажлыг бол хийж байгаа. Наранбаатар гишүүний хэлсэн энэ төлбөр мөнгө яаж байна гээд. Тэгэхээр байгалийн нөөц ашигласны төлбөр бол орон нутгийн төсөв рүү ордог. Жишээлэхэд хамгийн багадаа гэхэд өнгөрсөн 220 тэрбум төгрөг орж байгаа. Орон нутаг бол ингээд бид энэ орон нутаг руу орж байгаа төсвийг хэдэн хувь нь яг Байгаль орчиндоо зарцуулж байна вэ гээд ерөнхий нэг дүгнэлт хийгээд үзэхэд аймгууд бол нэг 60 орчим хувиа бол яг энэ мөнгөнийхөө Байгаль орчинд зарцуулаад байна аа.

Тийм учраас энийг одоо 100 хувь зарцуулдаг болох энэ ажлыг хийнэ. Ингээд энэ жишээлэхэд манай 2023 оны зүгээр дүнгээр үзэхэд 42 тэрбум төгрөг ингээд.

С.Ганбаатар: Одонтуяа гишүүнд нэг минут нэмж өгье.

С.Одонтуяа: 2023 оны дүнгээр бол энэ 42 тэрбум төгрөгийг зарцуулсан байгаа юм 60-ыг зарцуулахаас. Тэгэхээр энийг 21 аймагт хуваагаад үзэхэд нэг аймаг бол 2 тэрбум төгрөг бас зарцуулсан байна 2023 онд. Тэгэхээр бас Байгаль орчиндоо энэ аймаг орон нутгууд нэлээд мөнгө зарцуулдаг болсон байна. Тэр Ёлын амны талаар бас та яг зөв хэллээ. Очиход жуулчид очиход 00 байдаггүй гээд. Тэгээд сая бид энэ Өмнөговь аймгийн удирдлагуудтай зөвшилцөж байгаад энэ Ёлын аманд энэ менежментийн гэрээгээр өөрөөр хэлбэл төрийн зарим чиг үүргийг нь хувийн хэвшил хийж гүйцэтгэхээр хувийн ААН-тэй дэмжих гэрээ хийсэн байгаа. Энэ гэрээ бол энэ байгууллага бид нар 2 тэрбум орчим төгрөг энд оруулмаар байна. Тэр боловсон нолийг нь хийе ээ. Энэ мөс нь багасаад байгаа хэсэг дээр бид нар бас нэг ийм шинжлэх ухааны хийхээр зүйл байна энийг хийж өгье. Тэгээд энэ аялал жуулчлалын.

С.Ганбаатар: Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр байгалийн нөөцийн төрөл зүйл энэ Байгаль орчныхоо нэрийг бариад олон төсөл авч хэрэгжүүлсэн л дээ. Оносон ч зүйл бий байх, алдсан ч зүйлүүд байгаа байх. Тэгэхдээ мэдээж энэ хэрэгжиж байгаа юмнууд дээр нэг бодитой дүн шинжилгээ хийж байгаа болов уу гэж би ингэж бодож байна. Тэгэхээр эндээс бид анхаарах ёстой асуудал юу байна вэ гэхээр зэрэг энэ байгалийн нөөцийн төрөл зүйл болгон дээр хэрэгжүүлээд байгаа юмыг төсөлтэй нь цуг булшилчхаад болж өгөхгүй байгаа юм. Яг үнэнийг хэлэхэд. Төсөл дууслаа. Тэнд хэрэгжиж явсан бүх юмыг бид зогсоочоод болж өгөхгүй байгаад байгаа юм. Гэтэл үндэсний хэмжээнд тэр хэрэгжүүлсэн төслүүдээс бид тодорхой зүйлүүд авч үлдэх ёстой. Эрх зүйн орчноо яаж сайжруулах, ёстой юм, бодлого, үйл ажиллагаагаа, арга механизмаа яаж авч явах ёстой юм, менежментээ яаж сайжруулах ёстой юм, хяналтын тогтолцоогоо яаж бий болгох ёстой юм гээд олон зүйлүүдийг бид энэ Байгаль орчин руу гэдэг юм уу, тухайн тэр чиглэл рүү нь хэрэгжүүлээд аваад явах бололцоо байгаа. Энэ чиглэлийн юм юу байна вэ? Ер нь энэ олон төслүүдээс

үндэсний хэмжээнд бодлогын зөвлөмж болгоод аваад үлдээд тэгээд одоо нэг ийм үр дүн энэ салбарт ийм юм гарлаа гэдэг юм ер нь юу байна вэ гэдэг нэг ийм зүйл байгаад байгаа юм.

Хоёр дахь зүйл. Цаашид бид энэ Байгаль орчныг хамгаалах гэдэг юм уу, экосистемийн тэнцвэртэй байдлыг хангах, энэ биологийн олон төрлийг хамгаалах асуудал байна уу? Тэгэхээр 2 зүйл байгаад байх шиг байна гэж. Тэр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль гэж нэг урт хууль байдаг юм. Тэрүүгээрээ орж ирж байгаа тэр орлогоо буцаагаад тэр зарцуулдаг хувь хэмжээгээр нь зарцуулах үйл ажиллагааг нь нэгдүгээрт нэлээн хатууруулах хэрэгтэй байна.

Хоёрдугаарт энэ орон нутгуудад яг ийм зүйл хийх ёстой юм гэдэг шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогын зөвлөмж тэр чиглэлээрээ хангах юм чинь дутчихаад болж өгөхгүй байгаа ний нуугүй үнэнийг хэлэхэд. Энэнээс болоод алдаж оноод байгаа юмнууд зөндөө байгаа. Энүүн дээрээ одоо та бүхэн энэ гар зарцуулж байгаа хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр ер нь юу бодоод байна вэ? Энэ нэг зүйл дээр нэг юм асуумаар байна.

Дараагийн нэг зүйл энэ хүлэмжийн хийн тухай сүүлийн үед их ярих болж. Дүйцүүлсэн хамгаалалтын тухай их ярих болчихлоо. Хүлэмжийн хий ялгаруулаад байгаа энэ дэлхийн том корпорацууд гэдэг юм уу, аж ахуйнууд өөрийнхөө ялгаруулж буй тэр хийтэй дүйцсэн хэмжээний хийн ялгарлыг бууруулах чиглэлээр улс орнууд руу маш том хөрөнгө оруулалт хийдэг болчихсон байна. Монгол Улс энэнээс олж авах талаар ер нь юу бодож байна аа? Өнгөрсөн жил Байгаль орчны яам руу би нэг тодорхой төслийн байгууллагыг.

С.Ганбаатар: Нэг минутад нэмээд өгье.

Ж.Батжаргал: Дундговь, Говьсүмбэр, Төв аймгийн 6 сум билүү дээ. Би тэгж санаад байна. Тэнд тэр хүлэмжийн хийн ялгарлын тоолох технологийн техникийн чадамжийг бий болгох тухай асуудал, буцаагаад тэр 6 сум дээр тодорхой хэмжээний тэр гаднын одоо хөрөнгийг оруулж ирж ургамалжуулах гэдэг юм уу хүлэмжийн хийн ялгарлын өөртөө шингээх тэр ногоон массыг бий болгох чиглэл дээр тодорхой арга хэмжээ авъя гэсэн. Би тэрийг бол ер нь Монголын цөлжилттэй тэмцэх хамгийн тов зөв, арга барил хэлбэр рүүгээ санаа нь чиглэчхэж байгаа юм уу даа гэж харсан. Энэ тал дээр явсан ажил гэдэг юм уу судалгаа юмнууд нь хэр явагдаж байна вэ гээд нэг ийм 3, 4 зүйл дээр их тодорхой хариулт авчихмаар байх юм.

С.Ганбаатар: Батжаргал гишүүн 4 асуулт асуулаа. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Батжаргал гишүүний асуултад хариулъя аа. Тэгэхээр энэ төсөл дуусаад энэ бүх ажиллагаа зогсчихдог оо гэдэг бол санал нийлж байна аа. Ер нь бид бол бас энэ Байгаль орчны салбараа байнга онцгой анхаарч байхгүй бол дандаа гаднын төсөл хэрэгждэг юм чинь гээд ингээд хаяж болохгүй байгаа. Тэгээд маш олон сургалтуудыг хөдөө орон нутагт хийж байгаа та нарын энэ тайлан дээр байгаа байх. Тэгээд зарим хүмүүс энэ их олон сургалтаар яадаг юм гээд байдаг. Гэтэл энэ олон улсын төсөл хэрэгжүүлэгч нар юу гэж тайлбарладаг вэ гэхээр бид нар төсөл дуусахаас өмнө одоо энэ нутгийн иргэд Байгаль хамгаалагчид энэ салбарт ажилладаг хүмүүсийг бол бүрэн сургаж, дараа энэ төслийг өөрсдөө бие даагаад аваад явах ийм боломжтой болгоно гэж. Ийм зорилт тавиад явдаг. Манай салбарт бол сүүлийн үед ер нь боловсон хүчний дутагдал байнга байгаа. Энэ салбарт энэ мэргэжлээр дээд сургуульд сурдаг хүний тоо байхгүй болсон. Ойн

мэргэжлээр төгсөж байгаа жилдээ нэг тав, зургаахан хүн нь голцуу хувийн компанид ажиллаад ингээд явчих жишээтэй. Тэгэхээр бид бол энэ дээр энэ боловсон хүчнийг дэмжих чиглэлээр тэтгэлэг олгох энэ чиглэлийг судлаад явж байгаа. Тэр менежментийн би түрүүн хэлсэн. Энэ Тусгай хамгаалалттай газрын тухай хуульд энэ менежментийн нэгжийг бид нар байгуулъя гэж оруулж ирж байгаа. Энэ бол юу вэ гэхээр улсын төсөвт дарамт учруулахгүйгээр давсан орлогоосоо зохицуулаад энэ бүх ТХГН-т менежментийн үйлчилгээ үзүүлдэг. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр нь хангадаг ийм менежментийн нэгдсэн ийм нэгжтэй болъё гэж энэ хуульд орж байгаа. Байгалийн нөөц ашигласны төлбөр дээр бол тантай санал нэг байна. Энийг бол яг чиг үүргийг нь зааж өгөх ёстой, хатууруулах ёстой гэж.

Тэгэхээр энэ дээр манайд бол яг 2024 оны үйл ажиллагаан дээр аудитын дүгнэлт хийж байна. Яг ямар сум, яг аль аймаг энэ байгалийн нөөц ашигласны төлбөрийнхөө мөнгийг ашиглаж байна уу, зориулалтын дагуу ашиглаж байна уу гэдгийг аудит хийгээд энэ 2024 онд дуусах юм аа. Карбон кредитийн хувьд бол манай хүмүүс бол сая энэ чиглэлээр маш олон зүйлүүд мэдсэн байгаа. Тэгэхээр энэ дээр нэмээд хариулна биз. Ер нь олон жил ингээд ярьсан ч гэсэн манай дээр эрх зүйн орчин ерөөсөө байхгүй. Одоо гадаадын маш олон хүмүүс ирээд уулздаг. Карбон кредитээр уулзъя, карбон кредитээр уулзъя гэдэг. Яг бид нарт яг энэ та карбоноор уулзах гэж байгаа бол ийм ийм хууль, эрх зүйн орчинтой шүү гэдэг юм нь байдаггүй. Яах вэ бусад оронд ийм дутмаг байдаг юм байна. Тэгээд сая тэр Азербайжанд болсон уур амьсгалын өөрчлөлтийн хурал дээр яг энэ карбон кредитийн стандартыг бол баталсан байгаа. Тэгэхээр энэ дээр бол бид нар ажиллаад эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар Эдийн засаг хөгжлийн яамтай ажиллаж байгаа.

Ер нь сүүлийн үед бол сая Батжаргал гишүүн хэллээ. Энүүгээрээ бид нар маш их боломж байна шүү дээ гэдэг. Энэ маш их боломж байгаа. Одоо улс орнууд бүр өрөө наймаалцаад эхэлдэг эхэлдэг болсон. Энэ манайх тэчнээн оноог нь авъя. Тэгээд танайд өрийн тэдэн хувийг хаая ч гэдэг юм уу ийм бүүр эдийн засгийн маш том зах зээл болчихсон. Тэгэхээр бид энэ дээр хоцрогдоод байгаа учраас манай дээр энэ карбоноор мэргэшсэн маш олон мэргэжилтнүүд, зөвлөхүүдийн багийг бид нар ажиллуулж байгаа. Тэгээд нэмээд хариулчих уу?

С.Ганбаатар: 9 номер дэлгэрүүлж нэмж хариулъя.

Ж.Чойханд: Намайг Чойханд гэдэг. Би Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа хамтын ажиллагааны төв. Батжаргал гишүүний асуултад хариулахад нүүрстөрөгчийн сайн дурын зах зээлийн тухайд бол бид гаднын байгууллагуудтай бас хамтран ажиллах санамж бичиг байгуулаад энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлуудыг эхлээд явж байгаа. Мэдээж тодорхой хэмжээний авах хэмжилт судалгааны үр дүнд энэ ажлыг одоо цааш нь яг албажуулж явуулах ёстой. Өнөөдөр бол зөвхөн газар дээрх хөрсний дээж авах, судалгааны ажлууд хийгдээд явж байгаа. Ер нь бол энэ зах зээлийн зарчмаар нүүрстөрөгчийн давхар ислийг бууруулах санал санаачилга сайн дурын болон албан ёсны одоо Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хийгдээд явж байгаа. Эндээс Монгол Улс тодорхой хэмжээний санхүүжилт хөрөнгө оруулалтыг татах бүрэн боломжтой гэж хэлэхээр байна аа.

С.Ганбаатар: Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм ээ энэ бид нар одоо ингээд энэ олон төслийг яривал замаа алдсан юм болно. Тэгээд ганц нэг юман дээр нь тогтох ёстой. ТХГН-ийнхаа хамгаалалтын менежментийг зөв болгоё гээд яг бэлэн жишээ энэ хажууд Хустай байгаад байгаа юм. Энүүнийг нэвтрүүлээдхээч ээ гээд. Тэгэхээр өөрөө амьдардаг тийм орчныг нь бүрдүүлэх тухай асуудал байгаад байгаа юм байна лээ. Тэгэхээр хамгийн их хөдлөлттэй гэдэг юм уу, хамгийн их орчил эргэлтийг өөр дээрээ авч байгаа тусгай хамгаалалттай газрууд дээрээ тэр хамгаалалтын захиргаа гэдэг юм уу баг нь ажиллах хэмжээний орлогын бүрдлийг бий болгож чаддаг тэр үйл ажиллагааных нь чиглэлийг тодорхой болгож өгөөд, тэгээд тэр хувийн хэвшил гэдэг юм уу мэргэжлийн байгууллагынхаа түвшин дээр явуулаад байвал болохоор. Тэгэхээр энэ талын судалгаа тооцооллыг илүү нарийсгаж хийж байгаа зүйлүүд та бүхэн дээр юу байгаад байгаа юм. Сая Наранбаатар гишүүн бид 2 ярилаа шүү дээ.

С.Ганбаатар: Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Өдрийн мэнд хүргэе. Манайх шиг ийм том газар нутагтай улсад бол энэ Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүд, нэлээдгүй олон зүйлүүдийг бас шийдвэрлэхэд хяналтаа тогтооход судлахад нөлөө үзүүлдэг гэдэгтэй маргахгүй. Гэхдээ бид энэ төсөл хөтөлбөрүүд дээр хяналттай гүйцэтгэлд нь хяналттай байх ёстой гэж ингэж бодогдож байна. Яагаад гэвэл өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн тоо, дүнг сонсоход бол бас нэлээдгүй л их хөрөнгө оруулалтууд энэ төсөл хөтөлбөрөөр дамжиж ордог юм байна гэж ингэж харагдаж байна. Тэгээд эхний асуулт бол ер нь нөгөө бэлгийн морины шүдийг үздэггүй гэдэг шиг төсөл хөтөлбөр хэрэгжиж л байвал сайн байна гэдэг агуулгаар биш, энэ боломжийг бид яаж авч үлдэж байна вэ гэдэг дээрээ илүү анхаарлаа төвлөрүүлэх нь хэрэгтэй байх.

Тийм учраас сая бас Лувсанжамц гишүүн хэлж байна. Энэ төсөл хөтөлбөрүүдийн үр дүн яаж гарсан юм бэ гэдэг дээр зөвхөн танилцуулга хэрэгжүүлэх нэгж. Энийг яриад байхаасаа илүүтэйгээр үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг би Байнгын хороонд энэ нэг 28 төсөл дээрээ гаргаад өгөөсэй гэж ингэж бодож байгаа юм. Тэгээд араас ирүүлье гэдэг энэ юм юм бол яг энэ хариуцсан албан тушаалтнуудын зүгээр л нэг ам дагуулаад л хийж байгаа ам мэх шүү дээ. Ер нь араас явуулъя гэж. Авдаг ч хүн байдаг ч юм уу, үгүй ч юм уу.

Тийм учраас би тэр Байгаль орчны яамны холбогдох албан тушаалтнуудад бас энийг хэлж байгаа юм аа. Эхний асуулт бид ингээд Байгаль орчин дээр хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийг эрэмбэ дараатай байлгах ийм бололцоо байдаг уу? Хэдийгээр сая сайдын танилцуулга дээр гаднынхан ирээд л энийг хийнэ ээ л гэдэг ингэдэг тэгээд л тэрийгээ хийгээд л явдаг юм шиг ийм тайлбар хэлж боломгүй байгаа юм аа.

Жишээ нь одоо Байгаль орчныг хамгаалах асуудал дээр улс нийтийн асуудал энэ бүх сум суурины хогийн асуудал шүү дээ. Нэг ч очоод энэ ёстой мундаг хогоо шийдчихсэн байна шүү гэх газар Монгол Улсын энэ 330 сумд нэг ч байхгүй. Бүгд нэг өдрөө аргацаагаад л ингээд л нэг булж бариад л ингээд л явж байгаа. Жишээ нь би яагаад тэр төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг тодорхой хэмжээнд гаргаач гэж байна гэвэл энэ Улаанбаатар хотод хэрэгжсэн гэж байгаа энэ Италийн төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Италийнх гэж байгаа. 3.5 сая евро гэж байгаа. 2025 онд дуусна гэж байна. Хэрэгжээд 3, 4 жил болчихсон юм байна гэж ойлгож байгаа. Хийсэн ажлыг нь харахаар цэвэрлэгээ хийсэн 500 хүн оруулсан, 5 удаагийн арга хэмжээнд 500 хүнд мэдлэг олгосон. 2025 онд юу хийх вэ гэхээр олон нийтэд таниулна. Экологийн

олимпын 2 дугаар үе шатыг зохион байгуулаад энэ төсөл дуусгана л даа. Төгрөгөөр ярих юм бол 12, 13 тэрбум төгрөгийн асуудлыг тэгэхдээ арай ч ийм болчхоогүй байлгүй.

Тийм учраас бид бас энийг ингэж нэг бүрчлэн энэ гаднын төсөл хөтөлбөрүүдийн санхүүжилтийн үр дүнг бас ярих ёстой байх гэж ингэж бодож байгаа юм.

Хоёр дахь асуудал юу байна вэ гэхээр.

С.Ганбаатар: Идэрбат гишүүн нэмж асуулт тодруулж асууя.

Ц.Идэрбат: Энэ төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд манай зүгээс бас тодорхой төсвийн даалгавар авдаг уу? Бид санхүүжүүлэлтийн тодорхой хувийг хариуцдаг уу? Энэ төсөл хөтөлбөрүүдээс хэдийг нь Монгол Улсын Засгийн газраас тодорхой хувийг нь санхүүжүүлж байгаа вэ гэдгийг би асууя гэж ингэж бодож байна аа. 2 асуулт.

С.Ганбаатар: Идэрбат гишүүний асуулт дээр хэлэхэд бүх гишүүд анхаараарай. Өнөөдөр Үндсэн хуулийн 20 дугаар заалт дээр гагцхүү Улсын Их Хурал, төсөв батлах, хууль батлах эрхтэй гэж байгаа, гагцхүү. Тэгээд энд нэгдсэн төсөв дотор энэ зээл тусламж бүгд орж байгаа. Хуулийн хэрэгжилтийг хянаана зүгээр одоо нэг мэдээлэл гуйгаад араас нь нэг хэдэн төгрөг гэж явахгүй. Энэ олон их наяд төгрөг. Олон 100 сая доллар. Тэгэхээр энэ болгон дээр ажлын хэсэг хяналтын ажлын хэсэг гаргаж гишүүд их олуулаа оролцож, энэ дээр ганцхан Байгаль орчин биш, Хүнс, хөдөө аж ахуйн яам, аж үйлдвэржилттэй холбоотой бүх яамдуудыг бас энэ дээр ажлын хэсэг гаргаж оруулна аа. Энийг өөр биднээс өөр хэн ч анхаарч араас нь ингэж мөшгөж энэ мөнгө ер нь эцсийн эцэст 70 хувь нь консалтинг сервист л явж байгаа шүү дээ. Зөвлөгөө өгөх сервист л буцаагаад гараад явчхаж байгаа судалгаатай байгаа. Энэ асуудлыг ярина аа. Энэ асуудал дээр хяналтын ажлын хэсэг байгуулна.

Ингээд асуултад 5 номерын микрофон дээр хариулт өгье.

Ү.Энхтайван: Ерөнхийдөө олон улсын байгууллагуудын санхүүжилт хийгдэхдээ нөгөө Кофайнансийн буюу Монгол Улсын тодорхой хэмжээний санхүүжилтийг зэрэгцэн хийх ийм шаардлагуудыг тавьдаг болсон. Яагаад вэ гэхээр Монгол Улс бол хөгжиж байгаа орны зэрэглэлд орсон ийм улс байгаа. Тийм учраас бол олон улсын шаардлагууд бид бүхэн тодорхой хэмжээний санхүүжилтийг заавал хийж байхыг ингэж шаардаж байгаа. Мэдээж Байгаль орчныхоо чиглэлийн төсөв санхүүжилтийг бид бүхэн гаднаас нэмэгдүүлье ээ гэх юм бол улсынхаа оролцуулах тодорхой хувь нэмрийг нэмэгдүүлэх шаардлагатай.

Одоогийн байдлаар 172.2 сая ам.долларын төсөл 2018-аас 2028 оны хооронд хэрэгжиж байгаа. Энэтэй дүйцүүлээд манайх 102.4 сая ам.долларыг бол зэрэгцүүлэн хийж байгаа. Тэгэхдээ манайх бол санхүүжилтээ хийхдээ бэлэн бэлэн бус хэлбэрээр хийгдэж байгаа. Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээнд Байгаль орчны салбарт орж байгаа хөрөнгө оруулалтыг бид бүхэн дүйцүүлэн тооцох маягаар ингээд тооцуулаад явж байгаа. Энэ гишүүдийн маань хэлээд байгаа энэ төслийн үр өгөөжийг бий болгох гэдэг бол туйлын зөв санаа. Мэдээж энэ чинь улсын маань ямар ч хэлбэртэй байсан гэсэн улсын маань тодорхой чиглэлд хийгдэж байгаа хөрөнгө оруулалтууд учраас бид зөвхөн үр ашгаа нэмэгдүүлэх ийм зорилгоор

ажиллаж байгаа. Бид бүхэн одоо тэр Байгаль орчныхоо нэгдсэн мэдээллийн сан дээрээ л энийгээ нэгтгэж базах мэдээллүүдээ нэгтгэх чиглэлээр ажиллаж байгаа. 2025 онд бол тодорхой үр дүнд хүрнэ ээ гэж итгэлтэй төсөөлж явж байна. Саяын таны дурддаг тэр Улаанбаатар хотод хэрэгжсэн төсөл бол манай яаман дээр ямар ч мэдээлэлгүй байсан. Бид бүхэн ерөнхий мэдээллийг татан төвлөрүүлээд мэдээлж байгаа байдал нь энэ төслүүд дээр зарим чиглэлийн үйл ажиллагаануудад нь Байгаль орчны яаманд бүрэн удирдлагын хувьд шилжихгүй бид нарт бүрэн удирдагдах боломжгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр бид бүхэн байгаа мэдээлэлдээ тулгуурлаад хяналтаа тавих ийм зорилготой. Нэгдсэн мэдээллийн санг, Сангийн яам Пи Ми Си гэдэг системээр санхүүгийнх нь талаас нэгтгэх ийм систем хөгжүүлж байгаа. Бид бүхэн бол яг энэ үйл ажиллагааны үр ашиг өгөөж, түрүүн Батжаргал гишүүн маань маш чухал асуудалд дурдсан. Тэр нөгөө яг дараа нь бид бүхэнд юу үлдэх юм бэ? Улсын маань авч үлдэх үр ашиг нь юу байх юм бэ? Ямар тодорхой бодлогын шийдэл ямар чиглэлүүд бид нарт үлдэх вэ гэдэг юмыг энэ төслийн мэдэгдсэн мэдээлэл үр ашгаас л нэгтгэж харах ёстой.

Нөгөөтээгүүр цаашдын хөрөнгө оруулалтыг ч гэсэн энэ дэс дарааллууд тогтоогоод прайти тогтоогоод аль чиглэлд нь бид бүхэн хөрөнгө илүү оруулбал үр ашигтай вэ, аль чиглэлийнх нь хөрөнгө оруулалт нь илүү ороод байна вэ тэрийг хэрхэн яаж зохицуулах вэ гэдгийг шийдэх боломжтой. Тэгэхээр энэ бүгдийг нэгдсэн тийм мэдээллийн санг бид бүхэн 2025 онд үүсгэчихнэ ээ гэсэн ийм төлөвлөгөөтэй байгаа. Одоогоор тэр мэдээллийн сан маань 53 төрлийн сантай тэгээд дотроо ерөнхий мэдээлэл цуглуулж байгаа. Тэгэхээр бид бүхэн энийг өргөжүүлээд нарийн мэдээллүүд аваад анализ хийдэг төслийн дүн шинжилгээ хийдэг ийм хэлбэр лүү шилжүүлнэ ээ.

С.Ганбаатар: Ёстой л гэж байна. Тийм юм байгаа ёстой л гэж байна. Ингээд Одонтуяа гишүүн тодруулж хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ үр дүнтэй төслүүд гээд тэгэх юм бол маш олон төслүүд байна. Сая Батжаргал гишүүн хэлсэн энэ Хустайн нуруунд тахь үржүүлэх энэ чинь маш зөв ийм жишээ болсон гээд. Энэ л бүр дэлхийд үлгэр жишээ болж байгаа. Өөрөөр хэлбэл энэ ТББ менежментээ маш сайн хийгээд ингээд ажиллаж байгаа. Тэгэхээр энэ Хустайн жишээгээр сая манай яаман дээр бид нар нийт нэг 25 газартай энэ менежментийн гэрээнд гарын үсэг зурсан. Аль болохоор одоо энэ орчны менежментийг сайжруулах дээр ажиллаж байгаа. Идэрбат гишүүний хэлсэнтэй санал нийлж байна аа. Ингээд олон сая долларын төсөл хэрэгжээд байх юм. Зарим нь нүдэнд харагдахгүй байна гэж. Тэгэхээр энэ дээр бол бас үр дүн багатай хэрэгжсэн төслүүд ч байдаг. Энийг нуугаад байх юм байхгүй. Зарим төслүүд бол яадаг вэ гэхээр гадаадын тэр зөвлөхийнх нь гол зардал явчихдаг. Танай улсад тэчнээн сая долларын төсөл хэрэгжүүлнэ гэснээ дийлэнх нь тэр зөвлөхийн.

С.Ганбаатар: Идэрбат гишүүн тод тодруулж асуугаад дараа нь Одонтуяа сайд хариулаарай.

Ц.Идэрбат: Тийм яах вэ сайн хэрэгжиж байгаа төслүүд байгаа. Одоо манай Онон Балжийн цогцолборт газрынх байна, Тосон хулстай байна. Сайн юмнууд байгаа. Гэхдээ бид санхүү ил тод байх ёстой гэсэн энэ л зарчим үр дүн байх ёстой гэсэн энэ зарчим байгаа гэдгийг хэлье. Нөгөө талдаа энэ боловсон хүчний асуудал дээр тулгамдаж байгаа асуудал байгаа гэж байгаа учраас би яг яамныхан байгаа

учраас яг анхан шатад ажилладаг Байгаль хамгаалагчийнхаа тэр томилогддог процессыг та нар нэг эргээд нэг хараач ээ. Яам нь энэн дээр санаачилга гаргаж ажиллах юм байна лээ шүү дээ. 12 дугаар анги төгссөн хүн ажиллаж болно. Байгал хамгаалах ажил бол сэтгэл шаарддаг ажил шүү дээ. Тэр хүнээс төрийн албаны шалгалт авна гээд ингээд тамлаад байдаг. Тэгээд энэ чинь яаж ойлгогдох юм. Логикийн хувьд маш буруу. Тэгэхээр тэнд тэнцэж ордог Байгаль хамгаалагч гэж байхгүй. Тэгэхээр энэ бид Байгаль хамгаалах энэ үйлсийг өшөө өргөжүүлэхийн тулд энэ Байгаль орчны салбарт байгаа боловсон хүчний асуудал дээрээ та хэд анхаараач ээ. Би төрийн албаны зөвлөлийнхнөөс асуусан. Байгаль орчны яам л.

С.Ганбаатар: Одонтуяа сайд тодруулж хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр түрүүн одоо энэ гаднын төслүүд дээр тийм тохиолдол байна л даа. Нэг дүн тавигддаг, тэгээд тэр гадаадын зөвлөхийнх нь цалин мөнгө зөвлөх үйлчилгээ нь нэлээд хэмжээтэй ийм төслүүд байна. Гэхдээ энэ хогийн төсөл дээр бол манай дээр нэг Италийн төсөл хэрэгжсэн. Энэ бол дандаа нөгөө ЕБС-ийн хүүхдүүд рүү чиглэсэн танин мэдэхүй энэ хогоо ангилан ялгах энэ чиглэлийн сургалтууд нэлээд явагдсан. Байгаль хамгаалагчийн хувьд санал нэг байна. Сая хөдөө орон нутгаар явахад Байгаль хамгаалагчийн орон тоо нь бол бараг 40 хувь нь сул байж байдаг. Тэгээд ТЗ-ийн заавал ангилалтай байх ёстой гээд шаардчихдаг. Тийм учраас одоо бид бол энэ ангиллын нь өөрчлөх талаар ажиллаж байна аа. Иргэний журмаар Байгаль хамгаалагчид бол бид байгалиа хамгаалъя. Хувийн компаниуд хүртэл бид нар энэ хэдэн амаар нь ингээд байгалиа хамгаалъя гэдэг. Тэгэхээр тэд нарт бол торгохоос бусад эрхийг нь олгосон ийм.

С.Ганбаатар: Гишүүд маш чухал асуудлыг хөндөж байгаа. Энэ дээр би зүгээр нэмж хэлэхэд нэг улсын төсөв батлахад нэг 500 сая төгрөгөөр бид нэг сургуулийн засварт нэмэрлэж оруулах гээд л хоорондоо бараг барьцлаа алддаг. Энд чинь олон 100 тэрбум төгрөг их наяд төгрөг ярьж байгаа шүү дээ. Ганцхан Байгаль орчны яам биш, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Аж үйлдвэржилттэй холбоотой. Энэ мөнгөний араас хяналт тавьж үр дүнг нь шалгаж явахгүй бол 70 хувь нь зөвлөх гээд нэг хүний гадагшаа гараад явчихдаг. Дараа нь Монголын ард түмэн энийг төлдөг. Энэ дээр ганцхан буруутгах улсууд гэвэл Улсын Их Хурлын гишүүд болдог. Ингээд энэ дээр хяналтын ажлын хэсэг байгуулна.

Ингээд Бейсен гишүүн асуулт асууна.

Б.Бейсен: Энэ төсөл хөтөлбөрийн хүрээнд энэ Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч байгаа, Ардын намын ч мөрийн хөтөлбөрт байгаа, АН-ын ч мөрийн. Таван Богдын тусгай хамгаалалттай газар түшиглэсэн аялал жуулчлалын бүс байгуулна гээд тусгачихсан байгаа. Гэтэл өндөр хүчдэлийн асуудлыг нь шийдээд Таванбогд хүрчихсэн энэ жил бүрэн ашиглалтад өгөх юм. Даянгийн чиглэлээр тэр Хотон хурга нуур тийшээ өндөр хүчдэлийг нь шийдчихсэн. Энэ зундаа ашиглалтад өгчих байх. Гэтэл та нарын бодлого чинь Засгийн газрын бодлого уялдахгүй байна. Ерөөсөө ерөөсөө хэрэгжүүлэхгүй төслөө нэг хэдэн зарим улс төржсэн ч гэх юм уу тийм байдлаар хэрэгжүүлдэг. Өнгөрсөн 4 жил би Бат-Эрдэнэ сайд энэ тэрийг гуйгаад та нар энэ өнгөрсөн жил юунд яамны бүрэлдэхүүнд байсан улсууд мэдэх байх. Тэр отоглох газар, хог хаягдлын цэг, ариун цэврийн байгууламж байгуулж өгнө оруулна гээд яг энэ юун дээр хэлсэн. Одоо хүртэл байхгүй. Маш ихээр Байгаль бохирдож байна, ус бохирдож байна, ариун цэврийн байгууламж байхгүй, отоглох цэг байхгүй, хоолны газар буудал ч байхгүй. Ийм юутай. Яагаад гэвэл тэнд чинь Таванбогд, Хөх хөтлийн хадны сүг зураг, Хотон Хурган нуур,

Хүрхрээгийн чухал газруудаар энэ Сүүн гол гээд ингээд явдаг. Гадаад дотоодын 30-аас 40 мянган жуулчин очиж байна. Энийг яагаад энэ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхгүй байна? 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ яамныхан Байгаль орчныхон очсон юм болов уу гээд. Асгат Сийлхэмийн нурууны асуудал байна. Ховд, Увс, Баян-Өлгийн яг зааг дээр. Хэдэн жилийн өмнө энэ хил хамгаалах байгууллагад голын цаад талаар манай Монголын хил байсан. Одоо голыг нь наад талаар нь татсан. Тэнд 10-аас 15 км газар ой сүйтгэчихсэн байгаа. 60, 70 онд мод бэлтгэх зорилгоор ёстой ой байхгүй модны тайрдас л байж байгаа. Тэрүүгээр нь түлээ бэлдээд дахиж ойжуулах асуудал байгаа юм. Тэнд чинь ирвэс байгаа, янгир байгаа, аргал, ятуу гээд маш ховор ан амьтны шувууд байж байгаа. Тэгэхээр энэ төсөл хэрэгжүүлж болохгүй юм уу та нар очиж үзсэн үү 1 дүгээрт.

Нөгөө талаар энэ сая Таванбогд явах замын асуудал байж байгаа. Хүн байхгүй байх тэр хамгаалалтын цэгээс цаашхан замыг нь засах тал дээр юу төсөл хэрэгжүүлж болдоггүй юм уу? Очиж байгаа жуулчид машинаа ч эвдэж байна байгалиа ч сүйтгэж байна. Энэн дээр яагаад анхаарлаа хандуулахгүй байна?

Би нэг минут сунгаад авчихъя. Дараа нь энэ цөмийн радиацийн асуудал байгаа. Цеми Палатинскийн жаран хэдэн онд цөмийн туршилт хийсний дараагаар Таванбогдоос авхуулаад Ховд, Баян-Өлгий аймгийн нутаг бүхэлдээ Ховдын нутаг, Увсын нутаг, Хамраад бүүр Завхан хүрсэн гэж байгаа шүү дээ. Үйл нь тэр үед тэр байсан зарим ан амьтан дүрвэж яасан. Нөгөө талаараа энэ 90 оны сүүлээр бид нар судалгаа хийлгэсэн радиаци өндөр байна гэсэн. Ховдын энэ яг цаад талд нь Хятадын нөгөө цөмийн туршилтын юу байгаа. Энд нэг их мөнгө шаардахгүй шүү дээ. Энэ радиацийн юуг судлах боломж бий юу? Ер нь энэ талаар асууя.

С.Ганбаатар: Чухал асуулт асуулаа. Асуултад 7 номерын микрофонд хариулт өгье.

П.Батхишиг: Гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх тал дээр бид нар төлөвлөгөөндөө тусгаад ажиллаж байгаа. Гэхдээ бид Байгаль орчны нарийвчилсан үнэлгээнийхээ дүгнэлтийг гол шалгуураа болгож тавьдаг ийм хуультай, зохицуулалттай байж байгаа. Энэ дээр хэрэгжүүлж байгаа тэр отог болон тэр нолийн байгууламжийн асуудал болохоор чинь бид нар гадаадын зээл тусламжаар хэрэгжихгүй юмнуудаа улсын төсөв дээр хэрэгжүүлдэг. Ингэж хэрэгжүүлэхдээ АМНАТ-ийн хуулийн 50 хувиас орж ирсэн орлого маань Уур амьсгалын санд төвлөрдөг байсан. Энэ төвлөрсөн жоохон мөнгөө бид нар аль болох энэ төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх иймэрхүү арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөөд ингээд хэрэгжилтийг хангаж ажилладаг байсан бол энэ 2025 оны төсвийн энэ жилд энэ сан маань урсгал зардалтайгаа цуг хасагдаад тэглэгдсэн байж байгаа.

С.Ганбаатар: 3 номер гүйцэд хариулт өгье.

Б.Оюунсанаа: Бейсен гишүүний асуултад хариулъя. Ойтой холбоотой хэсэг дээр Оюунсанаа Ойн газрын дарга. Улсын тэр зааг дээрх 15 га ойн талбайн дээр би тодруулаадахъя. Яг одоогоор мэдээлэл байхгүй байна. Ямар юуны улмаас энд сүйдсэн гэдэг дээр тодруулаад хийгээдэхье ээ. Мэдээлэл аваагүй байгаа энэ дээр.

С.Ганбаатар: Цөмийн радиацийн асуудал асуугаад байсан шүү. Тэрэн дээр хариулах хүн байна уу? Одонтуяа гишүүн хариулъя.

С.Одонтуяа: Баян-Өлгий аймгийн хувьд бол энэ та сая нөгөө замын асуудлыг ярьсан. Тэгэхээр одоо манай энэ Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа буюу өмнө нь хэрэгжүүлж байсан төслүүдийг ингээд харахаар ерөөсөө замд бол төсөл зам тавих ч юм уу тэр төсөл бол ер нь их хэрэгждэггүй. Ийм байгаа энэ тайлангуудаас харахад.

Тэгэхээр энэ олон улсын байгууллагууд голцуу л энэ биологийн олон янз байдал, амьтан ургамал, энэ бэлчээрийн тогтвортой байдал гэсэн ийм зүйлүүд рүү оруулаад байгаа. Алтай Таванбогдын хувьд бол Баян-Өлгий аймгаас сонгогдсон гишүүд надад хэлж байсан.

Алтай Таванбогд дээр маш их жуулчны урсгал байгаа. Тэгээд аюулгүй байдлыг нь хангах шаардлагатай учраас тэр Германы төсөл дээр байгаа нөгөө ТХГН-ийн.

С.Ганбаатар: Бейсен гишүүн тодруулъя. Дараа нь Одонтуяа гишүүн тайлбар өгье.

Б.Бейсен: Тэр Сийлхэмийн нуруун дээр тэр Асгат явах хавцал нэлээн хол газар л даа. Энийг чинь 60, 70-аад онд ААН-ийн барилгын нуруу мод бусад мод материалын хувьд бэлдчихсэн юм байна л даа. Тайрсан та нар энд явж үзээгүй байх очоод үзэх хэрэгтэй. Хараад уйлмаар л санагдаж байгаа юм чинь ёстой. Тэрний энэ тайрсныг түлээ мод бэлтгээд нөгөөдхийг нь ашиглах боломж байгаа. Дахиад ойжуулах асуудал байгаа байхгүй юу тэрэн дээр. Ерөнхийлөгчийн тэрбум модын хүрээнд тэнд ойжуулах асуудлыг танай энэ төсөл хөтөлбөрийн хүрээнд хийж болно, нэгдүгээрт.

Хоёрдугаарт сая нөгөө ариун цэврийн байгууламж хог хаягдлын цэг гээд ноднин хэн Бат-Эрдэнэ сайд хулхидаад тэгээд гол гаргасан л даа. Энэ нэг хөдөлмөрийн хүрээнд та нар хэрэгжүүлэх боломж бүрэн байгаа гэж бодож байна. Гадаад дотоодын олон жуулчид явж байгаа шүү тэнд.

С.Ганбаатар: Одонтуяа гишүүн тодруулж хариулъя.

С.Одонтуяа: Энэ чиглэлээр төсөл хэрэгжиж байсан. Өмнө нь нөгөө Аялал, жуулчлалын яам бол манай яамтай хамт байхад энэ нэлээн олон газар яг энэ аялал жуулчлалын тогтвортой аялал жуулчлал гэсэн энэ хөтөлбөр хэрэгжсэн. 7 дугаар сард нөгөө яам аялал жуулчлалын бодлого, аялал жуулчлалын яам руу тусдаа шилжсэнтэй нийлсэнтэй холбогдуулаад энэ бүх төсөл хөтөлбөрүүд бүгд Аялал жуулчлалын яам руу шилжсэн байгаа. Тэнд боловсон энэ эко нолийн асуудлууд энэ тэр мөн отоглох цэг, гаднын жуулчид ирэхэд ая тухтай байх гэсэн ийм нэлээд олон төслүүд бол энэ хэрэгжиж, дөнгөж хэрэгжих шатдаа явж байгаа.

С.Ганбаатар: Бейсен гишүүн тодруулъя.

Б.Бейсен: Аялал жуулчлалаасаа гадна Байгаль орчны бохирдлын асуудал байна. Тусгай хамгаалалттай газрын. Засгийн газрын бодлоготой ерөөсөө уялдахгүй байна. 2 намын мөрийн хөтөлбөр ч байгаа шүү дээ. Тэр ариун цэврийн байгууламж, отоглох цэг, хог хаягдлын цэг гээд энэчээ ёстой байхгүй. Энэ бүх юм

бохирдож байна шүү дээ. Энэ дээр чинь төсөл хөтөлбөр дээр бүрэн хамрагдах боломжтой юм шүү дээ. Энэ тал дээр ямар бодлого барих вэ танайх.

С.Ганбаатар: Тодруулж хариулъя. 4 номерын микрофон.

П.Батхишиг: Тэгэхээр сая Бейсен гишүүний хэлж байгаа санал бол бид нарын дараа дараагийн төслүүдийн саналд оруулах ёстой зүйл гэж харагдаад байна л даа. Ер нь яах вэ бид нар ганц нэг аймгуудын, ганц нэг яамдуудын тавьсан саналын хүрээнд одоо хэрэгжиж байгаа төслүүд дээр бас тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах саналууд тавьсан хэдий ч эд нар дор хаяж удирдах зөвлөлөөрөө шийдвэр авахад 6 сараас нэг жил зарцуулдаг гэнгүүт нь бид нар ганц нэг дээр саналуудаа буцаагаад татсан. Яах юм одоо явж байгаа төслүүдээ энэ мөнгөнд нь тааруулаад үр дүнтэй дуусгачихгүй бол дахиад хаашаа явчих юм бэ гээд. Гэхдээ одоо бид нар дахиад 2025, 2026 онд юу хэрэгжүүлэх вэ гэдэг саналуудаа авч байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ энэ зарим гишүүдийн нэмж хэлж байгаа тэр төслүүдийн санааг оруулаад ярих нь зүйтэй байх гэж харж байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Хогны асуудал дээр Одонтуяа сайд тодруулж хариулъя.

С.Одонтуяа: Хогны асуудал дээр хэд хэдэн том төсөл явж байгаа. Энд бол хэрэгжүүлэгч нь бол янз л байгаа НЗДТГ байна. Юуных нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам байна. Нийслэлийн байгууллагуудад бас хэрэгжүүлэх ийм 6 гол том төсөл байгаа. Энэний нэг нь Улаанбаатар хотын хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах төсөл Азийн хөгжлийн банкных хэрэгжсэн. Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлын цуглуулалт тээвэрлэлтийн менежмент төсөл гээд энэ Швейцарын хөгжлийн банкнаас биш ээ хөгжлийн агентлагаас хэрэгжээд дууссан, хатуу хог хаягдлын байгууламжийг шинэчлэх төсөл гээд 2019-2021 онд энэ Европын банкаар хэрэгжсэн, Азийн хөгжлийн банктэй бас хог хаягдал ба уур амьсгалын өөрчлөлт төсөл, Хог хаягдлаас үүдэх ил шаталтыг бууруулах төсөл.

С.Ганбаатар: Энэ олон төслүүд дээр ТУЗ гэж яамдуудаас орсон хүмүүс байгаа. Тэд маань эх орныхоо төлөө энэ их олон 100 сая долларыг маш үр дүнтэй эх орончоор сайн зарцуулж байгаа гэдэгт бид итгэлтэй байгаа. Гэхдээ нэгдсэн төсөвт орж батлагддаг энэ зээл тусламжуудын араас хөөцөлддөг гишүүд байдаг. Араас нь хянах ёстой хуультай юм гэдгийг ойрын үед хяналтын ажлын хэсэг гарч ажиллана гэж би найдаж байгаа. Ингээд Батлут гишүүн асуулт асууя.

Д.Батлут: Оройн мэнд хүргэе. Өнөөдөр бас их чухал асуудлууд хэлэлцэж байгаад их баяртай байна. Гэхдээ жоохон харамсалтай зүйл байгаа. Энэ Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа 28 төсөл арга хэмжээ гаднын хөрөнгө оруулалттай. Тэгээд хэрэгжсэн санхүүжилтийн дүн гараад ирэхээр тоймгүй их мөнгө байна л даа. Зөвхөн нэг салбарынх шүү дээ. 36 сая доллар орчим 3.6 сая евро орчим, 83 орчим тэрбум төгрөг гээд. Ингээд тоймлоод үзэх юм бол. Энэ мөнгийг ингээд үр дүнтэй зарцуулах юм бол энэ гишүүдийн яриад байгаа олон асуудлуудыг шийдчих боломжтой юм шиг харагдаад байгаа юм. Гэхдээ 28 энэ төслийн үр дүнг ингээд харахлаар нэг үсрээд л нэг гурав, дөрөвхөн төсөл дээр бага ч гэсэн нэг үр дүн гарсан юм уу л гэж харагдаж байна. Тэгэхээр Одонтуяа сайд энийг ер нь нэг бодлоготойгоор цэгцлэхгүй бол үнэхээр болохоо байсан байна шүү гэдгийг хэлмээр байна. Одоо бод л доо та бүхэн ингээд 3.5 сая еврогоор хог боловсруулах менежментийн хөтөлбөрийг нь боловсруулаад дууссан. 30 тонн хог ингээд нэг цуглуулчхаж л дээ. Ингээд л дуусчих юм шиг байна гээд л. Бодоод үзэх юм бол энэ чинь аймаар мөнгө. Тэгээд хэрэгжиж байгаа үр дүн нь чамлалттай санагдаад байгаа

байхгүй юу. Төр бол өөрийнхөө авах хэрэгжүүлж болох юмыгаа аягүй сайн авчаж байгаа юм байна. Байгалийн одоо ашигт малтмал ашигласны төлбөрийг бол 26 хувиас 63 хувьд хүргээд авчихсан байна. Тэр төсөл аягүй сайн хэрэгжсэн байна гэтэл бусад нь байхгүй. Зүгээр нэг ийм жижүүрийн үгтэй нэг тайлбар бичсэн зүйл л байна шүү дээ.

Тэгэхээр энийг бид нар нэг яг хэрхэн хэрэгжиж ямар үр дүн гарсан юм бэ гэдэг тал дээр нь цаашлаад бид нар гаднын хөрөнгө оруулалттай төсөл хөтөлбөрүүд дээр ямар бодлого гаргаж ажиллах юм бэ гэдгээ ч гэсэн тодорхой болгохгүй бол энэ асар их мөнгө.

Дээрээс нь ингээд гарын салаагаар урсаж байгаа зүйлүүд байна гэдгийг хэлмээр байна аа. Тэгээд энэ үр дүнгүүдийг нь хараад байна л даа. Яг үндсэндээ нэг 3 дөрөвхөн төсөл дээр жижигхэн ч гэсэн үр дүн гарсан юм байна гэж харж байгаа юм. Бусад нь баахан сургалтууд.

Эцэст нь ямар үр дүнг харах вэ гэхээр баахан төрийн албан хаагчдыг сургасан байна. Мөнгөн буйл киноны Гочоогийн дүр төрхтэй нэг баахан төрийн албан хаагчтай үлдэх үү дээ бүгдээрээ. Баахан мөнгө зарж зарчхаад. Энэ бүх зүйлээ ч гэсэн бид нар яг аль салбар дээр нь ямар зохион байгуулалтаар хийх вэ гэдэг дээр ч гэсэн анализ хийж бас зохион байгуулалтад оруулж өгөхгүй бол үнэхээр болохгүй нь ээ. Тэгээд одоо гишүүн болгон л ярьж байгаа юм. Энэ төсөл хөтөлбөрүүд чинь хаагуур яаж хэрэгжээд байгаа юм бэ? Хэлэх хүн байхгүй. Гишүүд мэдэхгүй байна шүү дээ. Тэгээд мэдээлэлд ойрхон байдаг хүмүүс гэхээр хэн юм бол Засгийн газрын гишүүд юм болов уу эсвэл энэ хэлтэс, агентлаг, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хүмүүс ч юм уу? Энэ чинь явж явж байгаад нөгөө мэдээлэлд ойрхон байсан хүмүүс асуудалд ороод байгаа нөгөө нүүрсний, Хөгжлийн банкны асуудал шиг юм болж хувирах вий дээ.

Би Ганбаатар даргатай санал нэг байна. Энэ тал дээр тодорхой хэмжээний бас ажлын хэсэг оруулж ажиллуулж тодорхой мэдээллүүдийг гаргаж өгөх нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгэхээр энэ асуудлуудыг.

С.Ганбаатар: Батлут гишүүнд нэг минут нэмж өгье. Гаднын төсөл нэвтрүүлгүүд хэрэгжих нь бол сайн. Гол нь сайн хэрэгжүүлбэл сайн хэрэг. Тэгэхдээ энэ ингээд хэрэгжээд дуусангуут зогсчихдог тал бий шүү. Энэ тал дээр манай Байгаль орчны сайд тодорхой бодлого гаргаж энэ төсөл нэвтрүүлгийг үргэлжлүүлж цааш нь нутагшуулах цаашлаад авч явах боломжууд дээр ямар асуудлыг шийдэх боломжтой вэ гэдэг тал дээрээ нэг хариулт өгөөдхөөрэй.

Хоёрдугаарт нь ер нь энэ зүйлийг засах танд боломж байгаа юу? Магадгүй их олон зүйлүүд гарч ирнэ. Энэ тал дээр манай Ганбаатар гишүүний саяын санаачилга ч гэсэн нэлээн их хувь нэмэр оруулах байх гэж би бодож байна. Танд яг ийм эр зориг байна уу? Энийг шийдэх боломж бололцоо танд байгаа юу? Энэний чинь цаана асар олон асуудлууд нуугдаж байгаа шүү бас. Яг үндсэндээ бол татвар төлөгчдийн төрийн мөнгө байдаг. Эргэн төлөлт хийгдэнэ. Хэрэгжиж байгаа үр дүнд ийм жул тэгээд баахан нэг Гочоогийн дүртэй төрийн алба.../минут дуусав/.

С.Ганбаатар: Асуултад хариулъя. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр Батлут гишүүний асуултад хариулъя аа. Ер нь энэ салбарт яг энэ гадаадын зээл тусламжийг хэрхэн үр дүнтэй болгох вэ гэдэг дээр бид

чанарын шинэ түвшинд гарах болсон. Өмнө нь бол за яах вэ ингээд үнэгүй өгч байгаа юм чинь гээд л. Ингээд л нэг хэрэгжүүлсэн болдог. Энд нь үнэлэлт дүгнэлт өгдөггүй, ингээд эргэх холбоогүй ч юм уу ийм зүйлүүд маш их байсан. Тэгэхээр энэ дээр бол ер нь өөрөө салбар том учраас бид нар энэ асуудлыг яаж шийдсэн бэ гэхээр манайх зөвхөн гадаад хамтын ажиллагаа хариуцсан зөвлөх гаргасан энэ зөвлөх л бүх төслийн хүмүүстэй уулзаж байна. Гадаадынх нь хүмүүстэй уулзлаа. Манайд хэрэгжүүлсэн төсөл чинь ямар болж байна үр дүн байна уу гээд ингээд хэрэгжсэн газар нь очоод хэрэгжилтийг нь яах энэ чиглэлээр яг хэдэн сар бол манай энэ гадаад хамтын ажиллагааны зөвлөх бол ажилласан. Бүгдийг нь энэ үр дүн гараагүй байна гэж хэлж бас болохгүй. Яагаад гэхээр энэ Байгаль экологийн салбарын төслүүд чинь зарим нь нүдэнд харагддаггүй ийм төслүүд байгаа.

Тэгэхээр энэ дээр бол бас энэ ОУБ-аас гадаадын орнуудаас хэрэгжүүлсэн сайн санааны маш их тусламжууд байгаа. Энийг бол бид нар үгүйсгэж болохгүй. Жишээлэхэд мазаалай хамгаалах төсөл бол үнэхээр амжилттай хэрэгжсэн. Тархи нутагшуулах төсөл бол бүүр Прагаас цэргийн онгоцоор энэ хэдэн устах гэж байсан тахийг авчраад нутагшуулаад жил болгон л энэ дээр нь ингээд л мөнгө өгөөд л өгөөд л энэ том аж ахуйг аваад явж байгаа. Ийм одоо сайн ажиллаж байгаа юунууд байгаа. Бид нар бол яам ямар бодлого баримтлах вэ гэхээр энэ дээр дэлхийн бүх улс орнуудын сая шинэ жишиг гарсан. Төсвийн мөнгөөр төслийн мөнгөөр байгалиа хамгаалж дийлэхээ больсон. Тэгэхээр хувийн хэвшлийн оролцоог маш сайн хангах, ёстой, хувийн хэвшлийнхээ сонирхлыг төрүүлэх ёстой. Энэ одоо саяын тэр карбон зах зээлээр гэх мэтчилэн ийм зүйлүүдээр хувийн хэвшилтэйгээ л ажиллах ёстой. Тэгэхгүй бол дэлхий бол удахгүй 2030 он гэхэд өдөрт 1 тэрбум доллар зараад ч Байгаль орчноо хамгаалж дийлэхгүй болсон гэсэн ийм зүйлүүд ярьж байгаа.

Тэгэхээр бид бол энэ үр дүн гарсан төслүүд байна. Одоо манай дээр Герман улсын KFW гээд төсөл байна. Бүх сумдуудад ингээд л хэрэгтэй сумдуудад эмнэлгийн машин өгөх юм. Байсхийгээд л хөөрхий тусгай хамгаалалтынхан чинь юу байна гээд л мотоциклууд өгөх юм. Хувцас хэрэглэл өгөх юм. Ингээд сайн санааны тийм их тусламжууд зөндөө байдаг. Тэгэхдээ энэ дээр хаана нь алдаа байна, хаана нь хийдэл яваад байна хаана нь үр дүнгүй зараад байна гэдэг дээр яах аргагүй тантай санал нэг байгаа. Энэ дээр бид бол байнга ажиллаж мониторинг хийж ажиллах ийм шаардлагатай байгаа.

С.Ганбаатар: Батлут гишүүн тодруулж асууя.

Д.Батлут: Сайн яригдаж байгаа төслүүд байгааг би үгүйсгээгүй. Тэгээд танай салбараас оруулж ирсэн 28 төсөл арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой тайлан гэж нэрлээд байгаа зүйлийг уншчихаад тэгээд нэг 3, 4 төслийн л яах вэ дээ гэж л харж байгаа юм л даа. Түрүүн Идэрбат гишүүн хэлчихнэ лээ. 3.5 сая еврогоор ийм юм хийгээд зогсчхож байгаа юм уу хайран биш үү гээд. Үр дүн гэж ингэж ярьж байгаа бол уучлаарай. Ийм зүйл байж болохгүй. Тэгэхээр та энэ төсөл хөтөлбөрүүд дээр цааш нь хэрэгжүүлэхдээ төлөвлөлтөө сайн хийж, хэрэгжих үр дүн дээрээ аягүй сайн тооцох хэрэгтэй. Манай Лувсанжамц гишүүн маш сайн ярьж байгаа. Энэ асуудлыг. Эхлээд нөхцөл байдлаа тод зөв тодорхойлъё. Дараа нь үр дүнгээ, хүрэх үр дүнгээ тавьж өгье өө. Ингэж байж энэ чинь эргээд нөгөө биелэлттэй холбоотой асуудал. Энэ хөтөлбөрийн үр дүнтэй хэрэгжсэн эсэхтэй холбоотой асуудал дээр бид нар тодорхой шийдэл гаргаж чадна. Үр дүнг тооцож чадна гэж хэлээд байгаа байхгүй юу. Энийг л та хэрэгжүүлэх ёстой. Би бол Лувсанжамц гишүүнтэй 100 хувь санал нэг байгаа.

С.Ганбаатар: Манай Батлут гишүүн маш чухал санал хэллээ. 4 номерт тодруулж хариулах уу?

П.Батхишиг: Тэгэхээр яах вэ Байгаль орчны чиглэлээр хэрэгжиж байгаа төслүүд дээр юу сайн бэ гэхээр хэрэгжүүлэгч нь дандаа олон улсын байгууллага байгаа. Юу гэж хэлж байна вэ гэхээр би энэ дээр түрүүн гишүүн нүүрсний хэрэг шиг болох вий энэ тэр гээд ярьж байна. Би тэр талаасаа бол харьцангуй гайгүй байх гэж хэлж байна. Яагаад гэхээр НҮБ-ын хөгжлийн агентлаг гээд эхнээсээ бид нар анхны тайлан дээр хэлсэн. Энэ 28 төслийн 2 дээр нь яам хэрэгжүүлэгч дээр нь харьцангуй нэг тал болж явж байгаа. 26 дээр нь санхүүжүүлэгч болоод хэрэгжүүлэгч. Яагаад хэрэгжүүлэгчийг би тодорхой хэлж байна вэ гэхээр олон улсын ногоон сангийн итгэмжлэгдсэн байгууллага хэрэгжүүлнэ ээ гээд заачихдаг учраас Монголд одоо яг жишээлбэл тэрийг хангаж байгаа хоёрхон банкнаас өөр ямар ч ААН байдаггүй, ТББ байдаггүй. Тэгээд тэр утгаараа бол энэ дээр мэдээж хэрэг бас аудит ороод явж байгаа. Энэ маань зээл тусламжийн юм учраас улсын аудит нь орж байгаа. Яам одоо ажлын хэсэг гаргаад энэ дээр орох гэж байгаа. ОУБ өөрөө орж байгаа. Тэгэхээр бас эндээс ингээд нэмээд ороод ирвэл би зөв зүйтэй л гэж харж байна.

С.Ганбаатар: Ингээд асуултад хариуллаа. Саяын хариулт дээр нэмж хэлэхэд бүх төслүүдийг муу гэж хэлээгүй. Тэгэхдээ бид хянах үүрэгтэй тэр ажлаа. Харин энэ олон жил Монголын Засгийн газрын олон төслүүдийг бас Улсын Их Хурал хяналтаа сайн тавиагүй байгаа. Ер нь бол олон улсын туршлага байдаг л даа. Олон улсын практик дээр байдаг. ОУБ болгон тэгээд бурхан шиг биш. Тухайн ядарсан ард түмний зовлонг ажилгүйдэл, ядуурал, Байгаль орчны доройтлын нулимс гартал уйлтал нь бичээд л. Тэгээд олон улсын өөр байгууллагаас Дэлхийн банк, Валютын сан, Азийн банкнаас мөнгө аваад 70 хувийг нь өөртөө цалин болгож аваад явчихдаг. Дараа нь тэр тухайн ядуу орны хүүхэд, хүмүүс, хүүхдүүд ирээдүйд төлдөг. Ийм байдал байлгахгүйн тулд бид бас хяналтаа тавих үүрэгтэй.

Би энэ дээр зүгээр 1 сая долларын төсөл Эй Ди Би-ийн төсөл байгаа. Бүүр нэртэй нь би хэлчихье. 2023 онд тайлангаа тавьсан байна. Интернэтэд байгаа. 1 сая долларын төслийн консалтингийн мөнгө нь гэсэн чинь анх бол 544 мянган доллар байж байгаад, 867 мянган доллар болсон. 86.7 хувийг нь зөвхөн цалиндаа зөвхөн цалиндаа буцаагаад аваад явчхаж байгаа юм. Тэгээд дараад нь кофе цайны мөнгө гээд 107 сая доллароор зарцуулсан. Трэйнинг семинарт 107 сая доллар юу мянган доллар зарцуулсан. Зүгээр энэ бол ярихаас өөр аргагүй болчихсон зүйл л дээ. Тэгэхдээ энэ ганцхан Байгаль орчин дээр яриагүй шүү. Би энэ яах вэ Байгаль орчин, хөдөө аж ахуйн яам 2 дээр хэрэгжсэн төслийг яг тайланг нь гаргаж ирж байгаа ярьж байгаа.

Тэгэхээр бодит байдал бол олон улсын байгууллагууд бурхан шиг бүгдээрээ биш юм шиг байна лээ. Ингээд Үүрийнтуяа гишүүн асуулт асууя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. 4 асуулт байна. Сая асуулт дээр нь давхардал үүсэж байна. Тэгэхээр давхардуулахгүй байдлаар тодруулаад явъя. 38 сая долларын Эй Ди Би-ийн санхүүжилттэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл зээлийн төсөл ямар хугацаанд хэдэн төгрөгийн зээлийн хүүгийн төлбөр үндсэн төлөлттэй хэзээ төлөх вэ? Энэ 28 төсөл дотор Засгийн газраас тодорхой хэмжээний санхүүжилтийн эх үүсвэр дээр тодорхой хувиар оролцож байгаа. Засгийн газраас Монгол Улсын төсвөөс гарч байгаа ямар хэмжээний зардал гарч байгаа вэ? Үр өгөөжийг тооцож байна гэж байна. Тэгэхээр энэ үр өгөөжийг тооцоход чиг үүргийн давхардал энэ төслүүд дээр чинь орж ирж байна уу? Давхардаж байгаа

ажлууд байна уу? Тухайлах юм бол ТХГН-тай холбоотой 3 болон 9 дэх дугаарын төслүүд хамт орсон байна. Тэгээд ийм хэдэн төсөл байгаа вэ?

Хоёр дахь асуулт нь биологийн олон янз байдлыг хамгаалах тухай асуудлаар 8 дахь төсөл. Энэ дугаарласнаар 8 дээр. Энд ургамал орж байгаа юу? Явц үр дүн гэж юм бол ургамалтай холбоотой юм алга байна. 4 жил өнгөрсөн байна. Хэрэгжиж эхлээд ямар үр дүн гарсан бэ? Ургамлын төрөл зүйл их ховордож байгаа. Үүнээсээ хамаараад хөрсний үржил шим буурч нөгөө эргээд ХАА гол МАА дээр хамгийн хүндрэл үүсэж байгаа. Малын ашиг шим буурч байна, давж ирж байна гэж байгаа юм. Тэгэхээр энэ чиглэлээр энд 4 жилийн хугацаанд энэ төсөл ямар үр дүн гаргаж ажиллав гэдгийг асууя.

Гуравт нь Ногоон хэрэм төсөл. Сэлэнгэ, Өвөрхангай, Хөвсгөл аймаг, 3 аймаг дээр мод үржүүлгийн газар байгуулах ажлыг 2022 оноос эхлээд хийгээд явж байгаа гэж байна. 3 жил 2, 3 жил болсон байна. Энэ ажлууд дууссан уу? Ямар үр дүнтэй байна? Тэрбум модтой хэрхэн уялдаж байгаа вэ?

4 дэх асуулт Карбоны зах зээлийн талаар нэлээд ярьж байна. Одонтуяа сайдад бас баярлалаа. Энэ чиглэлээр мэргэжлийн хүмүүс ажиллуулж байгаа юм байна. Бид ер нь бол албан ёсны зах зээл дээр өрсөлдөх боломж бидэнд байхгүй л дээ. Магадгүй ар албан ёсны зах зээл рүү ороод ирвэл мөнгө олох биш өрөнд орох байх. Сайн дурын зах зээл дээр өрсөлдөхөд сайн дурын зах зээл дээр бид нар гарахад Монгол Улсын боломж ерөөсөө л сайн дурын зах зээл байгаа. Тэгэхээр энэ зах зээл дээр гарахын тулд бид нар бэлтгэл хэр хангаж байгаа юм бэ? Энэ зах зээл мэдээж шинэ зах зээл үүсээд нэг 16, 17 жил л болж байна шүү дээ. Дэлхийд үүсээд. Тоглоомынхоо дүрмийг эцэслэн тохирч чадаагүй байгаа зах зээл. Гэхдээ гаднын улс орнууд энийг зөвхөн Байгаль орчны асуудал биш эдийн засаг худалдааны асуудал болгоод авч явдаг болчихсон байна. Сингапурт жишээлбэл худалдааны сайд карбоны асуудлыг хариуцаж байна.

Тэгэхээр энэ Эдийн засгийн хөгжлийн яамтайгаа энэ асуудлаа ер нь хэрхэн яаж уялдуулж ярьж байгаа юм бэ? Энэ талаар ямар ажлууд хийхээр төлөвлөж байна? Тэрбум модны хүрээнд хийж байгаа мод тарилт, хөрсний сайжруулалтын асуудлууд, бусад энэ технологийн чиглэлээр хийгдэж байгаа ААН-үүдийн хийж байгаа энэ ажлуудыг хэзээнээс эхлээд аудит хийж аль улсын диллерээр дамжуулж зах зээлд гаргахаар төлөвлөж байна вэ?

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн 4 маш тодорхой асуулт асуулаа. Хариултыг өгье. 3 номерын микрофон дээр хариулт өгье. Нэр усаа хэлээрэй.

Б.Оюунсанаа: Оюунсанаа Ойн газрын дарга. Ногоон хэрэмтэй холбоотой болоод тэрбум мод технологи карбонтой холбоотой 2 асуултад хариулья аа.

Ногоон хэрэм төсөл маань хэрэгжээд 3 дугаар үе шаттай явж байгаа. 3 үе шат нь хэрэгжсэн. 3 дугаар үе шат нь болохоор Өвөрхангай, Хөвсгөл, Сэлэнгэ, тэгээд Горхи Тэрэлжийн гэсэн 4 байршил дээр мод үржүүлгийн газар байгуулах дэд бүтцийг бий болгох энэ ажлыг хийгээд явж байна. Ирэх жил 25 оны төгсгөл буюу 26 оны эхээр дөнгөж он гараад дуусахаар ийм төлөвлөгөөтэйгөөр ингээд ажиллаж байгаа. 8 сая доллар.

Тэгээд энэ 4 байршил дээр иж бүрэн мод үржүүлгийн газар 15 га талбай тус бүр дээрээ байгуулсан. Энэ нь болохоор механикжсан эрчимжсэн ийм мод

үржүүлгийн газар, Тэрбум мод Үндэсний хөдөлгөөний хүрээнд энэ мод үржүүлгийн газруудаас жилдээ 3-5 сая ширхэг тарьц суулгацыг гаргах ийм хүчин чадалтайгаар байгуулагдаад дөрвүүлээ үндсэндээ байгуулагдсан. Тэгээд энэ жилээс тарьц суулгац нь гарч эхэлж байгаа. Ийм байгаа. Дээрээс нь бүгдээрээ 4 байршил дээрээ бас олон нийтэд зориулсан сургалт мэдээллийг өгөх жижигхэн ийм дэд бүтэцтэйгээр хийгдсэн. Зөвхөн тэндээ мод тариад байх биш, хүмүүст зориулсан, экологийн, байгалийн, ойн чиглэлийн боловсрол олгох ийм цомхон дэд бүтцийг хийгээд явж байгаа. Орон нутгийн засаг захиргаа үргэлжлүүлээд аваад явна. Ялангуяа ойн ангиуд хариуцаад аваад байх энэ төсөл дууссанаар тэгээд түүнтэй холбоотой бизнесийнх нь төлөвлөгөө юмнуудыг нь гаргаад өгч байгаа ийм онцлог төсөл бий. Тэрбум модтой карбонтой холбоотой өнөөдөр

Ойн тухай хуулийн шинэчилсэн найруулгын бэлтгэл ажил ингээд явагдаж байна аа. Үүн дээр болохоор бид нар нүүрстөрөгчийн зах зээлд ойгоос орох тэр зохицуулалтуудыг тусгаад оруулаад явж байгаа. Мэдээж Байнгын хороогоор орж ирээд хэлэлцэгдэх байх энэ үед та бүхэн дээр илүү мэдээлэл орох байх гэж бодож байна. Мэдээж бид бүхнийг харж байгаа. Үүнтэй холбоотойгоор бэлтгэл болгож ажил болгож зөвхөн яг ойгоос чиглэсэн энэ ойн салбараас чиглэсэн нөөц хэрэгцээний зах зээлийн бололцоо, холбоо, уялдаа холбоо зэрэг дээр бид нар жижиг төсөл гэх юм уу даа аваад хэрэгжүүлээд явж байгаа. Энэ дээр бол гол нь манай эрх зүйн орчин дээр онцгойлон анхаарсан ийм зохицуулалтыг хийж байгаа. Энэ зөвхөн ой биш, газар зохион байгуулалт, ХАА гээд олон салбартай холбогдож байж нарийн үндэслэл гарч ирнэ. Ер нь Үүрийнтуяа гишүүний хэлж байгаа зөв. Бид юу вэ гэхээр ерөөсөө тэр бизнесийн орчинд нь ярих ёстой асуудал байгаа юм. Гэхдээ байгууллага салбар болон хоорондоо уялдаа холбоогоо сайн хангахгүй бол зөвхөн дан ганц салбар нь энийг яриад болохгүй ээ. Бид маш сайн дотооддоо улс орон маань хоорондоо уялдаж байж энэ дээр зах зээл энэ дээр гарах ёстой эрх зүйн зохицуулалт маш тодорхой байх ёстой гэдгийг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

С.Ганбаатар: 8 номер дээр тодруулж асууя. 4 асуулт асуусан шүү дээ.

П.Цогтсайхан: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн хамтын менежмент хэлтсийн дарга Цогтсайхан Үүрийнтуяа гишүүний асуултад хариулъя. Би биологийн олон янз байдлын талаарх асуултад хариулъя.

Биологийн олон янз байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох гээд Германы Сэргээн босголт хөгжлийн банкны тусламжаар хэрэгжсэн ийм төсөл байж байгаа. Одоо бол үргэлжлэн хэрэгжиж явж байгаа. Энэ дээр түрүүн Үүрийнтуяа гишүүн ургамлын асуудал орсон уу гэсэн байгаа. 2020-2024 онд хэрэгжсэн энэ төслийн эхний шатад бол Монголын баруун болон говийн бүсийн тусгай хамгаалалттай газруудын анхны төлөв байдлын бүрэн хэмжээний судалгаа хийсэн. Энэ дээр бол үндсэндээ 13 газарт төлөв байдлын судалгаа хийсэн бөгөөд энэ төлөв байдлын судалгаанд байгалийн ургамлын асуудал бүгд тусгагдсан байж байгаа. Төслийн үр дүнд бид нар өнөөдөр ургамлын бүрхэвч төслийн эхэнд ямар байсан.

С.Ганбаатар: Асуултад Одонтуяа гишүүн хариулъя. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тогтвортой аялал жуулчлал төсөл. Би түрүүн хэлсэн нөгөө манай яаман дээр байж байгаад тэгээд одоо Аялал жуулчлалын яам хэрэгжүүлж байгаа. Энэ төслийн хүрээнд ер нь нэг Хөвсгөл нуурын орчимд учирч байгаа 3 том

бэрхшээлийг шийдвэрлэх зорилттой энэ төсөл хэрэгжиж байгаа. Энэ бол хог хаягдлын менежментийг сайжруулахгүй бол энэ хавьд бол маш их аюултай нөхцөл байдал үүсэж байгаа.

Хоёрдугаарт энэ аялал жуулчлалын дэд бүтэцгүй байна.

Гуравдугаарт энэ тогтвортой нэгдсэн төлөвлөлт хийгдээгүй байна гэдэг үүднээс энэ 3 асуудлыг шийдвэрлэхээр энэ хөтөлбөр батлагдсан. Энэ хөтөлбөрийн хүрэх үр дүн гэвэл ер нь Хөвсгөл аймгийн нэг хүнд оногдох орлогын хэмжээ өснө. Аялал жуулчлалын салбарынх нь тогтвортой хөгжил бол сайжирна. Энэ Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор газрын нэгдсэн ийм тогтвортой менежменттэй болно. Хог хаягдлын менежмент сайжирна.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Нэгдүгээрт Эй Ди Би-ийн санхүүжилттэй энэ 38 сая долларын зээлийн үндсэн төлөлт, хүү, хугацааг би тодруулаад байгаа юм. Ямар хэмжээний хүү, хэзээ төлөх вэ гэж? Энийг тодорхой болгоод өгөөч.

Хоёрдугаарт карбоны асуудал дээр Ойн хууль бол нэг л юу л даа. Нэг л ажил л даа. Эдийн засгийн хөгжлийн яамтай ер нь яаж уялдаж энэ бодлогоо ярьж байгаа вэ? Энэ дээр нэг тодорхой мэдээлэл өгөөч.

Гуравт нь биологийн тэр олон зүйлийн олон янз байдлыг хамгаалах асуудал байна. Тийм ээ дасан зохицох 2, 3 дугаар хөтөлбөр гээд. Тэгэхээр энэ дээр та гарсан үр дүнгүүд дээр ялангуяа ямар байгаад энэ чинь 4 жил болоод бараг хугацаа нь дуусаж байна шүү дээ. Тэгэхээр ямар байгаад ямар үр дүн гарав, юуг хамгаалав гэдэг нэг мэдээллүүдийг нэг эргэж явуулаач ээ гэсэн хүсэлт байна.

2 асуултаа тодруулъя.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн маш тодорхой 2 асуулт тодруулж байна тодорхой хариулна уу? 4 номерт хариулъя.

П.Батхишиг: Карбонтой холбоотой хуулийг хаврын чуулганаар оруулахаар ажлын хэсэг ажиллаж байгаа. Карбон гэх биш Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хууль. Тэрний 2 бүлэг нь бол яг карбоны зах зээлийн зохицуулалттай холбоотой 2 бүлэг байгаа. Ажлын үндсэн өмнөх сайдын үед байгуулагдсан ажлын үндсэн ажлын хэсэг хэвээрээ ажиллаж байгаа. 1 дэд ажлын хэсэг гараад энэ карбоны хэсгийг бүрэн хариуцаад ажиллаж байгаа. Энэ дотор холбогдох яамдын төлөөллүүд байгаа. Эдийн засгийн хөгжлийн яамнаас байгаа, Хүнс, хөдөө аж ахуйн яам байгаа, Барилга хот байгуулалт байгаа, Уул уурхай байгаа. Тэгэхээр тэр хууль ороод ирнэ. Тэгэхдээ хуулийг хүлээлгүйгээр бид нар энэний дагуу бичигдэх журам дээр давхар ажиллаж эхэлсэн байгаа. Тэгэхгүй бид нар хууль батлахыг хүлээж байгаад дараа нь журам дахиад өөр юм явдаг. Тэгээд энэ хугацааг хэмнэхээр хичээж байгаа.

Түрүүний карбонтой холбоотой хэсэг дээр мөн Сингапуртай Карбон трейдийн санамж бичиг 2 жилийн өмнө 2023 оны 6 сард зурсан байдаг. Тэгээд 24 он дуусаж байна. Сая уул нь энэ Бакугийн уур амьсгалын хурлаар энэ Сингапуртай Карбон трейдинг гэрээг Эдийн засгийн хөгжлийн яам зурах байсан юм байна лээ. Нэлээн тэгээд тодорхой.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн тодруулъя.

Д.Үүрийнтуяа: Баярлалаа. Тэгээд би ер нь нэгтгээд саналаа хэлчихье. Карбоны талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай надад нэг дэлгэрэнгүй мэдээлэл өгөөч. Энийг эргээд авъя. Ер нь манай улс Монгол Улс гаднын зээл тусламжаар ямар чиглэлээр хэдэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлээд хэдэн төгрөг зарцуулаад байгаа юм бэ гэдгийг бүх яамдынхаа хэмжээнд нэгтгэж нэг харах цаг болсон байна. Байнгын хорооны дарга аа. Манай Байнгын хороонд хамаарах асуудал, хамаарахгүй асуудлууд байгаа бол Улсын Их Хурал нэгдсэн байдлаар Монгол Улсын хэмжээнд явж байгаа энэ зээл тусламжийн зарцуулалт, санхүүгийн эх үүсвэр, түүний гүйцэтгэл, үр дүн ямар байгаа юм бэ гэдэг дээр нэгдсэн сонголт, тэр шалгалтыг хийх бол нэгдсэн байдлаар хийх нь зүйтэй байна гэдэг энэ саналыг хэлмээр байна. Энэ бол үндсэндээ төсвийн тэлэлтийг бий болгоод байгаа бас нэг хүчин зүйлийн нэг гэж харахаар байна. Одоо 38 сая доллар дээр гэхэд надад ямар ч тодорхой хариултыг салбарын яам өгч чадахгүй байна. Энэ мөнгө төгрөгийн би нэг минутын нөгөө нэмэлтээ аваагүй байгаа.

С.Ганбаатар: 2 удаа хэлсэн. Гишүүнээ яачих уу? Нөгөө энэний дараа үг хэлэх байгаа шүү. Тийм үг хэлэх дээр та үг авчих уу? Боломж байвал.

Батбаяр гишүүн асуулт асуух юм байна. Батбаяр гишүүн.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе ээ. Тэгээд сая Наранбаатар гишүүн бас хэлж байна. Тусгай хамгаалалттай газар гэхээр нэг саравч бариад нэг хогийн цэг тавиад тэгээд нэг хашаа барьчихдаг. Үүдэнд нь хэдэн төгрөг хураачихдаг нэг ийм л явж ирсэн шүү дээ. Тэгээд сайшаалтай зүйл гэж би харж байна. Яагаад гэхээр 25 ААН-тэй менежментийн гэрээ хийгээд энэ тусгай хамгаалалттай газрыг энэ ААН-үүдээр дамжуулж хамгаалж үйл ажиллагааг хэрэгжүүлж байгааг би сайшаалтай зүйл гэж үзэж байна. Ингэж ажлын байрыг бий болгоно ингэж үйл ажиллагааг нь сайжруулна. Энэ дээр бол Байгаль орчны яам бол зөв зүйл хийжээ гэж харж байгаа юм.

Асуулт. Энд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөртэй холбоотой энэ 28 төсөл болгон дээр нь бид нар ер нь яг тулж ярих ёстой байх. Тэгээд хурлын дэг нь энэ боломжийг олгохгүй байх шиг байна. Би яг энэ 6 дугаар төслийг яг уншаад өгчихье. Сэлэнгэ аймгийн Баянгол, Мандал сум, Түнхэл тосгонд 11.7 сая ам.доллараар бичил уурхайн эрх зүйн орчинд үнэлгээ хийх алтны бичил уурхайн сан байгуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн ийм зорилготой төсөл 2019-2025 онд хэрэгжиж байгаа юм байна. Өөрөөр хэлэх юм бол 80 хувь нь хэрэгжээд хугацааны хувьд 80 хувь нь хэрэгжээд явагдчихсан. Одоо нэгхэн жил үлдчихсэн байгаа юм байна. Ямар үр дүн гарсан бэ гэсэн чинь 2019-2025 онд 4.6 тэрбум төгрөгийг нь зарцуулаад 6 ширхэг тайлан хийгээд, судалгаа хийгээд, 3 захиргааны акт гаргаад нэг төслийн баримт бичиг боловсруулсан гэж байна. Тэгээд 69 арга хэмжээ хийгээд, 35 сургалт хийгээд, 857 албан хаагчийг хамруулсан гэж байгаа юм.

Өнөөдөр энэ Байнгын хороонд энэ сонголт дээр сууж байгаа олон гишүүн хэлж байгаа шүү дээ. Энэ төслийн үр дүнтэй байдал нь ямархуу байгаад байгаа юм бэ? Төсөл хэрэгжих төслийн үр дүн гэдгийг сургалт хийхээр ямар нэгэн тайлан боловсруулахаар судалгаа хийхээр төсөөлөөд байгаа юм уу. Байгаль орчны яамны бодлого ямар байгаа вэ гэдэг нэг асуу алт байна. Тэгээд энэ инээд хүрэхээр гэх үү яах вэ нэг ийм юм бичээд хэлчихсэн байгаа байхгүй юу.

2025 онд гарах үр дүн ямар ажил хийх вэ гэсэн чинь мөнгөн усгүй баяжуулах системийг улсын комисст хүлээлгэн өгнө гэж байгаа юм. Энэ яг юу гэсэн үг вэ? Мөнгөн усгүй баяжуулах системийн ноу хау юм уу патент нь юм уу ямар улсын комисст хүлээлгэж өгөх гэж байгаа юм. Нэг иймэрхүү байдлаар төсөл хэрэгжүүлээд хаагаад ингээд орхидог байж болохгүй ээ. Энэ дээр Байгаль орчны яам ямар байр суурьтай байна. Тэгээд дараа нь тодруулгаа ахиад авчихъя.

С.Ганбаатар: Паа ёстой янзын их юм хийсэн байна шүү хариулна. 4 номерт хариулъя.

П.Батхишиг: Энэ дотор байгаа зарим төслүүдээс бол яг энэ ний нуугүй хэлэхэд мэдээлэл авахад маш хэцүү байгаа. Тийм. Тэгэхээр бид нар өгөгдсөн мэдээллийнхээ хүрээнд энийг 9 сараас нэг 11 сар хүртэл төслүүдийн мэдээллийг нэмэгдэх гэж ингээд явсаар байгаад энэ дээр яг нэр бүхий нэг 3, 4 төсөл үнэхээр мэдээлэл бид нарт маш хүндрэлтэй байгааг хэлэх нь зөв байх. Тэгэхээр тийм энэ 2-т яах вэ зарим төслүүд дээр нэг жижигхэн, жижигхэн тайлбарууд ирсэн нь юу вэ гэхээр ковидын үе гээд 2 жил энэ төсөл хойшлоод нэг наана цаана гээд шалтгаанууд хэлсэн байдаг. Зүгээр тэр хэмжээний мэдээлэлтэй байна. Тэгээд яг энэ төслийг хариуцаад яаж байгаа хүн бол алга байна л даа. Манай энд.

С.Ганбаатар: Батбаяр гишүүн тодруулъя. Одонтуяа сайд тодруулж нэмэлт тодруулга өгье.

С.Одонтуяа: Тэгэхээр энэ бид бас энэ хэд хэдэн ТББ хувийн ААН-үүдтэй энэ менежмент дэмжиж хамтарч ажиллах энэ гэрээнүүдийг хийсэн. Одоо ингээд он гараад хамтарч ажиллах гээд үзнэ. Би бол үр дүн гарна гэдэгт итгэлтэй байгаа. Эдгээр хүмүүст бол оюуны маш их потенциал байна, мэргэжилтнүүд байна, хувийн хэвшилд бол санхүүжүүлэх тийм сонирхол энэ байгалиа хамгаалъя тэр хавиа аялал жуулчлал хөгжүүлэе гэсэн ийм сонирхол байгаа. Тэгэхээр энийг бол бид хийгээд явна аа.

Энэ төсөл дээр бол яг энүүхэндээ санал нийлж байна оо? Би бол сая 1 гаднын төслийн гадаадын хүмүүс нь ирэхэд шууд л хэлсэн. Танай энэ төсөл бол бараг эндэх ажлын албаныхаа зардлаас хэтэрсэн зөвлөх үйлчилгээтэй төсөл байна аа? Одоо энэ олон жил болчихлоо. Энэ зөвлөх үйлчилгээгээ больчхооч ээ. Бүх юмаа мэдээд авчихсан. Тэгэхээр одоо энэ юмаа одоо яг энэ орон нутагт.

С.Ганбаатар: Батбаяр гишүүн тодруулж асуучхаад тэгээд та нэг мөсөн тодруулаад нэмэлт хариулт өгчих.

Д.Батбаяр: Баярлалаа. Тэгэхээр энэ төсөл анх ярилцаад хэлцлийн шатанд явж байхдаа үйл ажиллагааныхаа объём хүрээг нь ингээд тодруулдаг тодорхой болгодог яамнаас нь санал авдаг байх. Тэгэхээр энэ төслийнхөө нэр, томъёо, хүрээг нь их тодорхой гаргаж өгдөг юм болов уу яадаг юм бол гэсэн нэг ийм механик асуулт байна. Тэгээд дахиад тодруулаад тэр төслийн үр дүн дээр хэрэгжилт дээр ямар бодлого баримтлах вэ гэдгээ хариулчхаарай. Ногоон хэрэм төсөлтэй холбоотой нэг тодруулах асуулт ирсэн. Түрүүн орхичихсон байна.

Энэ ногоон хэрэм төслийг хэрэгжүүлэхдээ энэ тариалангийн талбайнуудын дундах ойн зурвасуудыг ер нь юу гэж тооцож байгаа вэ? Энэ ойн зурвасуудыг ойжуулах юм бол тариалангийн талбайн голын завсрын талбайнуудыг ойжуулах юм бол ийм бэлчээртээ ч үр дүнтэй нөгөө талаар энэ ой маань өөрөө ургах ч бас давуу

талтай боломж байгаа. Тийм учраас энэ тал дээр бодож байгаа юм байна уу тайлбар байвал.

С.Ганбаатар: Батбаяр гишүүн асуулаа. Одонтуяа сайд нэмэлт хариулт өгье

С.Одонтуяа: Би хариулчихъя. Та нэмээд хариулчих энэ би өнөө гүйцээгээд хариулъя. Ер нь энэ төсөл дээр бол одоо яг ний нуугүй л ярихад нэлээд хэмжээ нь зөвлөх үйлчилгээ байдаг. Тэгээд бид нараас санал авдаг уу гэж байна. Зарим авдаг төсөл бий, авдаггүй төсөл бий. Өөрсдөө энэ чиглэлийн эрдэмтэн судлаачдынхаа дунд юу зарлаад хөтөлбөр энэ судалгаанд оролцох ийм хүмүүс байна уу гээд зарлаад тэрний дагуу эрдэмтэд, судлаачид, төрийн бус байгууллагууд ороод энэ судалгааг нь хийж өгдөг юм байна лээ. Голцуу энэ саяын таны хэлсэн төсөл бол Даян дэлхийн байгаль орчны сан мөртөө хэрэгжүүлэгч нь НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, НҮБ-ын Аж үйлдвэр, хөгжлийн байгууллага гээд ингээд. Тэгэхээр түрүүний энэ 28 төслөөс 2 төсөл.

С.Ганбаатар: 3 номерын микрофонд хариулт өгье.

Ү.Энхтайван: Батбаяр гишүүний ногоон хэрэмтэй холбоотой асуулт дээр нэмж хариулъя. Ногоон хэрэм төслийн хувьд болохоор түрүүн ярьсанчлан дэд бүтцийн төсөл энэ дээр ямар нэгэн зөвлөх үйлчилгээ ерөөсөө байхгүй. Тэр чигээрээ ерөөсөө тэр дэд бүтцийг бий болгож байгаа. Бизнес тээвэр төлөвлөгөө юмнуудыг нь гаргаж өгөөд орон нутгийн иргэдийн оролцоотойгоор орон нутгийн удирдлагуудтай яг хамтарч хийж байгаа ийм төсөл. Тэгээд тариалангийн талбайн хамгаалалтын зурвасын хувьд болохоор тэрбум мод үндэсний хөдөлгөөний нэг бүрэлдэхүүн хэсэг болоод төлөвлөөд явж байгаа. Энэ жилийн хувьд бид энэ намар тариалангийн талбай ялангуяа Дархан, Сэлэнгийн Улаанбаатар, Дарханы хоорондох тодорхой хэсгүүд дээр 42 км-т зурвасын ажлыг хийсэн. Энийг үргэлжлүүлж тэлнэ. Яах вэ ерөнхийдөө 70, 80-аад оны үед болохоор хэд хэдэн байршил дээр улсын хэмжээнд томоохон хэмжээний зурвасууд байгаа. Динамик үр дүнтэй хөрс хамгаалах хөрсний элэгдэл элэг хорогдлыг хамгаалах зорилгоор ингээд хийгдэж байсан. Бид яг тэр хуучин туршлагаа эргэж сэргээгээд тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нэлээн өргөн цар хүрээтэйгээр энэ ажлыг хийхээр эхний ажлууд хийгдээд.

С.Ганбаатар: Далайн Батбаяр гишүүн тодруулъя.

Д.Батбаяр: Түрүүн таны хэлсэн даргалж байгаа даргын хэлсэн энэ хяналтын ажлын хэсэг гаргаад төслийн хэрэгжилттэй танилцана гэсэн. Энэ тэгэхдээ Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дотор байгуулагдах ажлын хэсэг үү тиймээ.

С.Ганбаатар: Аж үйлдвэржилтэйгээ хамтарна.

Д.Батбаяр: Тэгээд нөгөө зарлагын хяналтыг хариуцаж байгаа дэд хорооны даргын хувиар төсөв бүрдүүлж байгаа. Энэ зээл тусламжийн зарцуулалт дээр тодорхой хяналт тавих ёстой. Тийм учраас энэ ажлын хэсэгт оролцох хүсэлтэй байгаагаа үүгээр хэлчихье. Баярлалаа.

С.Ганбаатар: Далайн Батбаяр гишүүн маш чухал саналыг хэллээ. Очирбат гишүүн асуулт асууя.

Г.Очирбат: Та бүхэндээ оройн мэнд хүргэе ээ. Тэгээд юуны түрүүнд Одонтуяа сайд, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны хамт олонд баяр хүргэе. Энэ богино хугацаанд энэ олон улсын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд ингэж нээлттэй танилцуулж байгаад баяр хүргэе ээ. Гишүүдийн зүгээс ярьж байгаа нэг ганц том асуудал байна. Энэ яаж байна гэхээр та хэд маань болж өгвөл дараагийн ийм хурал зохион байгуулаад энэ 28 төсөл хөтөлбөрийн үр дүнгийн тайланг бид нар нэг сонсчихмоор байгаа юм. Үр дүнг нь. Яг түрүүн тэр зөвлөх үйлчилгээ нь яаж яваад байдаг юм. Энэ түрүүн бас Байнгын хорооны даргын хэлж байгаа санаачилга. Гаднын байгууллагууд энэчээ төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ ихэнх нь зөвлөх үйлчилгээ гээд явчихдаг бодит ажил болдоггүй гэсэн ийм байна. Энийг дараагийн бас ийм уулзалтаар Байнгын хорооны хэлэлцүүлгээр та хэд маань бэлдэж орж ирээд бид нарт танилцуулчихвал их зүгээр байгаад байна.

Хоёр дахь асуулт энэ 28 төсөл хөтөлбөрийн нэг төсөл хөтөлбөр нь бол ингээд яг хөнгөлөлттэй зээлээр явж байгаа гэсэн. Яг ямар төсөл хөтөлбөр хэдий ямар хэдэн жилийн, хэдэн хувийн зээл ямар юм байдаг юм энийгээ нэг ямар төсөл хөтөлбөр юм гэдгийг нь тайлбарлаад өгчхөөч. Бусад нь болохоор олон улсын нөгөө буцалтгүй тусламж болохоор зөвхөн тэр хөнгөлөлттэй зээл нь яг энэ Байгаль орчны салбарт яаж явдаг юм гэдгийг нэг сонсоод авчихмаар байна. Ямар зээл яаж явдаг юм.

Дараагийнх нь энэ төслийн 25 дээр энэ Улаанбаатар хоттой холбоотой ганцхан юм байна 2022-2024 онд энэ хог хаягдлын салбарыг төрийн болон төрийн бус байгууллагуудын 25 төлөөлөлд 3 модулиар, 10 хүнийг сургалтад сургасан гэж байна. Тэгээд энэ 10 хүн маань яг энэ Улаанбаатар хотын хогийн асуудал дээр ямар байр суурь сурч ирчхээд илэрхийлсэн юм буюу нөгөө үр дүн нь ямар байсан юм гээд мэдээлэл байвал өгчхөөч. Яагаад гэхээр Улаанбаатар хот бол яг энэ хогийн асуудал хүндэрчихсэн. Ялангуяа манай энэ СХД, Баянзүрх, Чингэлтэй гээд манай энэ гэр хорооллын бүс нутгийн газруудын хогийн асуудал хүндэрсэн. Тэгээд та бүхэн санаж байвал бид нар 2025 оны төсвийг хийхдээ давхар Улсын Их Хурлын тогтоол гаргасан. Энэ дээр болохоор энэ хог хаягдлыг Цэвэр эрчим хүч болгоё гэсэн ийм тогтоол гаргасан. Энийг одоо манай Байгаль орчин Одонтуяа сайд манлайлаад аваад явчихвал их зүгээр байгаад байгаа юм. Би эрчим хүчний сайд дээр ерөөсөө итгэл үнэмшил төрөхгүй байгаа юм. Яагаад гэхээр сайхан хороо байгуулсан. Бүх эрх мэдлийг нь өгсөн. Ганц л юм хэлнэ шүү дээ. Энэ үнийг л өсгөлөө бодитой ажлууд ерөөсөө харагдахгүй байна. Хууль эрх зүйн орчин шинэчлэл ч харагдахгүй байна.

Тэгэхээр Одонтуяа сайд энийг манлайлаад улс төрийн манлайлал үзүүлээд яг энэ тогтоолыг аваад энэ Улаанбаатар хотын хог хаягдлыг эрчим хүч болгох тал дээр ажиллаж өгөөч гэсэн нэг ийм хүсэлт байна. Өнөөдөр бол Улаанбаатар хотоос энэ 3 цэг дээр 6 мянган тонн хог хаягдал гарч байна. Үүнээс 3.2 мянган тонн өдөрт шүү. Энэ нь болохоор сэргээгдэх хүчин үгүй ээ, дахин ашиглах бололцоотой, эрчим хүч үйлдвэрлэх бололцоотой ийм хог хаягдал гарч байгаа юм. Тэгэхээр та хэд маань энэ дээр нэг тодорхой яг ажил болгоод манлайлаад аваад явчхаач гэсэн санал байна.

Гуравдугаарх асуулт бол бид нар одоо ингээд цаашдаа энэ яг энэ хог хаягдал.

С.Ганбаатар: Очирбат гишүүнийг нэг минутаар тодруулъя.

Г.Очирбат: Аж үйлдвэржилтийн байнгын хороонд байгаа болохоор энэ хог хаягдалтай холбоотой асуудлыг нэлээн Байгаль орчны яам болон ЭХЯ-ыг хамтарч

ажиллахыг Аж үйлдвэрийн яамыг хамтарч ажиллахыг шаардана аа. Өнөөдөр бид нар олон улсад нээрээ гаднынхан ирээд манай хогийг энэ мөнгө байхад энийгээ ашиглаж чадахгүй юм гэж харж байна шүү дээ. Тэгэхээр та хэд маань Байгаль орчны яаман дээрээ санаачилга гаргаад ЭХЯ-тай болон энэ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамтай хамтраад Улаанбаатар хотын хогийн асуудлыг нэг мөр шийдээд энийг эцсийн эрчим хүч болгох тал дээр манлайлал үзүүлж ажиллах ийм боломж бололцоонууд байна шүү гэж хэлэх гэсэн юм. Тэгээд асуултдаа хариулт авчихъя.

С.Ганбаатар: Асуултад хариулъя 5 номерын микрофоныг нээж өгье.

Ү.Энхтайван: Баярлалаа. Түрүүн Үүрийнтуяа гишүүний асуусан асуулттай холбоод Очирбат гишүүний асуултыг хариулчихъя аа. Манай энэ 28 төслөөс Байгаль орчны яаман дээр харьяалалтай байж байгаа нэг л төсөл тэр дундаа энэ 28 төслийн ганц зээлээр хэрэгжиж байгаа ийм төсөл байгаа, Азийн хөгжлийн банкны төсөл. Одоогоор нэг төслийнх нь 31 хувь нь хэрэгжсэн. Тэгээд он дуусгаад Аялал, жуулчлалын яам руу шилжих ийм төсөл байгаа. 38 сая долларын төслийн 19 сая доллар нь энгийн зээл, 19 сая доллар нь хөнгөлөлттэй зээл байгаа. Энгийн зээл нь болохоороо лайбер дээр нэмэх нь 0.7 хувийн хүүтэй. Хүү төлөгдөх хугацаа эхний 5 жил чөлөөлөгдөнө тэр нь 2019 оноос 2024 оны хооронд явж байгаа. Тэгэхээр ирэх жилээс ингээд хүү төлөгдөөд эхэлнэ гэсэн үг. Хөнгөлөлттэй зээлийнх нь хүү нь 2 хувьтай байгаа. Ийм байгаа.

С.Ганбаатар: Найдалаа гишүүн асуулт асууя.

Б.Найдалаа: Ямар ч байсан өнөөдөр маш чухал асуудал ярьж байна. Байгаль орчны салбарт хэрэгжиж байгаа гаднын зээл болон тусламжтай холбоотой төслүүдийн талаар. Ерөнхийдөө би Байгаль орчны яамтай яг энэ төслүүдтэй нэлээн удаан ажиллаж ирсэн. Ер нь гадарлана. Асуудал нь юу байдаг вэ гэхээр асуултаас өмнө ярихад төсөл болгон нэг удирдах хороотой байгаа. Яамны нэг дарга удирдах хороог нь даргалдаг. Төслийн ажлыг нь хөтөлж явуулдаг нь яам биш, санхүүжүүлэгч нь болчихдог. Хэн нь гуйгаад байгаа юм, хэн нь хэрэгжүүлээд байгаа юм. Энэ хэний төлөө явж байгаа нь ойлгомжгүй байгаад байдаг, нэг ийм асуудал нийтлэгээрээ байдаг аа. Дунд нь яах вэ арай өөр төсөл байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ нийтлэгээр ийм. Тэгээд хурлынх нь ирц нь нэг тийм юу гэдэг юм тийм олуулаа оролцоод, яг хэн нь хөтлөөд байгаа нь мэддэггүй нь ийм байдаг. Тэгээд баахан цаас үйлдвэрлэдэг үнэн байхгүй юу. Зардлынх нь ихэнх нь гадаад зөвлөхүүд явчихдаг үр дүнтэй ч юм шиг үр дүнгүй ч юм шиг. Ийм байдаг. Тэгэхээр зүгээр миний асуух гээд байгаа юм Одонтуяа сайд бас хэлж л байна лээ. Тэгэхдээ асуух гээд байгаа зүйл бол одоо энэ төслүүдийг уялдуулах үнэхээр шаардлага байгаа.

Энэ чинь нэг л салбарт хэрэгжиж байгаа юмыг чинь бүгдээрээ биш юм гэхэд 99 хувь нь хамгийн багадаа 20, 30 хувь давхацдаг. Хүмүүс нь давхацна, ажил нь давхацна, хүсэж байгаа үр дүн нь давхацна. Тэгэхээр энийг уялдуулна гээд хэлэхэд амархан. Тэгэхдээ яг ямархуу арга барилаар уялдуулах вэ? Энэ 20, 30 төсөл байлаа гэхэд 20, 30 удирдах хороо, 20, 30 л хүн ингэхийгээд л явж байгаа байхгүй юу. Нэг иймэрхүү асуудал байдаг. Тэгээд энэ дээр Одонтуяа сайд болон яамныхан шинээр ажил тодорхойлж байгаа улсууд энэн дээр яг ямар ажлууд, ямар механизм ч гэдэг юм уу ямар хурал юу хийдэг юм, ямар зохион байгуулалтаар яаж ажиллах гэж байгаа вэ? Тэр маш сонин байна. Зүгээр яах вэ хувийн хэвшил зүгээс ингээд ажиллаж байхад бол үгүй ээ ингээд л ингээд л хийчихгүй гэсэн юм зөндөө байдаг байхгүй юу. Харсаар байтал яг юу хүсээд байгаа нь ойлгомжгүй. Тэгээд төслүүд чинь бол ихэнх нь нэг сайдтай цаг авах гээд л уулзах гээд л явна. Юм гуйх гээд

байгаа юм уу, гуйлгах гээд байгаа юм уу мэдэхгүй. Тэгээд иймэрхүү маягаар л явдаг иймэрхүү маягаар л явдаг нэг нийтлэг нэг нийтлэг дүр төрх байгаа юм аа.

Тэгээд яах вэ санаа нь бол Одонтуяа сайд энэ дээр бас төлөвлөгөөгөө яривал их сайн байна. Яг ямар төсөөлөл байгаа юм? Минийхээр бол яам маань эхлээд өөрсдөө ингээд ийм хөтлөгч нь болмоор байгаа байхгүй юу. Яг яаманд нэг л төлөвлөгөө байх ёстой Монгол Улсад. Тэрэн дээрээ харин энэ төслүүдийг ашиглах юм бол одоо хэрэгжиж байгаа төслүүдийг ч гэсэн ашиглах юм бол бүүр илүү нэмээд мөнгө босгох боломжтой. Энэ бүх асуудлуудыг шийдэхэд хөнгөхөн байгуулсан салбар бол яг тэр зээл тусламж байна уу? Үр дүнтэйгээр ингээд татаад татаад тэр байгаа санхүүжилтээ хийх бүрэн боломжтой байдаг. Энийгээ ашиглахгүй ерөнхийдөө урсгалаараа л ингээд л явж байдаг энэ жоохон харамсалтай санагддаг юм аа. Тэгээд энэ дээр Одонтуяа сайд ямархуу бодлого ямар төлөвлөгөөтэй ажиллаж байгаа вэ? Эдгээр төслүүдийг уялдуулаад нэг төлөвлөгөөндөө зангидах талаар. Баярлалаа.

С.Ганбаатар: Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Тийм Найдалаа гишүүнтэй санал нийлж байна. Үнэхээр ингээд энэ манай улсад ингээд ер нь маш их олон төсөл хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа юм. Зөвхөн манай салбарт биш тэгээд энэ дээр дүнг нь харахаар нэлээд үр дүнтэй болчихмоор юм шиг. Тэгээд яагаад үр дүн дунд байдаг юм, бага байдаг юм гээд бид нар энэний бүр учир начрыг нь олъё гээд яаман дээрээ бүтцийн өөрчлөлт хийсэн. Яг энэ рүү чиглэсэн бүтцийн өөрчлөлт хийсэн. Өөр ямар ч яам биш ээ. Газар хэлтсийг бол өөрчлөөгүй. Гол нь яг энэ гадаад хамтын ажиллагаан дээр тусгайлан газар байгуулсан. Энийг чинь ингэж даргаар нь хүн аваад 6 хэлтэй устай залуучууд өдөр шөнөгүй сая энэ бүх төсөл хөтөлбөрүүдийг танилцаад уншаад ингээд ажиллаж байна л даа. Тэгээд нэг зөвлөх маань ерөөсөө яг гадаадынхантайгаа уулзаад яг юу хүсээд байгаа юм, яг ямар үр дүнд хүрэх гээд байгаа юм гэдгээ ингээд хийсний хүчинд бид нар бол ядаж нэг ийм өнөөдөр ийм тайлагнах хэмжээнд очиж байна л даа. Хаана юу байгаа нь мэдэгддэггүй ийм байсан.

Тэгээд бүх яамдуудын удирдах хороо солигдсон. Одоо энийг бол бид нар шинэчлээд хурдан ажилдаа орж байгаа. Ер нь яам бол бодлогын хувьд хөтлөгч байх ёстой. Одоо надыг ажлаа авсны дараа бараг би 2 зуугаад гадаадын төсөл хөтөлбөртэй уулзлаа. Уулзъя, уулзъя гээд. Тэгэхээр би НҮБ-ынхантай энэ Тапан Мишер гуайд нэг л санал хэлсэн. Юнита уулзъя, Юнисеф уулзъя, Юндипи уулзъя гээд ингээд ойлгомжгүй байна. Тэгэхээр НҮБ дээр нэг эвсэл болоод энэ бүх НҮБ-ын төслүүдээ ядаж танайх зангидаач ээ. Тэгээд хамтраад энэ дээрээ яг аль төслийг нь хэзээнээс яаж үр дүнтэй давхцалгүй болгох юм бэ гэдэг ийм зүйлийг бол ярьсан. Энийг бол хийгээд эхэлсэн байгаа. НҮБ-ын төслүүд нь хүртэл дотроо давхацчихдаг ийм зүйлүүд байгаа. Тэгэхээр бид бол энэ дээр энэ бүх төсөл хөтөлбөрүүдээ судлаад одоо ямар хаана алдаа оноо байсан юм гэдэг энэ зүйлүүд дээр ажиллаж байна. Энэ сая яг одоо гарт орчихлоо.

Дээрээс нь бид үндсэн 3 конвенцынхоо олон улсын хуралд явсан. Бусад Байгаль орчны яамд ямар чиглэлээр ажилладаг юм бэ ямар чиглэлийг гол болгоод байгаа юм бэ? Дэлхийн Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн чинь хамгийн том сорилт нь юу юм бэ? Яаж санхүүжилтээ босгодог юм бэ? Яаж одоо энэ дээрээ том үр дүнд хүрдэг юм бэ гэдгийг бид нар сая үнэхээр хэд хэдэн копт яваад энийг бол мэдэж авсан байгаа.

Тийм учраас энэ дээр бол асуудлаа сайн мэдэж авсан учраас энэ дээр боломж болох байх гэж үзэж байгаа. Тэгээд яах вэ би зүгээр энд түрүүн энэ хогийн юу ярихад нэг бүрчлэн энэ компаниудтай уулзаад танилцсан. Ер нь бол дандаа ийм бодитой ийм яг газар дээр нь хийдэг төсөл хийдэг юм байна. Жишээлэхэд хог гэхэд яг энэ СХД-ийн ийм ийм сургуулийн хүүхдүүдэд яг энэ хог ангилахыг ингэж заана, хогийн сав нь ийм байна ингэж ингэнэ ээ гэдэг бүр ингээд детальчилж заадаг ийм төслүүд байгаа. Тэгэхээр бид бол энэ төслүүд үр дүнтэй. Нэг их айхтар ямар нэгэн сөрөг бол юм байдаггүй. Бидний бас энэ төсвийн хөрөнгөөр хүрэлцэхгүй байгаа зүйл дээр маш том хувь нэмэр болж өгдөг юм. Тэгэхээр бид бол зүгээр Монголын тал өөрсдөө энийгээ яаж хөтлөгч болох вэ, яаж илүү тэр тулгамдсан асуудалтай салбар руугаа энийгээ шилжүүлэх вэ гэдэг дээр бид нар өөрсдөө л сайн манлайлж ажиллах ёстой юм байна лээ. Өөрсдөө юмаа сайн мэдэж байж ингэж ажиллах юм байна лээ.

С.Ганбаатар: Найдалаа гишүүн тодруулж асууя.

Б.Найдалаа: Баярлалаа. Яах вэ тодруулж асуулт алга аа. Зүгээр яах вэ дүгнээд хэлэхэд ер нь бол яг энэ гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа энэ төслүүд чинь зөвхөн Байгаль орчны салбар биш маш чухал сэдэв. Өнөөдөр хөндөж байгаа нь маш сайн. Харин энэ Байнгын хороон дээрээ ингээд өөлж алдааг нь олохдоо биш ер нь зүгээр цаашдаа Монгол Улс эд нарыг яаж үр дүнтэй зангидаж нэгтгэж өөрсдөө хөтлөгч нь болох талаар шийдэл гаргахын тулд илүү дүгнэлт гаргаж байгаад дахиж ярилцах ёстой гэж бодож байна. Яг Байгаль орчны дээр жишээ загвар болгоод энэ бол зөвхөн энэ салбар бусад салбар ч гэсэндээ үр дүнтэй жишиг загвар болох болно оо. Тэгээд Одонтуяа саяынхаа хэлж байсан юмыг би зөв гэж дэмжиж байна. Тэгээд танд амжилт хүсье ээ.

С.Ганбаатар: Гишүүд асуулт асууж дууслаа.

Миний зүгээс 2 тодруулах зүйл байна. Ер нь бол гишүүдэд мэдээлэл өгөхөд Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2 хамтарч хуралдаж байгаа нь ганцхан Байгаль орчны яам биш бусад яамдуудаа ингээд дараалуулаад сонсож байгаа. Дараа нь Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрлэлийн яамыг сонсоно. Аж үйлдвэрлэлтэй холбоотой яамдуудаа сонсоно. Энэ дээр харин ч гэж Байгаль орчны яам бол бас энэ асуудлыг ингээд эзэнгүйдүүлчихсэн байна. Бас ингээд газар хэлтсээ байгуулж зохион байгуулалтад оруулаад үндсэндээ нэг ажлаа аваад 6 сар болж байгаа хүмүүсээс юу ярих вэ дээ. Би авч байгаа энэ тайлангууд өнгөрсөн 2024, 2023 онд тайлагнасан тайлангууд дээр 86.7 хувь нь буцаагаад гадагшаагаа цалин болоод гараад явчихсан байгаа. Нэг төсөл нэгхэн төслийг л би жишээ нь дундаж.

Тэгэхээр энийг зүгээр Улсын Их Хурлын гишүүдээс өөр анхаарах хүн ер нь Монголд байхгүй шүү дээ бид л хариуцна. Тэгээд миний 1 дүгээр асуулт. Түрүүн сайд нэг чухал юм ярьсан. Зарим төслүүд дээр Бид хүч хүрэхгүй байна нөлөөлж чадахгүй байна, аймаг орон нутагт энд арай чухал юм биш үү, энэ аймаг руу энэ рүү болох уу гэж асуухад бид нөлөөлж чаддаггүй ээ гэж хэлсэн. Ийм олон 100 тэрбум төгрөг олон 100 сая доллар их наяд төгрөг Монголд орж ирээд сайд болон Улсын Их Хурлын гишүүдийн ямар ч оролцоогүйгээр хаашаа явах нь тодорхой байж байвал энэ орны улс төрд нөлөөлж байна гэсэн үг шүү дээ. Зүгээр аймшигтай юм болж байна шүү дээ энэ чинь. Энийг бид эргэж харахаас өөр аргагүй болсон. Ажлын хэсэг байгуулна, хяналт тавина, шийдвэр гаргана.

Тэгээд миний тодруулах асуулт гэвэл Сангийн яаман дээр Сангийн яамны төлөөлөл байхгүй байх. Тэгэхдээ Сангийн яаман дээр энийг аудитын байгууллага дээр энэ төсөл болгон дээр дүгнэлт гардаг уу? Сангийн яаман дээр хуучин чинь энэ зээл тусламжийн газар гэж байдаг байсан. Тэд нар яг энэ дээр дүгнэлтүүдээ Байгаль орчинд гаргаж өгдөг үү гэсэн нэгдүгээр асуултыг би асуучихъя.

Хоёрдугаарт, үгүй ээ та нар бод доо гоё шүү. Монголын ард түмний зовлон зүдүүрийг уяртал нь нулимс гартал бичиж байгаад Монголын ард иргэдийн иргэдийн нэрээр оруулж ирээд дараа нь Монголын ард иргэд дараа нь төлөх энэ төслийг Монголын ард иргэдээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд нь ямар ч мэдээлэл байхгүй нэмж мэдээлэл өгөөрэй гэдгээс цааш юм ярихгүй сууна гэдэг бол дахиж ийм тэнэг байдал бид гаргахгүй ээ. Ажлын хэсэг байгуулна.

Тэгэхээр энэ ТУЗ буюу тэр ТУЗ гэж байгаа янз бүрийн нэртэй байгаа шүү. Би намайг Хөдөлмөрийн яамтай ажиллаж байхад бол тэр нэг ТУЗ шиг яамдаас бүтсэн нэг хэдэн дарга нар байдаг. Эд нар ямар хариуцлага үүрдэг вэ? Бүгдийг нь ингээд цалин болгоод гадагшаа гараад явж байхад үр дүн байхгүй байна гэж хэлэх хариуцлага тооцож чадах уу? Тэдэн дээр ямар хариуцлага байдаг вэ? Би ийм 2 асуулт асууя. Одонтуяа сайд хариулъя.

С.Одонтуяа: Тэгэхээр тодорхой хэмжээний зээлийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа төсөл дээр би Ганбаатар гишүүний ярьсан зүйлтэй санал нэг байна аа. Үнэхээр энэ зээлийн үр өгөөж нь ямар байх юм. Энийг хэрхэн эргээд төлөх юм гэдэг зүйл дээр би санал нэг байна. Ер нь зээлээр бол голцуу бид нарын өөрсдөө хэрэгжүүлж чадахгүй байгаа энэ цэвэр усны төслүүд гээд ийм гол гол төслүүд явж байгаа. Зүгээр бусад буцалтгүй тусламж дээр бол би энэ Монгол Улсад хэрэгжсэн бүх төсөлд л баярлалаа л гэж хэлнэ. Яагаад гэхээр бид нарт өөрсдөө төсвийн хөрөнгөөрөө хийсэн бол энэний хэдэн хувийг нь ч хийхэд хэцүү. Тэгэхээр энэ Байгаль орчин хамгааллын салбар гэдэг нь өөрөө бүүр далай шиг том санхүүжилт шаардсан салбар юм байна. Тэгээд би одоо энэ олон төслүүдийг судлахад бол бүгдээрээ л манай улсын энэ Байгаль орчин, экологийн нөхцөл байдлыг сайжруулъя гэсэн ийм л буцалтгүй тусламжийн төслүүд байдаг. Энд бол мэдээж одоо тодорхой хэмжээний үр дүнгүй хэрэгжсэн зүйл байгааг үгүйсгэхгүй. Гэхдээ дийлэнх нь маш их асуудлыг бид нарын өөрсдөө шийдчихэж чадахгүй маш олон асуудлуудыг шийдсэн байгаа.

Тийм ч учраас бид нар бол сая тэр гадагшаа яваад одоо энэ манай улсад ийм ийм проблем байна. Энэ усны асуудал байна. Энэ цөлжилтийн асуудал байна. Энэ дээр санхүүжилт өгөөч, энэ дээр буцалтгүй тусламж өгөөч гээд л бүүр ичих ч үгүй хамаг юмаа гуйж гуйж л ирсэн. Ер нь бид нар яаж ажиллахаас энэ салбарын тэр том санхүүжилтийг яаж татах вэ гэдэг нь шалтгаалах юм байна лээ. Тэгэхээр би бол зүгээр энэ дээр буцалтгүй тусламж дээр бид нар хэтэрхий нэг их хатуурхаж буруу болов уу. Тэгэхдээ энийгээ Улсын Их Хурлын гишүүд бид нар дотроо яриад ийм ийм зүйлүүд дээр нь ярьж хэлэх зүйл байгаа гэж үзэж байна аа.

С.Ганбаатар: 5 номерт тодруулж хариулъя.

Ү.Энхтайван: Тэгэхээр энэ төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн мэдээллийг Сангийн яам бол PMS гээд систем дээрээ авч байгаа. Энэ систем нь шинэ нэрээрээ PMS. Өмнө нь бол Адамес гээд систем байсан. Энд ерөнхийдөө төслийн санхүүжилт талаас нь бол мэдээлэл ирэх гэж байгаа. Бид бүхэн түрүүний дахин дахин яригдаад байгаа тэр үр ашиг талаас нь үнэлэх ийм систем рүү схемээ

угсарчихсан ингээд орж байгаа. Тэрийгээ бид бүхэн ES гээд манай яамны нэгдсэн мэдээллийн сан Байгаль орчны нэгдсэн мэдээллийн сан гэдэг сан руу төвлөрүүлж дүгнэж оруулах гэж байгаа гэдгийг л дахин дахин дурдъя даа. Сангийн яамнаас бид нарт мэдээлэл ирдэггүй байгаа. Бид бүхэн харин төслийнхөө ерөнхий мэдээллүүдийг явуулдаг байгаа.

С.Ганбаатар: Ингээд ажлын хэсэг байгуулаад энэ рүү нэлээн нарийвчилж орох юм байна. Тэгээд би сая зүгээр тодруулж санал хэлэхэд бол цэнгэг усны асуудал дээр ганцхан 186 мянган доллар байна. 2023-аас 2024 онд хэрэгжинэ гээд. Тэгээд л менежмент арга зүйн зөвлөгөө өгч нэг цаас үйлдвэрлэж өгнө өө л гэсэн юм байна. Энийг голох юм биш ээ. Буцалтгүй тусламж гэдгийг өөрсдөө оруулж ирж буцалтгүй тусламж өгсөн нэрээр 70, 80 хувийг нь цалин болгоод аваад гаргаж авах гэж байгаа бол бид ярих ёстой. Одоо бид асуудалд ийм гуйлгачин сэтгэлгээгээр хандана гэж байхгүй. Яг бодитой бидэнд юу хийх гэж байгаа юм, ямар туршлага байна? Гадныхнаас сурах юм их бий. Тэгэхдээ бид нөхцөл болзлоо тавих хэмжээний тусгаар улс гэж би итгэдэг.

Ингээд манай гишүүд асуулт асуулаа. Одоо үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ингээд асуудал нь үнэхээр сэтгэл өвдмөөр чухал асуудал учраас Очирбат гишүүнээр. Идэрбат гишүүнээр тасаллаа. Ингээд Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Ингээд олон гишүүн их нарийн яг шалгуур үзүүлэлт, үр нөлөө, үр дүн асуугаад, ямар өртгөөр бид нар ямар үр дүнд хүрч байгаа гэдэг дээрээ яг анхаарч энэ асуулт асууж, үг хэлж байгаад маш их баяртай байна аа. 2 Байнгын хороо хамтарч хуралдаж байгаа болохлоор 2 Байнгын хорооны дарга болон референтүүдээсээ хүсэх зүйл байна. Цаашдаа энэ яамдуудаас ирж байгаа материал дээр яг өнөөдрийнх шиг үр дүн, үр нөлөө, шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин ийм байдлаар энэ төсөл хөтөлбөрүүдийн агуулгыг нь авмаар байна. Тэгээд материалтай нь урьдчилж бид нар танилцах юм бол ямар төсөл дээр бид нар хэдэн төгрөг зарцуулаад, ямар өртгөөр, ямар үр дүнд хүрээд байгаа юм бэ гэдгийгээ эхлээд мэдчих боломжтой.

Тэгэх юм бол бид нар илүү цаашаага илүү чанартай хэлэлцүүлэг буюу яг энэ төсөл дээр бид нар ийм төгрөг зарцуулж байсны оронд илүү үр дүнтэй төсөл дээрээ цаашдаа төсөв тавиад явдаг болмоор байна шүү дээ гэсэн ийм зүйл рүүгээ шилжмээр байгаа юм.

Хоёрдугаарт нь, Төсвийн хавсралт нэг байгаа. Бүх төсөв улсын төсвөөр зарцуулж байгаа, төсөв өртөг арга хэмжээ бүгдээрээ байж байгаа. Тэрний шалгуур үзүүлэлт дээр байгаа зүйлүүдийг ашигламаар байна.

Гурав дахь зүйлс нь Алсын хараа 2050 дээрээ бид нар хавсралтаараа шалгуур үзүүлэлт буюу тоон болон чанарын үзүүлэлтүүд байгаад байгаа 73 ширхэг зүйл байгаад байгаа. Салбар салбараараа 9 бүлэг болоод хуваачихсан. Өнөөдрийнх бол жишээ нь 6 дугаар бүлэг буюу ногоон хөгжил дээр хамаарагдах асуудлууд байгаад байгаа. Тэгэхлээр бид нар урт хугацаандаа ямар үр дүнд хүрэх гэж байгаа юм бэ гэдгийгээ бас яамдуудын энэ тайлан танилцуулга дээр зэрэг авдаг болмоор байна. Тэгэх юм бол цаашдаа бид нар ингээд хэн Улсын Их Хурлын гишүүн байхаас, хэн яамны сайд байхаас үл хамаараад манай улс зарцуулж байгаа хөрөнгө мөнгө нь зөв үр дүнтэй зүйлдээ зарцуулагдаад иргэд олон нийтийн амьдрал сайжраад, ААН-үүдийн орлого дээшлээд энэ зөв голдирол руугаа явах боломж бүрдэх юм.

Тэгэхээр энэн дээр манай Байнгын хорооны дарга нар болон референтүүд маань сайн анхаараад ийм байдлаар яг мэдээлэл авахдаа ийм мэдээллүүдийг заавал гаргаж өг гэсэн байдлаар шаардлага хүргүүлээд тэрэн дээр нь урьдчилж танилцаад хэлэлцдэг болъё гэсэн тийм санал байна. Тэгээд цаашдаа Байгаль орчны яамныхандаа ажлын өндөр өнж амжилт хүсье. Яалт ч үгүй их төсөв хөрөнгө дутагддаг гаднын мэргэжлийн боловсон хүчин хэрэгтэй салбар. Сая яг хэлж байгаа нөгөө байгууллага болгон дээр KPI байгаа гээд тэгж байгаа тэ. Тэрийгээ бас нэгтгээд авах нь ч гэсэн манай улсад маш их хэрэгтэй зүйл шүү дээ. Тэрнийгээ төсвийн 1 дүгээр хавсралт Алсын хараа 2050-ийн хавсралтууд дээрээ заагаад тусгаад явах юм бол цаашдаа зөв голдиролдоо ороод манай Байгаль орчны салбар сайн сайхан болоод явах боломж нь бүрдэх болохоор саяын хэлж байгаа энэ төслүүдээс гарч байгаа KPI-уудыг шалгуур үзүүлэлтүүдийг нь төрийн бодлогодоо яаж тусгаж авч явах вэ гэсэн тэрэн дээр анхаарч ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд ирэх 7 хоногтоо багтаад тэр төсвүүдийн шалгуур үзүүлэлт болон хүрч байгаа үр дүнгүүдийн мэдээллийг хүргүүлнэ гэж байсан.

Өнөөдөр энд байгаа ирсэн бүх гишүүдэд хүргэхийг хүсэж байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Манай Лувсанжамц гишүүн маш чухал санаа хэллээ. Байнгын хорооны эрхэм өндөр зэрэглэлийн хүндэт нөхөд ажилтнууд минь анхаараарай. Яамдын зүгээр өгсөн мэдээллийг дамжуулж өгөх биш тодорхой цензур тодорхой нөхцөлтэйгөөр бүүр дэлгэрэнгүй мэдээллээр гишүүдийг хангах ёстой. Тэр хэмжээгээр бид шийдвэр гаргалтад оролцоно гэдэг ийм байр суурийг хэлж байна. Протоколд тэмдэглэж үлдээе. Жаргалсайхан гишүүн үг хэлье.

Д.Жаргалсайхан: Бид хэд ингээд л нэг Байнгын хороо хуралдахаар л материал яг зэрэгцээд л ороод ирж байгаа юм. Тэгээд л нөгөө асуух асуулт хариулт гээд л нөгөө материалаа эргүүлж тойруулсаар байтал. Тэгэхээр ер нь манай энэ ажлын албаныхан бас нэг өдрийн өмнө ч юм уу тэ хэлэлцэх асуудалтай холбоотой материалаа өгчихмөөр байна аа. Тэгэхгүй бол бид хэд нэг судалж энэ дээр оновчтой зөв хариултуудаа авах, цааш нь шийдвэрлэх арга хэмжээн дээр ажилламаар байна гэдгийг хэлэх гэсэн юм.

Мөн дээрээс нь манай яамныхан маань ингээд тодорхой мэдээллийг өглөө. Баярлалаа та хэддээ. Ойлгомжтой энэ 28 төслийн 27-нд буцалтгүй байна тэ? Тэгж ойлголоо. Тэгээд үнэгүй юм гэдэг чинь эргээд бид нар хамаагүй хандаж болохгүй шүү гэдгийг давхар хэлэх гэсэн юм. Гэхдээ бид нарын хувьд гарч байгаа үр дүн байгаа. Би тэр ногоон төгөл билүү тэ? Ногоон хэрэм төслийг бол маш их үнэлдэг тэрнийг хардаг. Дээрээс нь нэг хариуцлагатай уул уурхай, ер нь энэ тогтвортой амьжиргаа төсөл гээд л ер нь олон улсын зөндөө л төслүүд орон нутагт хэрэгждэг ээ. Гэхдээ бид нар ер нь зарим юманд оролцдог баймаар байна аа яам. Олон улсын энэ байгууллагууд өөрсдөө ингээд дураараа ингээд яваад байдаг. Орон нутагтай ч хамтарч ажилладаггүй. Ирээд явсан ч бараг ингээд мэдэгддэггүй.

Тэгэхээр энэн дээр бид нар нэг оролцоогоо их сайжруулж, хамтын ажиллагаагаа сайжруулж илүү их үр дүнтэй оновчтой болгохгүй бол ажиллахгүй байгаа. Тэгээд ихэнх гишүүд бас тэр талын юм хэлж байна шүү дээ тэ? Дээрээс нь би энэ Лувсанжамц гишүүний ярьж байгаатай санал нэг байгаа. Гарч байгаа үр дүнг их сайн тооцож иргэдэд мэдээлэхгүй бол бид нарын хувьд ямар үр дүн гаргаж байгаа гэдгээ бас манай энэ салбарын хувьд ч гэсэн хийж байгаа ажлын үр дүнгүүдийг харж баймаар л байна л даа. Тэгээд дээрээс нь бас энэ жишээ нь ингээд

энэ бэлчээрийн даац хэтэрсэн. Би түрүүн асуулт дээр асуусан. Энэ бүс нутгуудыг яг энэ бэлчээрийг зөв зохистой ашиглах бэлчээрийн менежментийг сайжруулах дээр бол илүү та хэд маань анхаарч өгөөч ээ. Энэ дээр юу гэдэг юм, тэр малчдыг, тэр МАА эрхэлж байгаа хүмүүсийг мэдээллээр хангах асуудал эрсдэлээс хамгаалах асуудал дээр сайн мэдээлэгдүүлэхгүй бол манай малчид ерөөсөө тооны хойноос л яваад л тэрийг орон нутгийн удирдлагууд нь хэлж ярихаар яг ингээд нэг сайн буухгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ ОУБ-ын энэ судалгаа шинжилгээ энэ бүх юмыг нь хийгээд яасан улсууд ингээд дор дор нь ингээд сургалт янз янзын юм ингээд мэдээллээр хангаад байх юм бол энэ хүмүүс малын тоо биш чанар руу анхаарах шаардлагатай байгаа. Мөн дээрээс нь тэр өвөлжөө хаваржааг тохижуулах. Энийг сайжруулах дээр нэлээн анхаармаар байна. Тэгээд малчдын энэ эрүүл мэнд энэ энэ тал дээр нэлээн анхаарахгүй бол үнэхээр бидний хувьд түрүү жилийн энэ гамшигтай холбоотой асуудлууд дээр бол харлаа шүү дээ. Юуны тэр мал битгий хэл өөрийнх нь асуудал үнэхээр хүндэрчихсэн байгаа асуудлууд байж байгаа байхгүй юу тиймээ? Тэгээд энэ тал руу бас бидний өмнөх ОУБ-аас орж ирсэн тэр зээл тусламж янз янзын юмнууд орж ирсэн шүү дээ. Тэрийг хөрөнгө хүртээмжийг нь сайжруулах руу бид нар анхаарахгүй бол яг энэнээс хохирсон иргэд л тэр тусмаа манай хангайн бүс дээр гэхэд Архангай аймагт л маш их айл өрхүүд л малгүй болчихсон, хохирчихсон, орлого байхгүй болчихсон.

Цаашид яг яаж энэ хүмүүст төрийн үйлчилгээг хүргэх вэ гэдэг дээр ч гэсэн асуудал их байсан л даа. Тийм учраас энэ нөхцөл байдлыг тэр олон улсын байгууллагуудад хүргэж яг оновчтой энэ хүмүүсийг цааш нь бусад өөр ямар эх үүсвэрээр малжуулах юм уу амьжиргааг нь дэмжих ямар нөхцөл бололцоо байдаг юм гэдэг дээр хандуулах нь их чухал юм шиг ингээд санагдсан юм аа.

Тийм учраас энэ сонгон шалгаруулалтыг өгөөд бусад төсөл хөтөлбөрүүдийг яг ийм онцгой газруудаар бэлчээрийн даац нь хэтэрчихсэн. Тэр амьжиргаа нь уначихсан ийм айл өрхийг оновчтой болгож, хүртээмжийг сайжруулах дээр бас ажиллаж өгөөч ээ гэж ийм хүсэлт байгаа шүү. Энийг уламжлах гэсэн юм.

С.Ганбаатар: Баярлалаа Дамдинсүрэнгийн Жаргалсайхан гишүүн үг хэллээ. Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн үг хэлнэ ээ.

П.Мөнхтулга: 28 төслийн 26 төсөл нь 2013 оноос 2023 оны хооронд эхэлсэн байна. 2 төсөл нь 2024 он буюу одоо энэ Засгийн газраас эхэлсэн байна аа. Тэгэхээр яах вэ нэг дутагдалтай юмнууд олон харагдаж байгаа ч гэсэн үр дүнг олон шалгуураар үзүүлээч ээ гэсэн ийм гишүүдийн хүсэлт хүлээлт байгаа. Тэгэхдээ салбарын сайд салбараас нэг ч хүн энэ өмнөх Засгийн газрын үед шийдсэн юм гэж хэлсэнгүй. Тэрэнд баяртай байна. Засгийн газар салбарынхаа уялдаа холбоог өөрсдөө цээжээрээ хамгаалаад цааш нь үргэлжлүүлэх ёстой. 2024 оноос хойш цаашдаа дахиж ийм гэрээ, тусламж, зээл ийм тодорхойгүй юмаар явмааргүй байна.

Тэгэхээр цаашдаа хэдүүлээ энэ ажлын хэсгээсээ бас нэг журам гаргавал яасан юм бэ? Эсвэл нэг барьж мөрддөг кодификац, ямар нэртэй албан бичиг байх нь тухайн үедээ шийднэ биз. Ямар ч байсан нэг ийм буцалтгүй тусламжийг яаж зарцуулах ёстой юм, зөвлөмж ч гэдэг юм уу нэг тийм юм гаргаж өгвөл яасан юм бэ? Үүнд ийм 2 Байнгын хороо нийлж хуралдаж байгаа юм чинь. Тэгээд Байгаль орчны яаманд амжилт хүсье. Гадаадад ажиллаж байсан гайгүй залуучууд авчраад шинэ баг бүрэлдэхүүнээр салбарын төлөө зоригтой зүтгэе гэж байгаа баг бүрэлдэхүүнд

амжилт хүсье ээ. Тэгээд ирэх жилүүдэд салбарт том өөрчлөлт гарна гэж найдаж итгэж байгаа шүү.

Б.Бейсен: Замира гишүүн үг хэлье.

С.Замира: Ер нь өнгөрсөн он жилүүдэд Монгол оронд хэрэгжүүлж байсан энэ төслүүд хэр зэрэг үр өгөөжтэй болсон? Монгол Улсын хөгжилд ард түмний амьдралд хэр зэрэг нөлөөлж байна гэж тодорхой бус байна даа хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай хэрэг. Тэгэхдээ бол сая Ганбаатар гишүүний хэлж байгаа нь үнэн шүү дээ. Монголын ард түмний зовлонгоор нэг гадаадынхан тоглож баахан тэрбум тэрбумаар доллар оруулж ирээд өөрсдөө аваад явчихдаг. Тийм байж болохгүй ээ. Буцалтгүй тусламж байсан ч тэгээд дахиж төлөх эргэн төлөх нөхцөлтэй байсан ч уг нь Монгол Улс өөрөө удирдах ёстой. Одоо үнэнийг хэлэхэд гуйлгачин шиг царайлаад суух одоо нэг хэдэн төгрөг гуйгаад та авбал 70, 80 хувийг нь авч болно гэсэн царайтай сууж байж болохгүй ээ. Энэ тэгэхдээ бол яг Одонтуяа сайдын үед гарч байгаа гэж би бодохгүй байна. Тэгж харахгүй байна. Энэ он удаан жил үргэлжилж ирсэн байх аа. Тэгээд нөгөө гадаадынхан тэгээд сурч авсан тэр зангаа одоо хүртэл тавихгүй байгаад байх шиг байна.

Тийм учраас энэ удаагийн төрийн 126 гишүүнтэй маш хүчтэй Засгийн газар бүрэлдэн тогтсон байдаг. Тийм учраас энийг шинэчлэх тал дээр уг нь хэдүүлээ санал санаачилга гаргах нь зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд ажлын хэсэг байгуулаад уг нь энэ бүгдийг нь ганц Байгаль орчны яам биш бүх яамууд өөр ямар газар дээр нь ийм тусламж зээл орж ирж байгаа тэр бүгдэд уг нь ер нь сонголт хийсэн нь дээр юм шиг байна аа. Энийг нэг зохион байгуулах нь зүйтэй.

Тэгээд уг нь Баян-Өлгий аймгийг Засгийн газар аялал жуулчлалын бүс нутаг гээд зарласан байдаг. Тэгсэн чинь тэр Алтай Таванбогдоос өгсүүлээд уг нь хогонд дарагдсан зөвхөн Баян-Өлгий биш Алтай Таванбогд биш биш бүх Монгол Улсын газар нутаг нь энэ хогонд дарагдаж гүйцлээ л дээ. Тийм учраас ер нь энэ тал дээр санал санаачилга гаргаж том төсөл хэрэгжүүлэх юм уу яадаг юм. Энэ тал дээр нэг сайдаас хүсэх юм бол энд нэг сайн юм хийж өгөөч ээ гэж хүсэх байна аа. Ямар боломж байна? Эсвэл төсөл бичээд бид нар нөгөө парламентын бүлгэм гээд байгуулаад яваад байгаа шүү дээ. Тийшээ хандах юм уу ийм байдалд хүрчихлээ. Уур амьсгалын өөрчлөлттэй байгалийн хөрс нь ч гэсэн ингээд бохирдож байна. Энийг дэмжиж өгөөч гэсэн төсөл хэрэгжүүлэх тал дээр бүгдээрээ Их гурвын гишүүдэд хандаад ч болов ийм том төсөл хэрэгжүүлэх нь зүйтэй болов уу гэж бодож байна.

Тэгээд тэрбум модын төсөл дээр яг ямар юу хэрэгжүүлэх гэж байгаа тэрнийг тодорхой болгож нэг танилцуулаадхаач ээ гэж хүсэх байна.

Ингээд Байгаль орчны яамныханд амжилт хүсье. Цааш цаашдаа их хариуцлагатай байж орж ирсэн юм нь тодорхой байж тэгээд хэдүүлээ хамтдаа нэг нь дэмжээд нөгөөдөх нь хийгээд л ингээд амжилтад хүрье дээ. Баярлалаа.

С.Ганбаатар: Замира гишүүнд баярлалаа. Мандхай гишүүн үг хэлнэ ээ.

М.Мандхай: Эхнээс нь нэг эхлээд явчихъя даа 4 асуудал байна. Эхний нэг хамгийн эхний төсөл дээр нийтдээ 23.1 сая доллар зарцуулахаар энэ тусгажээ. Тэгээд төслийн ерөнхий үндсэн зорилгыг нь л би ярих гээд байгаа юм. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг дээшлүүлэх байгалийн аюул

гамшгаас сэргийлэх чадамжийг нэмэгдүүлэх шинэ технологи нэвтрүүлэх гэсэн гол базаад хэлэх юм ийм төсөл байгаа. Тэгээд энэ өөрөө 21 оноос хойш явсан. Гэтэл одоо энэ хэрэгжсэн аймгийг нь харах юм бол Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар гээд зүүн бүс. Ингээд харахаар хамгийн их, өнгөрсөн зуднаар хамгийн их мал хорогдсон аймаг бол өөрөө Дорнод, Сүхбаатар аймаг байгаа. Тэгээд энэ 2021 оноос хэрэгжсэн төсөл өөрөө яг энэ зуднаас малчид энэ уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг дээшлүүлээд аюул гамшгаас сэргийлэх гэсэн хэмжээнд 23.1 сая доллар зарцуулчихжээ. Тэгсэн мөртөө яг үндсэн зорилгоо ингээд биелүүлэх явцын үр дүнг нь харахаар энэ чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн нь өөрөө маш хангалтгүй нэг сургалт зохион байгуулсан байна. Тэгээд тэр чигээрээ зах зээлийг өргөжүүлэх ажлууд хийгдээд харагдаж байна л даа.

Бүтээгдэхүүний шилдэг туршлага хэрэгжүүлсэн, мэдлэгийн бүтээгдэхүүн бий болгосон гээд. Үндсэн зорилгынх нь гол жин дааж байгаа асуудал чинь өөрөө яаж энэ уур амьсгалын өөрчлөлтөөс дасан зохицоход бэлэн байх вэ гээд. Гэтэл энэний чинь үр дүн нь өнгөрсөн зуднаар энэ Сүхбаатар, Дорнод гэдэг аймаг бол үндсэндээ 8.1 сая бид нар чинь малаа алдсанаас хамгийн их жин даасан аймаг нь өөрөө энэ аймаг. Тэгэхээр энэ төслийн үр дүн бол нэг ийм үзүүлэлттэй байгаа юм болов уу гэж би бол яг үндсэндээ тааж байна. Тэгэхдээ энэ тодруулж асуумаар байна. Яг энэний үр дүн нь яасан бэ гээд.

21 дээр төсөл ялгаа байхгүй 2024 онд хэрэгжиж байгаа. Үндсэндээ 2024-2026 гээд 2 жилийн хугацаанд хэрэгжих 2.6 сая доллар байгаа юм. Тэгээд ингээд харахаар төслийн нэг жил нь буюу 2024 онд бол үндсэндээ баг нь ч томилогдох гэж явсаар байгаад, захирлаа ч томилж аваад томилогдсон юм уу томилогдоогүй нь тодорхойгүй 2024 он гээд нэг жил нь дуусчихсан. Тэгээд 2025 ондоо бид нар 25-аас 26 онд нэг жилийн хугацаанд үндсэндээ энэ 2 сая доллар зарцуулах гээд байгаа байхгүй юу 2.6 сая доллар чинь цалин явлаа гэхэд 600 мянга нь явлаа гэж зүгээр тооцъё. Нөгөө бүтцийг нь хараагүй болохоор мэдэхгүй байна. Тэгэхэд бид нар нэг жилийн хугацаанд 2 сая долларыг нутгийн иргэдийн оролцоотойгоор байгалийн нөөцийн менежментийг хийх үр дүн гаргаж чадах уу гэдэг асуулт байгаад байгаа юм.

Гуравт нь 23-ын төсөл. Бэлчээрийн энэ менежментийг сайжруулах дулааралд дэлхийн дулааралд голлох нөлөө үзүүлж хүлэмжийн хийн шингэлтийг нэмэгдүүлнэ. Ингээд нүүрстөрөгчийн зах зээлд оролцсон МАА-аас гадна нэмэлт орлоготой болох боломжийг тэлнэ ээ гэсэн энэ том ТЭЗҮ-ийн төсөл байх шиг байна. 166.4 мянган доллар. Тэгээд энэний үр дүнг нь харахаар би асуух гээд байгаа асуулт нь болохоор энэ төслийн үндсэн зорилго санхүүжилт нь яг гарсан уу? Тэгээд энэ 2 юманд зарцуулчихсан байгаад байгаа юм. Эко аялал жуулчлалын бааз, жижиг оврын арьс боловсруулах үйлдвэр, Хэнтий аймагт зөгий үржүүлэх ААН-үүдэд мөнгө гарчихсан үндсэн зорилгоосоо өөр. Тэгээд 2025 онд буюу хамгийн сүүлийнхээ жилдээ яг энэ гол зорилго дээрээ тусгасан асуудлууд нь орчихсон байгаад байгаа байхгүй юу. Тэгээд 1 жилийн хугацаанд энэ үндсэн гол зорилго чинь биелэгдэх юм уу? Ингээд өөр бааз барих ингээд шал өөр юманд төслүүд нь явчихсан байна аа.

25-ыг дахиад хэлье. Нийслэл хотын орчны бохирдлыг бууруулах уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх замаар оршин суугчдын амьдралын чанарыг сайжруулах гэсэн зорилго тавьсан. Энэ дээр ялгаа байхгүй энэ том.

С.Ганбаатар: Мандхай гишүүн маш чухал асуудлуудыг хөндөж тавилаа. Үг хэлж дууслаа. Ингээд Мандхай гишүүний саяын энэ тодруулж үг хэлсэн энэ

асуудлууд дээр та бүхэн бүгдээрээ албан ёсоор Мандхай гишүүнд тайлбар хаяглаж өгөх ёстой шүү. Ингээд Идэрбат гишүүн үг хэлнэ ээ.

Ц.Идэрбат: Бид хэд одоо Одонтуяа сайд их зөв зүйтэй зүйл хийж байна гэж би хэлэх гэж байгаа юм. Энэ бол ингээд ил болгох ёстой. Тэгээд ер нь Монгол Улс 1993 оноос хойш хэрэгжсэн төсөл хөтөлбөр гэхэд овоо л юмнууд дуулдаж байна. Тэр үеийн нөхцөл байдал өнөөдрийн нөхцөл байдал 2 ямар байгаа билээ. Тийм учраас ер нь энэ төсөл хөтөлбөртэй холбоотой асуудлууд дээр ирсэн болгон сайн байна гэж хэлэхгүй. Сая Байнгын хорооны даргын хэлж байгаа янз янзын л юм давхар явдаг. Ийм цаг үед байгаа учраас бид энэ төсөл хөтөлбөр дээр үр өгөөж олон талын юмаа бодох ёстой байх. Гэхдээ яг салбар хариуцаад ажиллаж байгаа сайдын хувьд улсын төсвийн хөрөнгө оруулалт тавьчихвал боломжгүй олон асуудлууд байдаг. Тэгээд энийг шийдэхэд энэ төсөл хөтөлбөр бол бас их чухал үүрэгтэй. Тийм учраас өнөөдрийнх шиг ийм нөхцөл байдал үүсгэхгүйн тулд салбарын сайдад эрх зүйн ямар шинэчлэлүүд дэмжлэгүүд хэрэгтэй байгаа вэ? Одоо энэ хууль юмаа өөрчлөхөд салбарын сайдын хувьд манай хууль ийм юм гээд хэлээд сууж байхад олон зүйл бас зүг чигээ олох болов уу гэж. Ингэж би бодож байгаа юм.

Тийм учраас ажил эрхэлж байгаа хүнд олон зовлон байдаг учраас би тэр талаас нь харъя гэж. Ингээд төслийн танилцуулгаас ингээд л харахад би яах вэ өөрөө орон нутагт ажиллаж энэ хогтой их ноцолдсон хүн л дээ. Үнэндээ Монгол Улсад очоод энэнийг л нэг дуурайгаад л нэг хогоо янзалчихъя даа гэх газар нэг ширхэг байхгүй. Гэтэл энэ Улаанбаатарт хэрэгжиж байгаа хэрэгжсэн гэж энэ танилцуулга дээр явж байгаа энэ төслийн мэдээллийг яам нь Засгийн газар нь авч чадахгүй байна гэдэг чинь юу гэсэн үг вэ. Улаанбаатар хотын захиргаа нь энэ талаар юу ч мэдэхгүй, тайлан дээр нэг 500, 500 хүн цуглуулсан 30 тонн хог хаясан гэж. Тэгэхээр цаашид ийм зүйл би битгий гараасай гэж л ингэж л бодоод энэ үгийг би хэлж байгаа шүү л гэж ингэж хэлье.

Тэгэхээр яах вэ энэ Байнгын хорооноос цаашдаа ажлын хэсэг гараад ажиллах юм байна. Нэлээн юмнууд ил тод болох юм байна. Ялангуяа энэ мэдээлэл авч чадахгүйгээс болоод нүүрээ улалзуулаад сууж байгаа энэ төрийн албан хаагчид тэр хууль эрх зүйн орчныг нь нээж өгөөд яахлаараа Монгол Улсад хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийг салбарын яам нь мэдээллээ авч чадахгүй болтлоо бид тэдний өмнө тийм буурай байх ёстой юм бэ л гэдэг энэ талыг барьж тэр хууль эрх зүйн орчныг өөрчлүүлэх тал дээр санаачилгатай ажиллаарай л гэж би энэ удаагийн уулзалтын үр дүн цаашдаа гарах өнөөдрийнх шиг ийм нөхцөл байдал үүсгэхгүй том зүйл болох болов уу л гэж ингэж би дүгнэж хэлье ээ л гэж бодож байна. Баярлалаа.

С.Ганбаатар: Идэрбат гишүүн үг хэллээ. Ингээд Бейсен гишүүн Буланы Бейсен гишүүн үг хэлнэ ээ.

Б.Бейсен: Энэ өнөөдрийн энэ хуралд бас Байгаль орчны сайд, ажлын хэсгийнхэн урд яамны ч гэхгүйгээр өөрсдөө энэ цээжээрээ хамгаалаад төрийн ажлаа ингээд тасралтгүй явж байх ёстой гэдэг үүднээс ингээд цаашдаа ажилдаа яаж байгаад нь баярлалаа гээд хэлье. Гэхдээ энэ Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй энэ ажлаа уялдуулж явуулах аж шаардлагатай байна. Засгийн газрын мөрийн хөтөлбөрт 2 намын ч мөрийн хөтөлбөртэй байгаа. Алтай Таванбогдын үзэсгэлэнт байгалийн үзэсгэлэнт газар түшиглэсэн аялал жуулчлалын бүс байгуулна гээд. Өндөр хүчдэлийн асуудлыг Засгийн газар шийдсэн. Таванбогд хүртэл тэр Ерөнхийлөгчийн овоог хүртэл. Тэгээд л Хотон Хурган нуур хүртэл шийдчихсэн байгаа. Энэ зун ашиглалтад орчихно. Гэтэл энэ дээр отоглох цэг, ариун

цэвэр, хог хаягдлын цэг, бүс байхгүй ирсэн. Зөвхөн тэр Таванбогдын тэр Ерөнхийлөгчийн овоо хүртэлх 16 км газар 26 зам байгаа. Ерөнхийлөгч тэр Берталётоор бууж байхад тэнд ирсэн дотоодын жуулчид ярьж байгаа юм чинь энэ бүү мэд. Ингээд л ойлгохгүй байна шүү дээ энүүгээр нэг явуулж үзээч гээд тэгж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ замыг мөрийн хөтөлбөрт тусгаад нэг засчихвал тэр чинь Ерөнхийлөгчийн тахилгатай овоо шүү дээ. Төрийн тахилгат овоо. Энэ дээр нэг анхаарч үзээч ээ гэж хэлмээр байна, нэгдүгээрт.

Хоёрдугаарт гуравхан газар отоглох цэг, ариун цэвэр, хог хаягдлын бүс байгуулах шаардлагатай байгаа. Тэр Ерөнхийлөгчийн овоо хүрэх наад талын хамгаалалтын цэг байна шүү дээ. Тэнд нэг хэрэгтэй, нэг нь тэр Хотон, Хурган нуурын нарийн гүүр дээр, нэг нь Хар чулуутын гүүр дээр энэ гуравхан газар хог хаягдлын цэг, отоглох цэг, нөгөө талаар ариун цэврийн байгууламж наад талдаа байгуулах шаардлагатай байгаа л даа. Энэ дээр нэг анхаарч өгөөч гэдгийг хэлмээр байх юм. Тэр Асгатын яг тэр хуучин хотхон байсан газар хүртэлх тэр ойжуулалтын ажлыг Ерөнхийлөгчийн тэрбум модны хүрээнд тэрийг шийдчих боломж байгаа байх. Энийг тусгайлж хэлмээр байна.

Нөгөө талаар энэ хяналт шалгалтын ажлыг бид нар ажлын хэсэг гаргахгүй сая 1 хөтөлбөр дээр 86 хүн зөвхөн цалин хөлстэй явна гэж юу байдаг юм. Арван дөрөвхөн хувьд нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж юу байдаг юм. Энэний цаана мөнгө угаалт луйврын хэрэг байх шиг байх юм. Тийм учраас энийг бид нар АТГ энэ ажлын хэсэгтэй хамтарч шалгаад ер нь яахгүй бол энэ зэргээр ингэж явж ерөөсөө болохгүй.

Тийм учраас Одонтуяа сайд та энэ ажлын хэсгийнхэн байна та нар хамтраад энэ дээр нэг хяналт шалгалттай ажиллаач гээд захимаар байх юм. Тэгэхгүй бол ингээд үр дүнгүй гадаадын тусламж хөтөлбөр ингээд явж байвал болохгүй байх гэж бодож байна.

Нөгөө талаар сая нөгөө цөмийн радиацийн асуудал байгаа. Энэ нэг судалгааг Германыханд хэлчихвэл тэр нэг төсөл бид нар хэрэгжүүлэх боломж байгаа байх. Бид нар энэ дээр судалгаа хийлгүүлсэн дээр үед. Радиаци нь өндөр байна гэж тогтоогдсон. 1990 оны сүүлээр. Хавдрын өвчлөл их байгаа, цусны өвчин их байгаа тэнд. Энэ дээр нэг анхаарч өгөөч гэдгээ хэлмээр байх юм. Нөгөө талаар энэ тусгай хамгаалалттай газрын төлбөрийн асуудал байгаа. Урьд нь 3 мянга авдаг байсан дараа нь 5 мянга болсон нэг хүнээс. Нэг машинаас 10 мянга авдаг. Энэ төрийн санд ордог. Байгаль орчны яам Байгаль орчны газар энд зарцуулах эрхгүй. Энийг төлбөрийг нэмэх асуудал байгаа. Нөгөө талаар зарцуулах эрхийг нь авбал тэд нар улсуудад тэрийг зохион байгуулах боломж байгаа гэсэн санал хэлье ээ. Баярлалаа та бүхэнд.

С.Ганбаатар: Бейсен гишүүн үг хэллээ. Ганхүлэг гишүүн үг хэлнэ ээ одоо.

М.Ганхүлэг: Байнгын хорооны гишүүд Байгаль орчны яамныхандаа энэ оройн мэндийг хүргэе. Надад хэд хэдэн саналууд байгаа юм аа. Үргэлжлүүлээд илүү детальчлаад энэ төслүүдтэй холбогдолтой асуудлыг ярилцах юм байна гэж ойлгож байна. Энийг дэмжиж байна аа. Яах вэ ярилцаад явахдаа бид нар их сайн бодох хэтэрхий бас хянаж шалгах гэхээсээ илүүтэй илүү үр дүнг нь сайжруулахын төлөөх энэ агуулга руу чиглэх нь зөв болов уу гэсэн ийм байр суурьтай байгаа юм аа. Яах вэ гадаадын энэ төсөл хөтөлбөрүүд дээр сайн үр дүнгүүд гараад явж байгаа туршлагаудыг би өөрийн туршлагын хувьд мэднэ ээ. ХАА-н салбар дээр бас нэлээн

хэрэгждэг ийм хөтөлбөрүүд байдаг. Яах вэ цаашдаа бид нар төр улсын хэмжээнд их хэмжээний төсөв хөрөнгө зарцуулахгүйгээр жижиг жижиг төслүүд хэлбэрээр хэрэгжүүлээд энэ ажлыг цааш нь үргэлжлүүлж авч явах боломжтой юм байна үгүй юм байна гэдгийг энэ жишиг хөтөлбөрүүдээрээ дамжуулж бий болгох гэдэг л ерөнхий энэ гол санал энэ гаднын төсөл хөтөлбөрүүд дээр байна гэж ингэж хараад байгаа юм аа. Тэгэхээр энэ чиглэлийн ажлуудыг нь илүү дэмжих чиглэлээр ажиллах нь зөв байх гэсэн ийм бодолтой байна.

Би яах вэ санаагаа ойлгуулах зорилгоор Палау гээд аялал жуулчлалаар амьдардаг 20 мянган хүн амтай 340 жижиг арлаас бүрдсэн ийм улс байгаа юм. Тэгээд Палау улсын хувьд жуулчдын хувьд одоо хамгийн их ирж байгаа асуудал нь хүн амаасаа 8 дахин их жуулчин авдаг. Тэгээд гол асуудал нь хог хаягдлын асуудал болсон. Тэгээд энэ хог хаягдлын асуудлаа шийдэхийн тулд төрөөс маш олон төрлийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Гэхдээ маш энгийн аргаар, тодорхой, үр дүнтэйгээр бууруулсан ийм кэйсийн тухай та бүхэн мэдэх байх аа. Энэ тухай бас олон улсад сайн туршлага болгодог. Жишээлэх юм бол одоо орж ирж байгаа иргэн болгоных нь гадаад паспорт дээр нь штампыг нь буюу тамгыг нь дарахдаа Палау амлалт гэдэг ийм кампанит ажлыг зохион байгуулсан. Маш энгийнээр. Тэгээд би Палау улсын иргэдийн өмнө амлаж байна. Хог хаягдал, ан амьтан, энэ байгаль орчинтойгоо зөв зохистой бид нар зорчиноо амлаж байна гээд ингээд паспорт дээрээ гарын үсгээ зураад ингээд нэвтэрдэг нэг ийм энгийн аргаар энэ асуудалтайгаа дэмжиж гаргасан. Тэгээд энийг би ярьж байгаа шалтгаан нь бол бидний хийж чадахгүй байгаа илүү сайн ийм жишиг туршлагуудыг нэвтрүүлэх чиглэл дээр энэ гаднын төсөл хөтөлбөрүүд цаашдаа хэрэгжих ёстой. Саяын танилцуулж байгаа энд төслүүдийн нэлээдгүй хэсэг нь энэ бэлчээрийн асуудлын тухай, малчдыг соён гэгээрүүлэх тухай энэ асуудлууд яригдаж байна аа.

Тэгэхээр энэ их зөвлөх үйлчилгээгээр дамжуулаад бас яваад байгаа энэ санхүүжилтүүдийг чиглүүлэхдээ цаашдаа илүү Монгол Улс өөрсдөө бие даагаад хэрэгжүүлээд явах энэ чиглэл рүү нь анхаарах нь зөв байна гэсэн ийм саналыг хэлье гэж бодоод байх юм. Жишээлэх юм бол бид нар энэ бэлчээрийн ашиглалтын талаар малчдыг сургах энэ үйл ажиллагаа Монгол Улсад зайлшгүй хэрэгтэй. Тэгэхдээ 1 удаагийн төсөл хөтөлбөрөөр энийг явуулаад ингээд орхилгүйгээр МСҮТ, мэргэжлийн сургуулиуд эдгээр энэ боловсон хүчнүүдээ бэлдэж авч үлдэх тэр өндөр үнээр дийлэнх хувиа аваад байгаа зөвлөх үйлчилгээнийх нь зардлыг Монголчууд өөрсдөө бий болгоод авч үлдэх энэ чиглэл рүү нь шилжүүлэх байдлаар энэ төслүүдийг илүү сайжруулах ёстой юм гэдэг ийм саналуудыг тэмдэглүүлье ээ тэгээд ажлын хэсгийн энэ ажлууд дээр илүү нарийвчлаад ингээд явъя. Жижиг чулуугаар том чулуу хөдөлгөх өө гэж Монголчууд ярьдаг. Тэгэхээр энэ жижиг төслүүдийг үр дүнг нь үргэлжлүүлэх чиглэл дээр энэ Байнгын хорооноос гарч байгаа ажлын хэсгүүд ажиллана гэдэгт итгэлтэй байна.

С.Ганбаатар: Ганхөлөг гишүүн үг хэллээ. Үүрийнтуяа гишүүн үг хэлнэ ээ.

Д.Үүрийнтуяа: Одонтуйа сайд баярлалаа юуны өмнө. Нэлээн биднийг энэ 28 төслийн хүрээнд төсөл хөтөлбөрийн хүрээнд тодорхой мэдээллээр хангалаа. Мэдээж энэ төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилт үр дүнг нэг бүрчлэн үзэж танилцаагүй учраас өнөөдөр өгсөн мэдээллийн хэмжээнд гүйцэтгэл тийм байна гэж дүгнэх нь учир дутагдалтай байх. Тэгэхээр яг энэ байгаа мэдээллийн хүрээнд ажиглаж байгаа асуудлууд дээрээ саналаа хэлье.

Нэгдүгээрт, бид нар энэ төсөл хөтөлбөрүүдийг гаднын зээлээр санхүүжүүлж байгаа нөхцөлд маш болгоомжтой хандах ёстой юм аа. Үнэхээр энэ зээлээр санхүүжих үед бид нарт үр өгөөж юу вэ гэдгээ харахгүй бол сая 38 сая долларын АХБ-ны санхүүжилтийн эх үүсвэртэй энэ төслийн сүүлийн 2 жилд зээлийн хүү төлөгдөх юм байна гэж ойлголоо. Хөнгөлөлттэй болон энгийн нөхцөлөөр. Энэ 2 нөхцөлөөр тооцоод аваад үзэхэд өнөөдөр Лайбер 4.85-тай байна. Ингээд тооцоход л зээлийн хүүгийн төлбөр бид нар сүүлийн 2 жил 11.4 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт өгөхөөр ийм тооцоо харагдаж байна.

Тийм учраас бид нар энэ үнэхээр ийм хэмжээний хүү төлөөд нэмэлт зардал гаргаад явах төсөл мөн үү үгүй юу гэдгээ эдийн засгийн ач холбогдлоор нь эн тэргүүнд авч үздэг байхын тулд энэ арга хэмжээ төсөл хөтөлбөр дээр Эдийн засгийн хөгжлийн яамтай ажлын уялдаа холбоо нягт байх ёстой юм аа. Эдийн засгийн агуулгаар нь авч үзэх дараагийн асуудал карбоны асуудал, карбон кредитийн асуудал. Энэ дээр бид сайн дурын зах зээл дээр Монгол Улс тоглолт хийхэд үнэхээр бид ямар эдийн засгийн нөхцөл байдлыг боломжуудыг бий болгох боломжтой байгаа юм. Байгаль орчны яамнаа төлөвлөж байгаа энэ ялангуяа тэрбум модны хүрээнд хөрс сайжруулах, агаар, орчны бохирдлыг бууруулах технологийн сайжруулалтын хүрээнд ямар хэмжээний эдийн засгийн ач холбогдол бий болгох боломжтой байгаа юм бэ гэдэг зах зээлийн багтаамж энэ тооцоолол юман дээрээ манай Эдийн засгийн хөгжлийн яам харж ажиллах ёстой. Ингэж байж бид энд ямар хөрөнгө оруулалт хийж ямар зардал гаргах юм бэ гэдгээ бодох ёстой.

Тэрнээс өнөөдөр дэлхий нийтээрээ ийм хандлагатай байна гэж хошуурдаг зүйл рүү орох юм бол магадгүй бид нар нэг өдөр дааж давахгүй өрөнд орох эрсдэл үүсэхийг ч үгүйсгэхгүй. Тийм учраас энэ талаасаа харж эдийн засгийн агуулгаар нь хандахын тулд энэ яамд хоорондын ажлын уялдаа холбоог хангах тал дээр Байнгын хороо хэрвээ эрх зүйн үндэслэл нь байдаг бол албан бичиг явуулах ёстой юм уу ямар байдлаар хандах ёстой юм. Энэ дээр тодорхой шаардлага өгөх нь зөв болов уу гэж бодож байна Засгийн газар дээр.

ТХГН-ийн тухай хуулийг өргөн барьж байгаа юм байна. Энд талархалтай хандаж байна. нэгэнт хуулийн асуудал орж ирэх гэж байгаа үед одоо төсөлтэй танилцаагүй байгаа учраас тодорхой зүйлийг ярьж ярих ийм боломжгүй байна. Тэгэхээр өнөөдөр манай Хөвсгөл аймгийн нэг сум жишээлбэл жишээ аваад л хэлэхэд 98 хувь нь ТХГН болчихсон. Сумын нийт нутаг дэвсгэрийн ерөөсөө хоёрхон хувь дээр нь ард иргэд амьдардаг. Газар тариалан эрхлэх боломж байхгүй, МАА гээд байх юм байхгүй байгаа нь ерөөсөө ойн нөөц. Гэтэл түүнийгээ ашиглах, цэвэрлэх, хадгалах, хамгаалах энэ эрх зүйн харилцаанд орох боломж нь иргэдэд байхгүй. Хороогоо засаж чаддаггүй яйжгий сайжгий хороотой. Тэндээс мод авчих юм бол маш их хэмжээний нөхөн төлбөр, торгууль, ял шийтгэл авах хэмжээний хууль эрх зүйн орчинтой. Үнэхээр тусгайлаад хамгаалаад байгаа юм уу гэхээр хамгаалаад байгаа юм алга. Дундуур нь явахаар сэтгэл өвдмөөр. Баахан унасан хожуул, холцорсон мод, хог хаягдал болчихсон ийм түвшинд л манай ой байна.

Тийм учраас энэ ТХГН-ийн тухай хуулийн энэ өөрчлөлт найруулга дээрээ та бүхэн маань ялангуяа энэ ТХГН-т амьдарч байгаа ард иргэдийн саналыг маш их сайн тусгаж ажиллах дээр анхаарч өгөөрэй гэж хүсмээр байна. Нөгөө талд энэ тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүдийн зарим эрхийг энэ орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагууд руу шилжүүлдэг тэд нар гүйцэтгэлд нь хяналт тавьдаг, энэ дээр анхаардаг, сэтгэл гаргадаг ийм механизм дутаг даж байна уу гэж харагдаж байгаа юм гүйцэтгэл дээр.

Тэгэхээр энэ тал дээр бас цаашдаа эрх зүйн өөрчлөлт хийх тал дээр анхаарч ажиллаарай гэж хэлье. Ингээд амжилт хүсье ээ та бүхэнд.

С.Ганбаатар: Үүрийнтуяа гишүүн үг хэллээ. Золжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Золжаргал: Ямарваа нэг тулгамдсан чухал асуудал дээр шийдэхийн тулд ер нь хажуугаар нь заавал нэг зувчуулах завших тийм юмнууд гараад байдаг. Тэгээд уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны чиглэлээр маш их мөнгө үр ашиггүй зарцуулагдаж байгаад ер нь олон жил ажиглаад санаа зовж яваа. Байгаль орчны сайд энэ төсөл хөтөлбөрүүд дээр үр ашгийг нь анхаарал хандуулах гээд яг энэ асуудлыг нь олж ажиглачхаад баг гаргаад ажиллаж байгаа юм байна. Тэгээд би Энэ бол их зүйтэй алхам юм болов уу.

Хоёрдугаарт нь энэ хэлэлцүүлэг аж үйлдвэр дээр энийг дуудаж хэлэлцэх нь их зөв байна аа. Үнэхээр тэр уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах эх үүсвэрийг Монгол Улс аж үйлдвэржилтээ явуулахдаа яаж хүлэмжийн хийн ялгарал багатай байх вэ гэдэг шийдлийг гаргаж ирээд нэвтрүүлэхэд ашиглах эсвэл манайд тулгамдчихаад байгаа цөлжилт усгүй болчхоод энэ бэлчээр яг ийм юмнуудтай тулган түлхүү ашигламаар байгаа юм. Тэгээд түрүүн бүгд л хэллээ. Би нэг товчхон дахиад хэлчихье ээ. Одоо энэ төслүүд дотор ингээд хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтийн дасан зохицох чадварыг нэмэгдүүлэх гээд ихэвчлэн сургалт 78 тэрбум төгрөг, унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь гээд 27 тэрбум төгрөг. 27 тэрбум төгрөгөөс 1.7 нь техник тоног төхөөрөмж бусад нь ингээд чадавхыг сайжруулах ухааруулах энэ тэр гээд. Бичил алтны уурхайн талаар мэдээлэл түгээх гэх мэт 40 тэрбум төгрөг. 40-өөс 1 тэрбум нь тоног төхөөрөмж. Эко системийг хадгалах хамгаалахад нь хувь нэмэр оруулах нь 67 тэрбум төгрөг. Шинэлэг тогтвортой ландшафтын түвшний менежментийг хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх. АХБ-ны зээлийн 130 тэрбум энэ болохоор баримт бичгийн төсөл 2-ыг боловсруулсан, 22 удаа сургалт хийсэн. Өвлөгдөн үлдэх газар нутаг 51 тэрбум. Шийдлүүдээр дамжин иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Тэгэхээр зэрэг юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр 1 дүгээрт энэ гадаадын зээл бүр ойлгомжтой. Монгол Улс төлнө. Туслалцаа буцалтгүй туслалцаа ч гэсэндээ олон улсын нийгэмлэгээс бид энэ буцалтгүй тусламжаа хүлээж авч байгаа юм. Хэрвээ Монгол Улс нэг юманд аваагүй бол өөр юманд авах боломж нь байсан буюу боломжийг өртөг гэж нэг юм байх ёстой. Дэмий юманд тусламж авах хэрэггүй, үнэхээр манайд хэрэггүй, зарим нь бүүр нэг их агаарын хамаагүй хамаагүй юм тийм зөвлөгөө өгөөд байдаг шүү дээ. Тийм юм бол бид нар татгалзаж сурмаар байна. Яг хэрэгтэй юмандаа авч ашиглая. Болдог ёстой 5 тэрбумаас дээш чадавх бэхжүүлэхгүй, 10 тэрбумаас дээш сургалт авахгүй гэдэг юм уу ингээд үлдэж байгаа юм нь нэг барьцтай юм үлдмээр байх юм. Эсвэл нэг эрх зүйн бичиг баримт эсвэл нэг зөвлөх үйлчилгээ зураг төсөлтэй үнэ цэнтэй документ, эсвэл нэг тоног төхөөрөмж эсвэл нэг байр байшин ч юм уу. Тэгэхээр ийм мөнгөн хязгаар тавьж болдог юм уу үгүй юу? Тэрийг бас түрүүн санал гараад байсан шүү дээ нэг ийм чиглэл өгөх юм байвал зүйтэй юм уу гээд тиймэрхүү л юм бодогдож байна. Баярлалаа.

Гишүүд асуулт асууж, үг хэллээ.

Би хоёрхон үг хэлээдэхье дээ. Энэ чухал асуудал энэ дээр тэгээд ажлын хэсгээ санаачилж би ахлах хүсэлтэй байгаа. Ингээд ахлаад ажиллана. Ганцхан

Байгаль орчны яам биш аж үйлдвэржилттэй холбоотой бусад яамдууд дээр хэрэгжиж байгаа төслүүд зээл тусламжууд, төслүүд хөтөлбөрүүд мөн хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин дээр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд дээр бид энэ сонсголудаа хийгээд тэгээд ажлын хэсгээ байгуулна. Хяналтын хяналтын ажлын хэсэг байгуулна. Үр дүн та нар зүгээр энэ дээр харахад байна шүү дээ ингээд 56.2 сая ам.доллараар бэлэн бус хэлбэрийн хамтарсан санхүүжилтийг ингээд өгсөн. 2024 оны 9 сар. Ингээд 13.3 сая долларыг санхүү зарцуулалт хийгдээд байна. Тэгээд төслийн хүрээнд бол судалгаа тайлан 25, боловсруулсан хуулийн төсөл 5. Бид чинь гаднынхнаар хуулийн төслөө боловсруулна шүү дээ. Тэр ч дүүрсэн хэрэг. Бүх шатны бодлогын баримт бичгийн төсөл 55, бодлогын баримт бичгүүдийг ер нь тэгээд эд нар боловсруулдаг юм байна. Ингээд 86 сургалт. Ингээд цаашаа хуудас явах юм бол дандаа л сургалт, баримт бичиг, судалгаа.

Тэгэхээр танай гэрт нэг хүн орж ирээд л гэнэт хашааг чинь хадаад л гадаа гудамны чинь хогийг чинь шүүрдээд л эхэлбэл тэр гэрийн эзэн байх хэрэг байна уу үгүй юу? Тэгээд л нэг эмэгтэй орж ирээд л аяга тавгийг чинь угаагаад л хоол хийгээд л эхэлбэл бас нэг хүний дотор муухай оргиод л явчихна даа. Энэ чинь ерөөсөө улс орны тусгаар тогтнолын асуудал шүү дээ. Маш олон олон улсын төсөл хөтөлбөрүүд спекуляц болчихсон байгаа. Ганцхан Монголд би зориулж ярьсангүй, өөр орнууд дээр. Тэгээд тэр Филиппиний нэг улс төрчийн хэлсэн үгийг л би зүгээр энэ дээр нэг хэлээдэхье. Манай оронд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүд гээд ингээд баахан юм ярьж байснаа ерөөсөө л хулгайч хүн, луйварчин хүн орж ирээд баахан цаас үйлдвэрлээд өөрсдийнх нь нэр дээр баахан өрийн бичилт бичээд аваад гарахдаа эвий дээ ойлгосон ч гэсэндээ намайг өрөвдөж дуугүй байна даа гэж боддоггүй гэж байгаа юм шүү дээ. Тэнэгүүдийг сайхан маллалаа даа гэж гардаг гэнэ лээ. Филиппиний улс төрчийнх нь баримттай юм ярьж байна шүү энэ чинь. Ийм байдал манайд л лав байхгүй. Би итгэж байна. Манайх хажууд нь ухаантай шүү дээ. Тэгэхээр Субашид дээр байдаг өрөвдөөд өрхийг нь бүтээх гээд, эвийлээд эдийг нь авах гэж орж ирлээ гэж би хэлэхгүй ч гэсэндээ энэ дээр бид хатуу хяналттай байна аа. Маш хатуу хяналттай, маш зөв цэгцэд нь оруулна. 6 сар дөнгөж ажил авсан улсуудтай юм ярихгүй. Өмнөх 2022, 2021, 2020 онд хэрэгжсэн төслүүд дээр ч гэсэн бид хяналтаа тавина. Дууссан гэж бид үзэхгүй ээ.

Ингээд ийм байр суурьтай байна. Ингээд гишүүд маш идэвхтэй оролцлоо. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, хүнд үйлдвэр холбогдох тэр мэдээллүүдийг дараагийн ирэх 7 хоногт сонсоно. Ирэх 7 хоногт юунд оруулна. Та бүхэн маань идэвхтэй сонсголд оролцоод, ажлын хэсэгт идэвхтэй оролцоно гэж би итгэж байна аа. Идэвхтэй оролцсон та гишүүддээ баярлалаа.

Өнөөдрийн хуралдаан хамтарсан хуралдаан хаасныг мэдэгдье.

Б.Бейсен: Одоо энэ үргэлжлүүлээд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хуралдана. Тийм учраас Байнгын хорооны гишүүд бэлэн байж байгаарай гэдгээ хэлье.

С.Ганбаатар: Би нэг зар өгөөдөх үү. Манай Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо энэ эзэн Чингис хаан танхимд хуралдахаар хүлээж байгаа юм байна. Ороод ирцээ бүрдүүлээд үйлдвэр технологийн паркийн ажлын хэсгээ яаралтай байгуулна шүү. Та бүхэн маань идэвхтэй оролцоорой.

18.20 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА